

Message




ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭЛ БОДЛОО  
ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙГ

## **ЦАХИМ ХУУДСЫГ ХААХ**

ЗАМААР ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН





НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

**ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ  
ЭРХИЙГ ЦАХИМ ХУУДСЫГ ХААХ ЗАМААР  
ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ,  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2024 он

ННА 67  
ДАА 340  
Ц-251

## **ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙГ ЦАХИМ ХУУДСЫГ ХААХ ЗАМААР ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **Гүйцэтгэгч:**

“Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН

### **Судалгааны багийн бүрэлдэхүүн:**

Судалгааны багийн ахлагч: Б.Баялагмаа (LL.M), Э.Энхцэцэг (LL.M)

Судлаач: Б.Анирмаа, өмгөөлөгч, хуульч, Б.Наранцэцэг, өмгөөлөгч, хуульч

Судалгааны туслах: Г.Амаржаргал, Б.Билэгдэмбэрэл, О.Маралмаа, С.Маралмаа

### **Хянан тохиолдуулсан:**

Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг

Нээлттэй Нийгэм Форумын хөтөлбөрийн зохицуулагч О.Сэлэнгэ

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14240

Утас: 76113207

Веб: <http://www.forum.mn>

И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Энэхүү судалгааны тайлан нь уг тайланг хийсэн судлаачийн үзэл бодол, байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.

ISBN 978-9919-9136-7-0

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	4
ӨМНӨХ ҮГ .....	5
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ .....	7
<b>НЭГ. ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ .....</b>	<b>18</b>
1.1. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх тухай ойлголт ба онцлог.....	18
1.1.1 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй хэлбэрүүд .....	20
1.1.2 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй субъектийг тодорхойлох..	21
1.2. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хууль зүйн баталгаа, хамгаалалт .....	23
1.3 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээний хууль зүйн үндэслэл .....	29
1.3.1 Монгол Улсын эрх зүйн орчин .....	29
1.3.2 Европын Холбооны зохицуулалт .....	37
1.3.3 Эстони Улсын зохицуулалт .....	39
1.3.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зохицуулалт.....	42
1.3.5 АНУ-ын холбооны болон мужийн эрх зүйн зохицуулалт .....	43
1.3.6 Олон нийтийн сүлжээний платформын хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ (Community Standards).....	46
1.4 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээг авах эрх бүхий субъектүүд .....	49
<b>ХОЁР. ЦАХИМ ХУУДСЫГ ХААХ ЗАМААР ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАСАН ШИЙДВЭРҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....</b>	<b>52</b>
2.1. Монгол Улс .....	52
2.1.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим хуудсыг хааж, хандалтыг хязгаарлаж буй тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл .....	52
2.1.2 Сонгуулийн сурталчилгааны үеэр цахим хуудсыг хаасан тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл .....	56

2.2. Европын Холбоо: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим хуудсыг хязгаарлаж буй тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл ....	58
2.3 АНУ: Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүнийг хязгаарласан тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл.....	62
2.4 Эстони Улс: Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, түүнийг хязгаарласан тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл ....	67
2.5 Канад Улс: Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл.....	75
<b>ДҮГНЭЛТ, САНАЛ.....</b>	<b>77</b>
<b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....</b>	<b>83</b>

## **ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ**

НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй түгээмэл хэлбэрүүд .	20
Хүснэгт 2. Европын Холбооны зохицуулалт .....	38
Хүснэгт 3. Фейсбүүкийн журмаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан байдал.....	47

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад баримтлах зарчмууд .....	31
Зураг 2. Хууль бус контентын ангилал.....	34

## ӨМНӨХ ҮГ

Туурга тусгаар Монголчууд Бүгд Найрамдах Улсаа тунхаглаж, анхдугаар Үндсэн хуулиа баталсны 100 жилийн ой 2024 оны 11 дүгээр сарын 26-нд тохиож байна. Энэхүү түүхэн тэмдэглэлт өдрийг угтан иргэний ардчилсан нийгмийн суурь болох үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг цахим орчинд хэрхэн хангаж буй талаарх судалгааг Танд толилуулж буйдаа таатай байна.

Нээлттэй нийгэм нь мэдээллийн чөлөөт урсгал, олон ургалч үзэл, мэтгэлцээн, шүүмжлэл өрнөх иргэний орон зайгүйгээр оршин тогтнох боломжгүй. Мэдээллийн технологийн хөгжилтэй уялдан иргэний орон зайн томоохон хэсгийг цахим орчин бүрдүүлэх болов. Үүнтэй холбоотой өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд дэлхийн улс орнууд цахим орчинд хүний эрхийг хангах асуудалд анхаарч хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулах, мэдээллийн экосистемийг хоруу контентоос хамгаалахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж шинэчлэл хийх нь эрчимжиж ирлээ. Монгол Улс ч үүнээс хоцорсонгүй. Гэвч шинэ тутам харилцааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй зэрэгцэн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг үндэслэлгүй хязгаарлах асуудал мөн шүүмжлэл дагуулах болов.

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах тодорхой нөхцөл, шаардлагууд байж болохыг дурдаж, дэлгэрэнгүй тайлбарласан байх боловч төрөөс хэтийдсэн хяналт тавьж, зохицуулалт хийх нь үндсэн эрхийг боомилох эрсдэлтэйг мөн анхааруулдаг. Та бүхэнд толилуулж буй энэ судалгаанд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж олон улсын эрх зүйн баримт бичгүүдтэй хэрхэн нийцэж буй талаарх дүн шинжилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад үүсэж буй асуудлууд, Европын холбоо болон бусад улсад ижил төстэй харилцааг хэрхэн зохицуулж, холбогдох маргааныг шүүхээр шийдвэрлэж байгаа талаарх мэдээллийг харьцуулан танилцуулжээ. Түүнчлэн дотоодын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн тодорхой санал зөвлөмж тусгасан нь энэ хүрээний хууль тогтоомжийг хүний эрхийн стандартуудад нийцүүлэн сайжруулахад тус нэмэр болно гэж найдаж байна.

Судалгааг амжилттай гүйцэтгэсэн Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН-ийн судалгааны баг, судалгааг ахалсан хуульч Б.Баялагмаа (LL.M), Э.Энхцэцэг (LL.M) нар болон судалгааны багийн гишүүд өмгөөлөгч, хуульч Б.Анирмаа, Б.Наранцэцэг, судалгааны туслах Г.Амаржаргал, Б.Билэгдэмбэрэл, О.Маралмаа, С.Маралмаа нарт талархал илэрхийлье. Судалгааны тайланд мэргэжлийн шүүмж өгч дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Хууль зүйн ухааны доктор Г.Нарантуяа, “Глоб интернэшнл” ТББ-ын хуульч Б.Пүрэвсүрэн (LL.M), ННФ-ын эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа (LL.M), Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэг (LL.M) нарт мөн талархаж буйгаа үүгээр уламжилъя.

*Нээлттэй Нийгэм Форумын гүйцэтгэх захирал  
П.Эрдэнэжаргал*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-д иргэний ардчилсан нийгмийн тулгуур болох “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх” үндсэн эрхийг заан баталгаажуулжээ.

Техник, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед интернэт орчин, цахим хуудас, мэдээллийн платформоор дамжуулан мэдээлэл түгээх, нийтлэл, бичвэр оруулах зэргээр үзэл бодлоо илэрхийлэх боломж, хэлбэр өргөжин нэмэгдсээр байна. Тиймээс цахим орчны онцлогт нийцсэн байдлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хамгаалалт, баталгааг хангах шаардлага үүсэж байна.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 тоот тайлбарын 12-т үзэл бодлоо илэрхийлэх арга хэлбэр, хэрэгсэлд “...цахим болон интернэтэд суурилсан үзэл бодлоо илэрхийлэх арга хэмжээ ... хамаарна” гэж тодотгон, 15-т “интернэт, ухаалаг гар утсанд суурилсан мэдээлэл түгээх систем зэрэг ... улс орнууд эдгээр шинэ төрлийн хэвлэл мэдээлэл, мэдээллийн хараат бус байдлыг бэхжүүлэх, хувь хүмүүс хэрэглэх боломжийг бүрдүүлэх талаар зайлшгүй бүх арга хэмжээг авбал зохино” гэж тайлбарласан.<sup>1</sup> Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2020 онд “Цахим орчинд халдашгүй байх эрхийг хэрэгжүүлэх” талаарх тогтоол<sup>2</sup> баталж, улс орнуудыг “... цахим харилцаанд халдашгүй байх эрхийг хүндэтгэн хамгаалах, уг эрхийн зөрчлийг зогсоох шаардлагатай арга хэмжээ авах, дотоодын холбогдох хууль тогтоомжийг олон Улсын хүний эрхийн гэрээний дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэн уялдуулах, хэрэгжүүлэх зэргээр ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх”-ийг уриалжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд хүн бүр чөлөөтэй эдлэхээр баталгаажуулж, түүнийг эдлэх баталгааг

---

<sup>1</sup> United Nations, Human Rights Committee, General comment No.34, Article 19: Freedoms of opinion and expression, International Covenant on Civil and Political Rights, 2011. <https://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>

<sup>2</sup> United Nations, General Assembly, Resolution adopted on December 16, 2020, No.75/176, “The right to privacy in the digital age” <https://digitallibrary.un.org/record/3896430?ln=en&v=pdf#files>.



улс орнууд хангах үүрэгтэй болохыг тусгасан. Харин нийтийн эрх ашиг, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах хүрээнд уг үндсэн эрхийг зөвхөн хуулиар хязгаарлах нөхцөлийг тодорхой дурдсан байдаг. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах нэг хэлбэр нь хувийн цахим хаягийг хаах, хандалтыг хязгаарлах, цахим хуудасны хандалтыг хязгаарлах, хаах бөгөөд ийм хязгаарлалт тавихад дээр дурдсан зарчим үйлчлэх учиртай. Засгийн газар, түүний харьяа болон холбогдох байгууллагуудын интернэтийн контентыг зохицуулах аргууд (цахим хуудас, харилцааны хэрэгслийг хаах) нь олон улсын хэм хэмжээнд буюу ИБУТЭОУП-ын 17 болон 19 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын арга хэмжээнд нийцдэггүй<sup>3</sup> гэж үздэг.

Монгол Улсад домэйн нэр ашиглах, цахим хуудас хөтлөх, интернэтийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд Харилцаа холбооны зохицуулах хороо хяналт тавьж ажилладаг. Холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн дүгнэлт, шийдвэрийг үндэслэн зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтад оруулж, интернэтийн үйлчилгээнд Монгол Улсаас хандах хязгаарлалт хийх арга хэмжээ авах замаар хяналтаа хэрэгжүүлдэг байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээлснээр "... тус зохицуулалт 2013 оноос хойш хэрэгжиж байгаа бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд 6873 домэйн нэрийг зөрчилтэй жагсаалтад оруулж, хаасан" гэжээ.<sup>4</sup>

Цахим хуудас, мэдээллийн хэрэгслийг хаах арга хэмжээг, 1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дах мөрдөн шалгах ажиллагааны явцад; 2) Сонгуулийн үеэр цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах үед хяналт хэрэгжүүлэх зэрэг тохиолдолд холбогдох зохицуулалтын хүрээнд явуулж байна. Тодруулбал,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 22.1.3-т мөрдөн шалгах ажиллагаагаар "... харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах ..." ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна гэж заасан. Тухайлбал, энэ заалтыг үндэслэн цагдаагийн байгууллагаас прокурорын зөвшөөрөлтэйгөөр [zarig.mn](http://zarig.mn) цахим хуудас, пэйж хуудас, "Unurtsetseg Naran" фейсбүүк хаягт Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах, харилцаа холбооны сүлжээнд

<sup>3</sup> United Nations, Human Rights Committee., General comment No.34, Article 19: Freedoms of opinion and expression, International Covenant on Civil and Political Rights, 2011. <https://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>

<sup>4</sup> Харилцаа холбооны зохицуулах хорооноос [zarig.mn](http://zarig.mn) цахим хуудсыг хаасантай холбогдуулан хийсэн мэдэгдэл, 2023.12.02. <https://news.mn/r/2689489/>

нэвтрэх боломжийг хязгаарлах технологийн арга хэмжээ авахыг Харилцаа холбооны зохицуулах хороонд даалгаж, Харилцаа холбооны зохицуулах хороо тус шийдвэрийг үндэслэн зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтад оруулсан<sup>5</sup>.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа хийх зохицуулалтыг хуульчилж, сонгуулийн сурталчилгаанд бүртгэлгүй цахим хуудас ашиглах,<sup>6</sup> нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээлэл нийтэд түгээх<sup>7</sup> зөрчил гаргасан тохиолдолд Харилцаа холбооны зохицуулах хороо тагнуул, цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн цахим хуудсыг хаах арга хэмжээ авахаар зохицуулсан.

Дээрх зохицуулалтуудын хүрээнд албадлагын чанартай хариуцлага ногдуулсан арга хэмжээ хэрэгжүүлэх шийдвэрийг шүүхээс гаргадаг байх, холбогдох этгээд эрх нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг хэрэгжүүлэх баталгаа, нөхцөлийг хуулиар тогтоож, бүрдүүлээгүй байна. Үүний улмаас цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах, цаашлаад уг эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрсдэлийг бий болгох үр дагавар үүсжээ. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц .. хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж зааснаар цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх үүргээ Монгол Улс зөрчиж уг эрхийг хязгаарлах зохистой арга хэмжээг олон улсын жишиг, хандлагад нийцүүлэн хэрэгжүүлээгүй гэх шүүмжлэлийг дэвшүүлж байна. Судалгааны багийн зүгээс Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид цахим хуудсыг хаах замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээг зохицуулсан байдал, түүнийг практик дээр хэрэгжүүлэх явцад тохиолдож буй бодит тохиолдлууд буюу кейст дүн шинжилгээ хийх, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон Улсын гэрээ хэлэлцээрт нийцэж буй эсэхийг шинжлэх, бусад улсуудын туршлага, зохицуулалтыг харьцуулах замаар судалж, холбогдох дүгнэлт саналыг хүргүүлж байна.

<sup>5</sup> Харилцаа холбооны зохицуулах хорооноос zarig.mn цахим хуудсыг хаасантай холбогдуулан хийсэн мэдэгдэл, 2023.12.02. <https://crc.gov.mn/articles/medegdel-2023-12-02/mn>

<sup>6</sup> Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47.7 дугаар зүйл.

<sup>7</sup> Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 35.3 дугаар зүйл. Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно.

## Судалгааны хүрээ, арга зүй

Судалгааг гүйцэтгэхэд эрх зүйн хэм хэмжээний норматив арга, харьцуулалтын арга, тохиолдолд дүн шинжилгээ хийх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргыг дараах байдлаар ашигласан.

Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, Контентын үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам, бусад холбогдох хууль тогтоомжид цахим хуудсыг хаах, хандах эрхийг хязгаарлах талаар зохицуулсан байдлыг Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нийцэж буй эсэхийг шинжлэн судалсан. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх замаар “цахим хуудас”-ыг хааж буй тохиолдолд дүн шинжилгээг хийж гүйцэтгэлээ.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг цахим хуудсыг хаах замаар хязгаарлах зохицуулалттай, уг хязгаарлалтыг хэрэгжүүлэх явцад үүссэн үндсэн эрхийн зөрчлийн талаар шийдвэрлэсэн шүүхийн жишиг практик зэргийг харгалзан Европын Холбоо, АНУ, Эстони, Канад улсуудыг сонгон авч, эрх зүйн зохицуулалтын болон шүүхийн практикийг харьцуулан судалсан болно.

## Судалгааны бүтэц

Тус судалгаа нь (1) Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хууль зүйн үндэслэл (2) Цахим хуудсыг хаах замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээ гэсэн хоёр бүлгээс бүрдэнэ.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар баталгаажуулсан байдал болон цахим хуудсыг хаах, хандах эрхийг хязгаарлах хуулийн зохицуулалтын судалгааг Монгол Улс, Европын Холбоо, Эстони Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Америкийн Нэгдсэн Улсын хуулиуд болон Фейсбүүк платформын хэрэглэгчдийн мөрдөх хэм хэмжээ буюу Community standart-т үндэслэн хийж гүйцэтгэсэн.

Хоёрдугаарт бүлэгт, Монгол Улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад цахим хуудсыг хаах, хандалтыг хязгаарлаж буй тохиолдол, сонгуулийн сурталчилгааны үеэр цахим хуудсыг хаасан тохиолдолд хууль тогтоомжийг хэрэглэж буй байдалд дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн Европын Холбооны

Хүний эрхийн шүүхийн шийдвэрлэсэн AHMET YILDIRIM v. TURKEY хэрэг, KABLIS v. RUSSIA хэрэг, Эстони Улсын v. Romeo KALDA-ийн хэрэг<sup>8</sup>, АНУ-ын Холбооны Дээд шүүх болон мужийн дээд шүүхүүдээс шийдвэрлэсэн Packingham v. North Carolina<sup>9</sup> хэрэг, Mills v. Alabama<sup>10</sup> хэрэг, Reno v. Am.Civil Liberties Union<sup>11</sup> хэрэг, Эстони Улсын шүүхээс шийдвэрлэсэн Tarmo Vahter v. Sulev Vedler хэрэг<sup>12</sup>, Канад Улсын шүүхийн шийдвэрлэсэн “Canadian Constitution Foundation v. Attorney General of Canada”-ийн хэрэг<sup>13</sup>-н шийдвэрүүдийг судалж, “цахим хуудсыг хаах, хандалтыг хязгаарлах” арга хэмжээний хамрах хүрээ, агуулгыг тодорхойлсон байдалд дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны хүрээнд хийгдсэн дүн шинжилгээнүүдэд үндэслэн үндэсний хууль тогтоомжид тулгамдаж буй асуудлууд, түүний хэрэглэж буй байдлыг боловсронгуй болгох шаардлагыг тодорхойлсон судалгааны үр дүнг дараах байдлаар гаргасан.

## Үр дүн

Онлайн болон оффлайн орчинд, эсхүл түгээж буй арга хэлбэрээс үл хамаарч Үндсэн хуулиар баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх нь төрийн хүлээх үүрэг мөн. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 50/15 тоот “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө”-ний тухай тогтоолд<sup>14</sup> гишүүн улс орон бүр Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын<sup>15</sup> 19 дүгээр зүйлд дурдагдаагүй шаардлагад үндэслэн шинэ төрлийн хязгаарлалт тогтоохоос татгалзаж, одоо байгаа хязгаарлалтуудыг цуцлах арга хэмжээ авахыг уриалсан нь манай улсад мөн хамааралтай байна.

<sup>8</sup> European Court of Human Rights: CASE OF KALDA v. ESTONIA <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-160270> Сүүлд хандсан огноо: 2024.07.17

<sup>9</sup> [https://www.supremecourt.gov/opinions/16pdf/15-1194\\_08l1.pdf](https://www.supremecourt.gov/opinions/16pdf/15-1194_08l1.pdf)

<sup>10</sup> <https://supreme.justia.com/cases/federal/us/384/214/>

<sup>11</sup> <https://supreme.justia.com/cases/federal/us/521/844/>

<sup>12</sup> Эстони Улсын Дээд шүүхийн тогтоол (2023.01.31), <https://www.riigiteataja.ee/kohtulahendid/fail.html?fid=331402045> Сүүлд хандсан огноо: 2024.07.16

<sup>13</sup> Canadian Constitution Foundation v. Attorney General of Canada., <https://globalfreedomofexpression.columbia.edu/cases/canadian-constitution-foundation-v-attorney-general-of-canada/> Сүүлд хандсан огноо: 2024.07.24

<sup>14</sup> Freedom of opinion and expression : resolution adopted by the Human Rights Council on 8 July 2022., <https://digitalibrary.un.org/record/3985686?ln=ru&v=pdf.> Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>15</sup> Монгол Улс 1968 оны 01 дүгээр сарын 05-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг баталгаажуулсан, тодорхойлсон тухайлсан эрх зүйн хэм хэмжээ одоогоор байхгүй. Энэ нөхцөл байдлыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбоотой үндэсний зарим хууль тогтоомж, зохицуулалт, дүрэм журмыг боловсронгуй бус, олон улсын гэрээ, конвенцод нийцээгүй тул үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилт хангалтгүй болохыг Хүний эрхийн үндэсний комиссоос дүгнэсэн байна.<sup>16</sup>

**Цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хуулиас гадна журмаар хязгаарлаж буй байдал:** Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах харилцааг зохицуулсан эрх зүйн актыг захиргааны байгууллагаас батлан хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бий болгосон нь гагцхүү хуульд заасан үндэслэлээр хүний эрхийг хязгаарлах зарчимд нийцэхгүй байна. Тухайлбал, (1) Монгол Улсын Засгийн газрын 2013 оны тогтоолоор<sup>17</sup> “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийг бий болгож, домэйн нэр олголтыг зохион байгуулах болон мэдээ, мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим хуудсанд тавигдах шаардлагыг тодорхойлж, зохицуулах журмыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн, боловсруулж, мөрдүүлэх арга хэмжээг Харилцаа холбооны зохицуулах хороонд даалгасан. Мөн (2) Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1.6 дах хэсэгт зааснаар домэйн нэр эзэмшигч нь тус журмаар хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд домэйн нэрийн хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах нөхцөлийг журамласан.

**Цахим хуудсыг хаах, хандалтыг хязгаарлах хуулийн зохицуулалтын тодорхойгүй байдлын үр дагавар:** Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомжийн зохицуулалтыг өргөтгөн тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дур мэдэн хязгаарлах шийдвэр гаргах эрсдэлийг үүсгэсэн. Тухайлбал, Прокуророос “Яллагдагч \*\*\*-ийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн \*\*\* гэх фейсбүүк хаяг, \*\*\*нэртэй веб-сайтаар дамжуулан хэргийн талаар мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулж, live бичлэг хийх замаар мөрдөн шалгах байгууллагад нөлөөлөх зорилгоор иргэд олон нийтийг уриалан, турхирсан үйл ажиллагааг зохион байгуулж, мөрдөн

<sup>16</sup> ХЭҮК-ын Монгол улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дах илтгэл., 2018., хуудас 208., <https://lib4u.net/ebook/?id=80&lib=nhrс> Сүүлд хандсан огноо: 2024.06.25.

<sup>17</sup> МУЗГ-ын 2013.01.05-ны өдрийн №1 дүгээр тогтоол., Цахим хуудас дах сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай., <https://legalinfo.mn/mn/detail/8939>.

шалгах ажиллагаанд саад учруулах нөхцөл байдал бий болгож байгаа тул тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх” саналыг Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан тохиолдол байна. Тус шүүхээс прокурорын саналыг хянаад, хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх гэсэн таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс авах боломжгүй гэж дүгнэж, прокурорын саналыг хүлээн авахаас татгалзсан. Тус хуульд заасан тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ нь “төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэх” гэх хүрээгээр хязгаарлагддаг. Гэвч тус зохицуулалтыг “цахим орчинд хандах эрх”-ийг хязгаарлахад хамаарахаар өргөтгөж тайлбарлаж байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах сөрөг үр дагавартай.

Үүнээс гадна, Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11 дэх хэсэгт заасныг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дах олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдөр хүртэл авч болно. Тус хуулиар хандалтыг хязгаарлах арга хэмжээний хамрах хүрээг тодорхойлоогүйн улмаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлах арга хэмжээг хэт өргөн хүрээнд зохион байгуулах нөхцөл бүрджээ.

Мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дах хэсэгт нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дах олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглосон. Тус хуульд “мэдсээр байж” тараах, “мэдээгүй тараах” талаар ялгаж тодорхойлоогүй нь хуулийн зохицуулалт нь тодорхой байх, зорилгодоо нийцсэн, пропорциональ байх зарчмуудад нийцээгүй.

**Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд гомдлын журмаар шүүхээр хянуулах боломжгүй байдал:** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан арга хэмжээг авсан нөхцөлд үндсэн эрхийг зөрчсөн талаарх гомдлыг шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломжгүй байна. Тухайлбал, Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар Мөрдөгч нь харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулдаг. Тус хуулийн зохицуулалтад үндэслэн Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн прокурорын зөвшөөрлөөр сэтгүүлч \*\*\*-г олон нийтийг төөрөгдүүлсэн илт худал мэдээллүүдийг олон нийтийн цахим сүлжээ буюу фэйсбүүк орчинд тараасан гэмт хэрэгтэй холбогдуулан \*\*\* нэртэй фэйсбүүк пэйж хуудас, \*\*\* вэбсайтын Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээг авахыг Харилцаа холбооны зохицуулах хороонд даалгаж, уг арга хэмжээг авсан.

Дээр дурдсанаар вэбсайт болон олон нийтийн сүлжээний платформд хаяг, хуудас нээж, тухайн вэбсайт, хаяг, хуудсаар дамжуулан мэдээ, мэдээлэл түгээж, нийтэлж буй нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй хэлбэр тул хандалтыг хязгаарласан арга хэмжээ нь зөвхөн тухайн хувь хүний эрхээс гадна, мэдээллийн вэбсайтаар дамжуулан мэдээлэл хүлээн авах бусад этгээдийн эрхийг хязгаарлах үр дагавартай.

Үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төрд халдаж, худал мэдээлэл тарааж, төөрөгдүүлсэн бол Эрүүгийн болон Иргэний хуульд заасны дагуу хариуцлага хүлээх, хохирол барагдуулах замаар уг эрх чөлөөг хязгаартай эдлэх нөхцөлийг хуульчилдаг нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3-т “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж заасанд нийцнэ. Харин үзэл бодлоо илэрхийлсэн нь хууль бус буюу гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгах ажиллагааны явцад эрх чөлөөг нь хязгаарлах эрхийг прокурорт олгосон хуулийн дээрх зохицуулалт нь цахим орчинд ч үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх хууль зүйн баталгааг хангах тухай Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасанд нийцэхгүй байна.

Цаашлаад прокурорын зөвшөөрөл олгосон энэ үйлдэлд дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй<sup>18</sup> боловч үндсэн эрхийг хязгаарласан гэх үндэслэлээр хууль тайлбарлах эрх бүхий “шүүх”-д гомдол гаргах боломжгүй. Учир нь Эрүүгийн

<sup>18</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйлд заасан шүүхэд гомдол гаргах үндэслэлд хамаарахгүй. Ийнхүү үндсэн эрхээ хязгаарлагдаж буйг шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...” эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсэж байна.

**Онлайн болон оффлайн орчинд “үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө”-г ялгамжтай хэрэгжүүлэх хуулийг баталсан байдал:** Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр цахим орчин дахь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зохисгүй, доромжилсон, ялгаварлан гадуурхсан агуулга бүхий үг хэллэг, зөрчилтэй контентыг хязгаарлах, хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, садар самуун, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилготой “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай” хуулийг баталсан. Уг хуулиар нийтийг хамарсан үймээн самуун дэгдсэн тохиолдолд цахим орчинд бүрэн эсхүл хэсэгчилсэн хязгаарлалт тогтоох эрхийг Кибер аюулгүй байдлын зөвлөл хэрэгжүүлэхээр тусгасан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан шинжтэй, олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд нийцээгүй талаар шүүмжлэл дагуулсан.<sup>19</sup>

Дээрх хуулийг батлахдаа “олон нийтийн оролцоог хангаагүй, хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн саналыг аваагүй, үндсэн эрх, чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг батлахдаа хууль дээдлэх ёсны зарчмыг баримталж, ард олон, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагын саналыг авч, хэлэлцүүлэг зохион байгуулж батлах ёстой”<sup>20</sup> гэх үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьж, УИХ-ын хаврын чуулганы 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хүлээн авч хэлэлцээд, хуулийг хүчингүй болгосон нь чухал ач холбогдолтой юм.

<sup>19</sup> Нээлттэй Нийгэм Форум, Хуулийн Шүүмж, Монгол Улсын Нийгмийн Сүлжээний Хууль, Цуврал №41, 2023 оны 3 дугаар сар.

<sup>20</sup> Монцамэ, <https://montsame.mn/mn/read/312089> Сүүлд хандсан: 2024.07.29



## Зөвлөмж

1. Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад үндэслэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг онлайн болон оффлайн орчин гэж ялгалгүйгээр, хэрэгжүүлэх баталгааг хангах нь зүйтэй. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хамаарах харилцааг зохицуулсан тусдаа хууль баталж, мөрдөхөөс илүүтэй одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа оффлайн орчинд дагаж мөрддөг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомж зэрэг бусад хуулиудыг онлайн орчинд дагаж мөрдөх зорилгоор боловсронгуй болгох, цаашлаад хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.
2. Монгол Улсад хууль бус контентын агуулгыг тодорхойлоход хуулиас гадна Домэйн нэр бүртгэх, ашиглах журам, хууль бус зохисгүй контентын агуулгыг дүрэм, журмаар тогтоож байгаа нь “хүний эрхийн хязгаарлалт”-ыг зохицуулах шаардлага, зарчмуудад нийцэхгүй. Тиймээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй хүчин төгөлдөр хууль тогтоомжийг түүвэрлэн судалсны үндсэн дээр онлайн болон оффлайн орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зорилго, шаардлагыг тодорхойлж, түүнийг цахим орчинд нэгэн адил хэрэгжүүлэх нь зүйтэй.
3. Монгол Улсад прокурорын зөвшөөрлөөр аливаа цахим хуудас, хаяг, контентод хандах эрхийг хязгаарлаж, хааж буй тохиолдолд тухайн шийдвэрт шүүхийн журмаар гомдол гаргаж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шүүхээр хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад хамрах хүрээг тодорхойлсон, хязгаарлалтад хамрах субъектэд хандаж, аль хуулийн заалтыг хэрхэн зөрчсөн талаар ойлгомжтой тодорхой тайлбарласан байх шаардлагыг баримтлах нь зүйтэй.
4. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд цахим хуудсыг хязгаарлах, хаах үндэслэлийг өргөн хүрээнд тодорхойлсноос гадна, тухайн тохиолдлыг харгалзан үзэж нарийвчлан зохицуулаагүй байгааг өөрчлөх нь зүйтэй. Тухайлбал, тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасан “гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх” нөхцөлийг зөвхөн гутаан доромжилсон, эсхүл худал мэдээллийг агуулсан, эсхүл аль аль шаардлагыг нэгэн зэрэг хангасан тохиолдолд хэрэглэх зэргээр олон утгаар

ойлгож, хэрэглэгдэхээр байна. Хуулийг хоёрдмол утгаар тайлбарлах боломж нэмэгдэх тусам үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах агуулга өргөн хүрээг хамаарч, улс төрийн зорилгоор хүний эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах эрхийн зөрчлийг үүсгэнэ. Тиймээс хязгаарлалтын агуулгыг нарийвчлан, тухайн тохиолдолд нийцүүлэн хүн бүрд ойлгомжтой байдлаар тодорхойлох шаардлагатай.

5. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан зохицуулалтыг боловсронгуй болгоход үндсэн эрхийг хязгаарлах нөхцөлийг тухайн тохиолдолтой уялдуулан хамгийн бага түвшинд тодорхойлох зарчмыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай.
6. Хуулиар тодорхойлсон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд аливаа улсын дотоодын эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас гадна олон улсад үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн сүлжээний платформуудтай хамтран ажиллах, тухайлсан тохиолдлуудад бие даасан хараат бус нэгжийг байгуулах, эсхүл байгуулагдсан нэгжтэй хамтран ажиллах нь үр дүнтэй байна.

# НЭГ. ЦАХИМ ОРЧИНД ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

## 1.1. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх тухай ойлголт ба онцлог

Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг иргэний нийгэмд суурь шинжтэй бөгөөд чөлөөт, ардчиллын тулгуур үнэт зүйл,<sup>21</sup> хувь хүн бүрийн бие даан амьдрах үндсэн нөхцөлүүдийн нэг гэж үздэг.<sup>22</sup> Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний агуулга нь 2400 гаруй жилийн тэртээх эртний Грекийн нийслэл Афины эрин үеэс оршин тогтнож ирсэн бөгөөд “parrhesia” буюу “зоригтой ярих, чөлөөтэй ярих” гэх утгаар үг хэлэх эрх чөлөөг илэрхийлж байв.<sup>23</sup> Нийгэм, цаг үе хувьсан өөрчлөгдөхийн хэрээр ардчилал, хүний эрх, эрх чөлөөний тухай үзэл санаа түгэн дэлгэрч, ардчиллын тулгуур гэгдэх үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг 1689 онд Английн Парламентаас баталсан “Эрхийн билл”,<sup>24</sup> 1789 оны Францын хувьсгалын үеэр баталсан “Хүний ба Иргэний эрхийн тунхаг”,<sup>25</sup> 1948 онд НҮБ-ээс баталсан “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”<sup>26</sup>,

<sup>21</sup> НҮБ-ын Хүний эрхийн хорооны Benhanj v. Algeria, 1173/2003 дугаартай гомдолд холбогдох 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлт., “...With regard to the alleged violation of article 19, the Committee recalls that the freedoms of information and expression are cornerstones in any free and democratic society...”, [https://www.worldcourts.com/hrc/eng/decisions/2007.07.20\\_Benhadj\\_v\\_Algeria.htm](https://www.worldcourts.com/hrc/eng/decisions/2007.07.20_Benhadj_v_Algeria.htm)., Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

<sup>22</sup> Wolfgang Benedek, Matthias C. Kettmann., “Freedom of expression and the internet”, 2013. p.24 <https://rm.coe.int/prems-167417-gbr-1201-freedom-of-expression-on-internet-web-16x24/1680984eae>. Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

<sup>23</sup> David Konstan., The Two Faces of Parrhesia: Free Speech and Self-Expression in Ancient Greece., 2015. [https://www.researchgate.net/publication/289879205\\_The\\_Two\\_Faces\\_of\\_Parrhesia\\_Free\\_Speech\\_and\\_Self-Expression\\_in\\_Ancient\\_Greece](https://www.researchgate.net/publication/289879205_The_Two_Faces_of_Parrhesia_Free_Speech_and_Self-Expression_in_Ancient_Greece). Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

<sup>24</sup> Bills of Rights, 1689. <https://www.parliament.uk/about/living-heritage/evolutionofparliament/parliamentaryauthority/revolution/collections1/collections-glorious-revolution/billofrights/#:~:text=It%20is%20an%20original%20Act,known%20today%20as%20Parliamentary%20Privilege>. Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

<sup>25</sup> Declaration of Rights of Man and Citizen., 1791., 11. The free communication of ideas and opinions is one of the most precious rights of man. Every citizen can therefore speak, write and print freely, subject to responsibility for the abuse of this freedom in cases as determined by law. <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/csj-sjc/ilp-pji/rev5/index.html#:~:text=Men%20are%20born%20free%20and,security%20and%20resistance%20to%20oppression>. Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

<sup>26</sup> Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал <https://legalinfo.mn/mn/detail/1271>.

ИБУТЭОУП<sup>27</sup> зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдээр жам ёсны эрх гэдгийг баталгаажуулсаар ирсэн.

Технологийн хөгжлийн хурдацтай тохируулж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчмыг уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслээр үл хязгаарлан, цахим орчинд баримтлах хандлага олон улсад дэлгэрсээр байна. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос интернэт, ухаалаг гар утсанд суурилсан мэдээлэл түгээх систем зэрэг технологийн хөгжил нь дэлхий нийтийн харилцаа холбооны мөн чанарыг үлэмж өөрчилсөн бөгөөд үзэл бодол, итгэл үнэмшлийг уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоогүйгээр түгээн солилцох дэлхийн сүлжээ нэгэнт бий болсныг онцолжээ.<sup>28</sup>

Интернэт нь хувь хүмүүс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж, мэдээлэл хүлээн авах, түгээх харилцааны гол хэрэгсэл болсныг олон улсын байгууллагууд 2011 оноос<sup>29</sup> бодлогын хүрээнд хүлээн зөвшөөрч, цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах асуудлыг чухалчилж ирэв. Интернэт хэрэглэгчдийн тоо 2024 оны 4 дүгээр сарын байдлаар 5.44 тэрбум буюу дэлхийн нийт хүн амын 67.1 хувийг<sup>30</sup> эзэлж буй нь цахим орчин нийгмийн харилцаанд маш өргөн хүрээг хамарч байгааг илтгэнэ. Интернэтийг ашигласнаар мэдээлэл хуваалцах, илгээх, хүлээн авах, нийтлэх гэх мэтээр үзэл бодлоо илэрхийлэх, хувь хүмүүс харилцаа үүсгэх, тойрон хүрээлэл үүсгэн нэгдэхэд хялбар болсон.<sup>31</sup> Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй энгийн жишээг Фэйсбүүк (Facebook), Instagram, Youtube, Twitter зэрэг платформыг ашиглаж хэрхэн мэдээлэл хүлээн авч, түгээж байгаагаас харж болно. Эдгээр нь зөвхөн түгээмэл ашиглаж буй арга, хэлбэрүүд бөгөөд цаашид дижитал технологи үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж,<sup>32</sup> ач холбогдол нь нэмэгдсээр байхыг тэмдэглэх нь зүйтэй.

<sup>27</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

<sup>28</sup> НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (№34, 19 дүгээр зүйл, 2011): Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө.

<sup>29</sup> Joint declaration on freedom of expression and the internet, 2011.06.01 <https://www.osce.org/files/f/documents/e/9/78309.pdf>, Сүүлд хандсан огноо: 2014.06.19.

<sup>30</sup> Statista, Number of internet and social media users worldwide as of April 2024 <https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide/>. Сүүлд хандсан огноо: 2024.06.20.

<sup>31</sup> Jack M Balkin (2004). How Rights Change: Freedom of Speech in the Digital Era, [https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/1734/How\\_Rights\\_Change\\_Freedom\\_of\\_Speech\\_in\\_the\\_Digital\\_Era.pdf?sequence=2](https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/1734/How_Rights_Change_Freedom_of_Speech_in_the_Digital_Era.pdf?sequence=2)

<sup>32</sup> Council of Europe., Legal instruments., Recommendation CM/REC 13 (2022), The Impacts of Digital Technologies on Freedom of Expression., <https://edoc.coe.int/en/international-law/11101-the-impacts-of-digital-technologies-on-freedom-of-expression-recommendation-cmrec202213.html>. Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

### 1.1.1 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй хэлбэрүүд

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн онцлог нь компьютер, технологийн цаана хэн ч нэрээ нууцлан өөрийн үзэл бодлоо илэрхийлэх боломжтой байдаг оршино. Өөрөөр хэлбэл, интернэт, мэдээлэл технологийн хөгжил нь хүмүүст үзэл бодлоо шийтгэл, хариуцлагаас айлгүйгээр илүү чөлөөтэй илэрхийлэх,<sup>33</sup> түүний дотор нэрээ нууцлах боломжийг бий болгосон.

Олон нийтийн сүлжээнд төрөл бүрийн сэдвээр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл түгээх дараах хэлбэрүүдийг түгээмэл ашиглаж байна.

Хүснэгт 1. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй түгээмэл хэлбэрүүд

Хэлбэрийн нэршил	Илэрхийлэгдэж буй хэлбэр	Платформ, төрөл
Олон нийтийн сүлжээний (Сошиал медиа), платформын нийтлэл (Social Media Posts)	текст, видео, зураг болон бусад хэлбэрээр аль ч төрлийн мэдээллийн технологийн хэрэглүүрийг ашиглан нийтлэх, байршуулах, тэдгээрт сэтгэгдэл бичих, хариу үйлдэл (reaction) үзүүлэх, хуваалцах	Фейсбүүк, Twitter, Instagram, Youtube, TikTok, LinkedIn, Reddit болон тэдгээртэй төсөөтэй бусад
Мэдээний нийтлэлийн тайлбар (Commentary on News Articles)	цаг үеийн шинжтэй үйл явдлын талаар сурвалжилсан мэдээний талаар санал бодлоо илэрхийлэхийн тулд мэдээллийн сүлжээ, цахим хуудсанд сэтгэгдэл бичих	Мэдээний цахим хуудас, олон нийтийн сүлжээний хуудас
Нийтлэл бичих (Opinion Columns)	өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн нийтлэл бичих	Цахим хуудас, онлайн сэтгүүл
Подкаст болон Влог (Podcasts and Vlogs)	аудио, эсвэл видео контент бүтээж, байршуулах	Youtube, Spotify болон тэдгээртэй төсөөтэй бусад
Шууд дамжуулалт (Live)	шууд дамжуулах боломж бүхий платформуудыг ашиглан шууд дамжуулах байдлаар санал бодлоо тухайн цаг хугацаанд хуваалцах, илэрхийлэх;	Фейсбүүк, Instagram, Youtube болон тэдгээртэй төсөөтэй бусад

<sup>33</sup> UN, Human Rights Council., Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, Frank La Rue., 2013.04.17., [https://www.ohchr.org/sites/default/files/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session23/A.HRC.23.40\\_EN.pdf](https://www.ohchr.org/sites/default/files/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session23/A.HRC.23.40_EN.pdf) Сүүлд хандсан огноо: 2024.06.19.

Хэлбэрийн нэршил	Илэрхийлэгдэж буй хэлбэр	Платформ, төрөл
Вебинар болон цахим хурал (Webinars and Online Conferences)	тодорхой сэдвийн хүрээнд, товлосон цаг хугацаанд хэлэлцүүлэг, ярилцлага, хурал зохион байгуулах, түүнд оролцох	Zoom, Teams, Meets болон тэдгээртэй төсөөтэй бусад

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэхдээ төрөл бүрийн платформыг тус бүрийн зориулалт, функцээс хамааран, өөр өөрийн хэрэгцээ, сонирхол, харилцааны хэв маягт нийцүүлэн тохирох хэлбэрүүдийг сонгон ашиглаж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг эрж хайх, хүлээн авах, түгээх<sup>34</sup> замаар хэрэгжүүлэх боломжтой тул дээрх хэлбэрүүдийг цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй хэлбэрүүд гэж үзэх боломжтой.

### 1.1.2 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй субъектийг тодорхойлох

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй арга, хэлбэрээс хамаарч субъектийг тодорхойлох боломжгүй тохиолдлууд гардаг онцлогтой. Жишээлбэл, мэдээллийн сайтад сэтгэгдэл (коммент) үлдээхэд тухайн хэрэглэгчийн нэр, зураг харагдахгүй байдлаар буюу нэрээ нууцлах тохиргоог ашиглах, олон нийтийн сүлжээнд хэрэглэгч өөрийн профайлыг түгжсэн, эсвэл хуурамч хаяг ашиглах зэргийг дурдаж болно. Үүнтэй холбогдуулан субъектийг тогтоох төлбөртэй болон төлбөргүй технологийн шийдлүүдийг хөгжүүлэн<sup>35</sup> ашиглаж байна.<sup>36</sup>

<sup>34</sup> Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, 1976, 19дүгээр зүйл, 2 дахь хэсэг

<sup>35</sup> Aaron minc "22 Free Tools & Tips to Identify an Anonymous Online Defamer" 2024 <https://www.minclaw.com/free-tools-tips-find-anonymous-online-defamer/> Сүүлд хандсан огноо: 2024.06.25

<sup>36</sup> Aaron minc "22 Free Tools & Tips to Identify an Anonymous Online Defamer" 2024 <https://www.minclaw.com/free-tools-tips-find-anonymous-online-defamer/> Сүүлд хандсан огноо: 2024.06.25

Үүнд;

- хэрэглэгчийн дугаар, утас, овог, нэр, хаяг, и-мэйл хаяг гэх мэт аль нэг мэдээллийг хайлт хэсэгт оруулснаар Фейсбүүк, Instagram, Youtube гэхчлэн 120 гаруй цахим сайтад байршиж буй тухайн хэрэглэгчтэй холбоотой мэдээллийг илэрцээр харуулах (Spokeo);
- хуурамч хаягийг илрүүлэх хүрээнд IP хаягаар хайлт хийж тухайн хэрэглэгч хаанаас, ямар төхөөрөмжөөр хандсан мэдээллийг байршил, цаг хугацаагаар зааглан дэлгэрэнгүй харуулах (Infospiner);

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн үр дагавраар дээрх аргууд нь цахим орчин дахь мэдээллийн “ард” хэн байгааг тодорхойлоход хүрэлцэхгүй байх асуудал гарсаар байна. Тухайлбал, хиймэл оюун ухааныг ашиглан хүний оролцоогүйгээр дуу, дүрс бүхий бүтээлийг хувиргах замаар хуурамч мэдээллийг (deep fake) түгээх, хүлээн авах боломжтой болсон.<sup>37</sup> Хиймэл оюун ухаанд суурилсан чат-бот, программ хангамж нь хүнтэй чөлөөтэй харилцан яриа үүсгэж, эсээ, мэйл бичиж, цахим орчинд судалгаа хийх,<sup>38</sup> мэдээлэл, нийтлэл бэлтгэх, дуу, шүлэг зохиох,<sup>39</sup> асуусан асуултад чөлөөтэй хариулт өгч байгаа зэрэг<sup>40</sup> нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлж буй хэлбэр гэж үзэх нь байна. Хүний оролцоогүй контент бүтээж, түгээж буй эдгээр тохиолдолд болон хуулиар тогтоосон хязгаарлалт, хориглолтыг зөрчих, бусдын нэр төр, алдар хүндийг гутаах, гэмт хэргийн шинжтэй болон хууль бус бусад үйл ажиллагаанд ашиглагдаж буй үед энэ төрлийн арга, хэлбэрийг ашиглаж буй субъектийг тогтоох шаардлага үүснэ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд **“хүн бүр”** гэж онцлон тэмдэглэсэн байдаг нь хүн бүр уг эрхийг баталгаатай эдэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн субъект болохыг хоёрдмол утгагүй илэрхийлж байна. Үүнээс үзвэл, хүн нэрээ нууцалж, хуурамч хаяг ашигласан ч энэ нь үзэл бодлоо илэрхийлж буй нэг хэлбэр болно. Харин

<sup>37</sup> Статистик мэдээллийн вэбсайт (2024), <https://www.statista.com/chart/31901/countries-per-region-with-biggest-increases-in-deepfake-specific-fraud-cases/>, Сүүлд хандсан: 2024.07.24

<sup>38</sup> Cass Sunstein “Does AI have the right to freedom of speech?”, 2024 <https://law.queensu.ca/news/Does-AI-have-the-right-to-freedom-of-speech> Сүүлд хандсан огноо: 2024.06.25

<sup>39</sup> Gene Policinski, “Does ChatGPT Have the Right to Free Speech?” <https://www.freedomforum.org/does-chatgpt-have-the-right-to-free-speech/> Сүүлд хандсан огноо: 2024.06.25

<sup>40</sup> Simon McCarthy-Jones, “Does AI have a right to free speech? Only if it supports our right to free thought”, 2023., <https://theconversation.com/does-ai-have-a-right-to-free-speech-only-if-it-supports-our-right-to-free-thought-212555> Сүүлд хандсан огноо: 2024.06.20

өгөгдөл, мэдээллээр “сургагдсан”, алгоритмд суурилсан хиймэл оюуны ухааныг хүнтэй адилтган үзэж түүнд ч мөн үзэл бодлоо илэрхийлэх эрх бий гэж дүгнэх нь өрөөсгөл юм.

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, улс орнуудын Үндсэн хуульд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан зүйл, заалтад “цахим орчин” гэх нэр томъёо тусгагдаагүй боловч үзэл бодлыг хэрхэн түгээж буй арга, хэлбэрээс үл хамааран оффлайн орчинд буюу уламжлалт хэлбэрээр илэрхийлж буйтай ижил түвшинд хамгаалагдана. Тиймээс уг эрхийг цахим орчинд хүн бүр ижил тэгш хэрэгжүүлэх баталгааг хангахын тулд гол хэрэгсэл болсон интернэтийн хүртээмжийг сайжруулах, хууль ёсны зохих үндэслэлгүйгээр интернэтийг хязгаарлахаас зайлсхийхэд улс орнууд анхаарч байна. Учир нь интернэтийн тусламжтайгаар цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх хэлбэр, төрөл, цар хүрээ нэмэгдэж, хуулиар тухайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх боломж хүн бүрд нээлттэй болсон. Мөн нөгөө талд мэдээллийг хүлээн авах, хайх бусдын эрх нь салшгүй агуулагдаж явах тул уг эрх хөндөгдөхгүй байх давхар баталгааг хангах шаардлагатай.

## **1.2. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хууль зүйн баталгаа, хамгаалалт**

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний салшгүй, заяагдмал эрх болохын хувьд олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд нэгэнтээ тусгагдаж, улс орнууд ч түүнээс улбаалан өөрсдийн Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг иргэний үндсэн эрх, эрх чөлөө болгон баталгаажуулсан байдаг.

Судалгааны эхний хэсэгт мэдээллийн технологийн хөгжлийн нөлөөгөөр цахим орчин нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлж буй нэгэн талбар хэдийн болсныг дүгнэсэн. Харин олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц, баримт бичгүүд, үндэсний хууль тогтоомжуудад нийцүүлэн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрхэн тайлбарлах, шинээр ямар зохицуулалт, эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулж буйг судалгааны энэ хэсэгт танилцуулна.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, хүний эрхийн баримт бичгүүд болох Хүний эрхийн түгээмэл тунхаглал<sup>41</sup>, ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд үзэл

<sup>41</sup> Дэлхийн хоёрдугаар дайны дараа улс орнууд хүн бүхэнд угаас заяасан адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрч, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ХЭТТ-ыг баталсан нь зөвлөмжийн шинжтэй боловч хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, улс орнуудын Үндсэн хууль, хууль тогтоомжийн үндэс болсон чухал баримт бичиг юм.



бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөвхөн бусдын нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгоор хуульчлан тогтоосон хязгаарлалтаас бусад үед “ямар ч хорио саадгүй” эдлэхийг онцгойлон дурдсан. Ийнхүү хуулиар тогтоосноос бусад нөхцөлд хэн ч, хаана ч, ямар ч хэлбэрээр, хөндлөнгийн оролцоогүйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаатай эдлэх, хэрэгжүүлэх боломжтой байна. Тодруулбал, үзэл бодлоо илэрхийлэх, түгээх бүх төрлийн арга хэлбэр, арга хэрэгслийг уг эрх чөлөөний хүрээнд хамгаалах бөгөөд үүнд цахим болон интернэтэд суурилсан үзэл бодол илэрхийлэх арга хэлбэрийг хамааруулна.<sup>42</sup> Тиймээс ижил төрлийн хамгаалалт, баталгааг олгож, уламжлалт хэлбэрээр буюу оффлайн орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг улс орнууд хамгаалдаг шигээ цахим орчинд ч мөн адил хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулахыг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос уриалжээ.<sup>43</sup>

Цахим орчин нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлж буй чухал хэрэгсэл бөгөөд дэлхий даяарх олон тэрбум хүмүүст дуу хоолойгоо хүргэх, тэдний мэдээлэлд хандах чадавх, олон ургалч үзэл, ил тод байдлыг нэмэгдүүлж буй<sup>44</sup> эерэг нөлөөтэй. Иймд хэрэгжих баталгааг хангах хүрээнд интернэт болон бусад харилцаа холбооны хэрэгслийг ашиглахад аливаа хязгаарлалт тогтоохгүй байх, хүртээмж, ашиглах боломжийг нэмэгдүүлэхэд улс орнууд анхаарах шаардлагатайг зөвлөжээ.<sup>45</sup>

Хүний эрхийн тухай Европын конвенц<sup>46</sup>-д баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг цахим орчинд хэрэгжүүлж буйтай холбогдуулан уг эрхийн агуулгыг бүх хэвлэл мэдээлэл, цахим орчинд яриа, бичгийн хэл, дуу, дүрс, аман бус, цахим орчинд суурилсан өөр бусад арга хэрэгслээр, бүхий л

<sup>42</sup> МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн., Үндсэн хууль манай сургуульд: НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр., Улаанбаатар., хуудас 137. 2022. <https://cli.num.edu.mn/content/Undsen%20manai%20surguulid%202022.pdf> Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>43</sup> UN, Human Rights Council., Report of the Special Rapporteur on the rights to freedom of peaceful assembly and of association., “Ending Internet shutdowns: a path forward”., Jun 15, 2021., <https://documents.un.org/doc/undoc/gen/g21/149/66/pdf/g2114966.pdf?token=ILlQWlfo nTUOCstYB&fe=true.>, Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>44</sup> Joint declaration on Freedom of expression and the Internet., Jun 11, 2011., <https://www.osce.org/files/f/documents/e/9/78309.pdf.>, Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>45</sup> Joint declaration on Challenges to Freedom of expression in the next decade., Jul 10, 2019., <https://www.osce.org/files/f/documents/9/c/425282.pdf.>, Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>46</sup> Европын зөвлөлөөс хүний эрхийг баталгаажуулсан анхны суурь баримт бичиг болох “Хүний эрхийн тухай Европын конвенц” нь 1950 онд батлагдан, 1953 оноос хүчин төгөлдөр болсон ба Европын холбооны гишүүн орнуудын хүрээнд хүний эрхийг хамгаалсан гол зохицуулалт юм. Уг конвенцын 10 дугаар бүлэгт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар заасан.

хэлбэрээр өөрийн үзэл бодлоо илэрхийлэх<sup>47</sup> гэж тодорхойлсон байдаг. Уг эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд хэрэглэгчийн хүсэлтээр, алсаас, цахим хэлбэрээр, төлбөртэй үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ үзүүлэгч (дижитал үйлчилгээ үзүүлэгч)<sup>48</sup> нь хариуцлагатай байж, найдвартай, аюулгүй орчныг бүрдүүлэх үүргийг хүлээлгэсэн.<sup>49</sup> Үйлчилгээ үзүүлэгч уг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэгчийн хандалтыг хаах арга хэмжээ авах тохиолдолд мэдээлэл авах эрх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлахаас зайлсхийх шаардлагыг Дижитал үйлчилгээний хуулиар зохицуулж байна.

Европын хүний эрхийн шүүх<sup>50</sup> 2023 оны 10 дугаар сарын байдлаар интернэт цахим орчинд хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотойгоор 220 гаруй хэргийг эцэслэн, 60 гаруй хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.<sup>51</sup> Эдгээр шүүхийн шийдвэр нь Европын хүний эрхийн тухай конвенц, түүний суурь зарчим, цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хүрээнд Европын холбооноос баталсан хууль, журамд нийцүүлэн<sup>52</sup> цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийн онцлог шинжийг харгалзан, энэхүү эрхийг хэрэгжүүлэх явцад бусдын нэр төрд халдах, худал мэдээлэл тараах зэргийн хохирлыг харгалзан үзэж хувь хүн, хуулийн этгээдийн цахим орчин дах үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэлд дүгнэлт хийдэг.

<sup>47</sup> Council of European Union “EU human rights guidelines on freedom of expression online and offline”

[https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu\\_human\\_rights\\_guidelines\\_on\\_freedom\\_of\\_expression\\_online\\_and\\_offline\\_en.pdf](https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu_human_rights_guidelines_on_freedom_of_expression_online_and_offline_en.pdf) Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>48</sup> Information Society services codification, 2015

<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32015L1535> Сүүлд хандсан огноо:2024.07.01

<sup>49</sup> EUR-lex “Digital services act”

<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32022R2065&qid=1719385637751> Сүүлд хандсан огноо: 2024.06.27

<sup>50</sup> Европын хүний эрхийн тухай конвенцэд тулгуурлан 1959 онд байгуулагдсан Европын хүний эрхийн шүүх байгууллага нь гишүүн орнуудын хүрээнд хүний эрхийн зөрчлийг арилган, хүний эрх, эрх чөлөөг ханган ажилладаг.

[http://news.bbc.co.uk/2/hi/europe/country\\_profiles/4789300.stm](http://news.bbc.co.uk/2/hi/europe/country_profiles/4789300.stm) Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>51</sup> Dirk Voorhoof “Freedom of Expression in the Digital Environment: How the European Court of Human Rights has Contributed to the Protection of the Right to Freedom of Expression and Information on the Internet” 2023

<https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/10/VOORHOOF.FOEDigitalEnvironment.BookElgar.SEPT22.pdf> Сүүлд хандсан огноо: 2024.07.01

<sup>52</sup> Dirk Voorhoof “Freedom of Expression in the Digital Environment: How the European Court of Human Rights has Contributed to the Protection of the Right to Freedom of Expression and Information on the Internet” 2023

<https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/10/VOORHOOF.FOEDigitalEnvironment.BookElgar.SEPT22.pdf> Сүүлд хандсан огноо: 2024.07.01

Дээрхээс үзвэл үзэл бодлоо цахим орчинд илэрхийлэх баталгаа, хамгаалалтыг олон улсын хүний эрхийн баримт бичиг, конвенцод тусгагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн агуулгаар нь хэрэгжүүлэхэд анхаарч байна. Энэ хүрээнд улс орнуудад дижитал дэд бүтцээ сайжруулах, интернэтийн хэрэглээ, хандалтыг хязгаарлахгүй байх, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг арга замуудыг зөвлөхийн зэрэгцээ, цахим орчинд үйлчилгээ үзүүлэгч нарт аюулгүй, найдвартай орчныг бүрдүүлэх үүргийг ногдуулж, уг үүргийг биелүүлэхдээ хэрэглэгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх шаардлагыг ногдуулсан шинэлэг хууль тогтоомжуудыг баталжээ.

Улс орнууд үндэсний хэмжээнд уг эрх чөлөөг хэрхэн баталгаажуулж, хамгаалж буйг авч үзье. Интернэт орчинд эрх чөлөөг хэрэгжүүлэх хамгийн таатай улсын нэг<sup>53</sup> Эстони Улс нь үг хэлэх, үзэл бодлоо ямар ч хэлбэрээр чөлөөтэй, аливаа цензургүй илэрхийлэх эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан.<sup>54</sup> Уг эрхийг хэрэгжүүлэхийн тулд цахим орчинд хүн бүрийн оролцоог хангах, интернэтийн эрх чөлөөг баталгаажуулах цогц арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн<sup>55</sup> нь өмнөх хэсэгт дурдсан улс орнуудын анхаарч хэрэгжүүлэх арга замуудад хамаарч байна.

Интернэтийн эрх чөлөөг хангалттай түвшинд хэрэгжүүлж буй<sup>56</sup> ХБНГУ бусдын нэр төрд халдахгүйгээр хүн бүр өөрийн үзэл бодлыг аливаа хязгаарлалтгүйгээр эдлэх эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулсан.<sup>57</sup> Ийнхүү баталгаажуулсан эрхийг илт хууль бус агуулгатайгаар хэрэгжүүлэх тохиолдолд хэрэглэгчийн контентыг устгах үүргийг тухайн нийгмийн сүлжээний платформыг ажиллуулагч дижитал үйлчилгээ үзүүлэгчид Нийгмийн сүлжээний хэрэгжилтийн тухай хуулиар<sup>58</sup> ногдуулсан байдаг. Тодруулбал, 2 сая болон түүнээс дээш хэрэглэгчтэй

<sup>53</sup> Statista, „Freedom House Index: Countries with the highest internet freedom 2023“, [https://www.statista.com/statistics/272533/degree-of-internet-freedom-in-selected-countries/#:-:text=In%202023%2C%20Iceland%20was%20the,0%20\(the%20least%20free\)](https://www.statista.com/statistics/272533/degree-of-internet-freedom-in-selected-countries/#:-:text=In%202023%2C%20Iceland%20was%20the,0%20(the%20least%20free).). Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>54</sup> The Constitution of the Republic of Estonia, (1992), <https://www.riigiteataja.ee/en/eli/521052015001/consolide> Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>55</sup> Republic of Estonia, Ministry of Economic Affairs And Communication, “Estonia’s Digital Agenda 2030”, 2021., <https://digital-skills-jobs.europa.eu/en/actions/national-initiatives/national-strategies/estonia-estonian-digital-agenda-2030.>, Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>56</sup> Freedom House “Freedom on the net report: Germany 2023” <https://freedomhouse.org/country/germany/freedom-net/2023> Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>57</sup> Federal Ministry of Justice website “Basic Law for the Federal Republic of Germany” [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_gg/englisch\\_gg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html) Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>58</sup> NETzDG буюу Нийгмийн сүлжээний хэрэгжилтийн тухай хууль нь 2017 оны 06 сард батлагдан, 2018 оны 01 сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

нийгмийн сүлжээ нь илт хууль бус контентыг 24 цагийн дотор, хууль бус контентыг нийтэлснээс хойш 7 хоногийн дотор өөрийн сүлжээнээс устгаагүй тохиолдолд 50 сая хүртэл еврогоор торгохоор заажээ.<sup>59</sup> Мөн судалгааны өмнөх хэсэгт дурдсан Европын холбооны гишүүн орнууд дагаж мөрдөх Дижитал үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд дотоодын хууль тогтоомжийг<sup>60</sup> батлан мөрдүүлж байна.

АНУ-д үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө 1791 оны “Эрхийн Билл”-ийн нэг хэсэг болох АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт, өөрчлөлтөөр хамгаалагдсан.<sup>61</sup> Уг нэмэлт, өөрчлөлт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд Засгийн газраас цензур тавихыг хориглох агуулгатай бөгөөд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн байдлыг “зохистой” эсвэл хүүхдэд тохиромжтой болгох зорилгоор түүнд хязгаарлалт тавих, интернэт хаах зэргийг хориглодог.<sup>62</sup> Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх чөлөөг хамгаалах хүрээнд “хууль зүйн үндэслэл бүхий процессгүйгээр хязгаарлахгүй” байх зарчмыг Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлт, өөрчлөлтийн дагуу АНУ-ын муж улс бүр мөрддөг.<sup>63</sup>

Цахим орчинд үйлчилгээ үзүүлэгч хууль бус хэрэглэгчийн контентод хязгаарлалт тавих, үйлчилгээнд нэвтрэх эрхийг хязгаарлах үүргийг Харилцаа холбооны зохистой байдлын тухай хуулиар хүлээж, уг үүргийг хэрэгжүүлсний төлөө хариуцлага хүлээхгүй байх хамгаалалт олгожээ. Мөн насанд хүрээгүй хүүхдийг интернэт дэх зохисгүй материалаас хамгаалах зорилготой уг хуульд “садар самуун, ёс суртахуунгүй” мэдээллийг санаатайгаар дамжуулах, түүнчлэн харилцаа холбоонд тавигдах стандартын дагуу “зохисгүй” гэж тооцогдох “бэлгийн эсвэл бусад эрхтнүүд”-ийн дүрслэл бүхий мэдээллийг дамжуулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан эсэхэд АНУ-ын Дээд шүүхээс шийдвэрлэсэн

<sup>59</sup> Federal Ministry of Justice website “Network Enforcement Act” [https://www.gesetze-im-internet.de/netzdg/\\_1.html](https://www.gesetze-im-internet.de/netzdg/_1.html) Сүүлд хандсан огноо: 2024.06.26

<sup>60</sup> “Digital service act” (DDG) <https://www.gesetze-im-internet.de/ddg/BJNR0950B0024.html> Сүүлд хандсан огноо: 2024.07.01

<sup>61</sup> “Freedom of Expression: A Comparative Summary of United States and European Law”, 2019, p.4 [https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN\\_ID4563882\\_code1452677.pdf?abstractid=4563882&mirid=1&type=2](https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN_ID4563882_code1452677.pdf?abstractid=4563882&mirid=1&type=2)

<sup>62</sup> Danielle K. Citron, Neil Richards, “Four Principles for Digital Expression” 2018, pp.1357, [https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty\\_scholarship](https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty_scholarship)

<sup>63</sup> “Freedom of Expression: A Comparative Summary of United States and European Law”, 2019, p.15 [https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN\\_ID4563882\\_code1452677.pdf?abstractid=4563882&mirid=1&type=2](https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN_ID4563882_code1452677.pdf?abstractid=4563882&mirid=1&type=2)

тохиолдол гарчээ.<sup>64</sup> Дээд шүүхээс хуульд “зохисгүй” гэдэгт хамаарах мэдээллийг нарийн тодорхойлоогүй<sup>65</sup> нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж,<sup>66</sup> улмаар Үндсэн хууль зөрчиж байна гэж дүгнэсэн. Уг шийдвэр нь цахим орчинд аливаа хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх нь Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд хамгаалагдана гэдгийг баталгаажуулж өгчээ.

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ерөнхий хүрээнд баталгаажуулсан бөгөөд ИБУТЭОУП-д нэгдэн, соёрхон баталсан улс<sup>67</sup> болохын хувьд ИБУТЭОУП-ын 19 дүгээр заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Гэвч цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх нөхцөлийг баталгаажуулсан, тодорхойлсон эрх зүйн хэм хэмжээ одоогоор байхгүй. Энэ нөхцөл байдлыг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбоотой үндэсний зарим хууль тогтоомж, зохицуулалт, дүрэм журам боловсронгуй бус, олон улсын гэрээ, конвенцод нийцээгүй тул дээрх эрхийн хэрэгжилт хангалтгүй<sup>68</sup> гэж Хүний Эрхийн Үндэсний Комиссоос дүгнэсэн байдаг.

УИХ-аас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр цахим орчин дахь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зохисгүй, доромжилсон, ялгаварлан гадуурхсан агуулга бүхий үг хэллэг, зөрчилтэй контентыг хязгаарлах, хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, садар самуун, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилготой “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай” хуулийг баталсан. Уг хуульд нийтийг хамарсан үймээн самуун дэгдсэн тохиолдолд цахим орчинд бүрэн эсхүл хэсэгчилсэн хязгаарлалт тогтоох эрхийг Кибер аюулгүй байдлын зөвлөл хэрэгжүүлэхээр тусгасан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан шинжтэй, олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд нийцээгүй гэсэн шүүмжлэл дагуулжээ.<sup>69</sup>

<sup>64</sup> Case of Reno v. ACLU

<sup>65</sup> Reno v. ACLU, 521 The U.S. Supreme Court, 844 (1997), <https://supreme.justia.com/cases/federal/us/521/844/#tab-opinion-1960201>, brief analysis: <https://www.oyez.org/cases/1996/96-511>

<sup>66</sup> Danielle K. Citron, Neil Richards, “Four Principles for Digital Expression” 2018, p.1358, [https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty\\_scholarship](https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty_scholarship) Сүүлд хандсан огноо: 2024.06.24

<sup>67</sup> Монгол улс 1968 оны 01 дүгээр сарын 05-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

<sup>68</sup> ХЭҮК-ын Монгол улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дах илтгэл., 2018., хуудас 208., <https://lib4u.net/ebook/?id=80&lib=nhrс> Сүүлд хандсан огноо: 2024.06.25.

<sup>69</sup> Нээлттэй Нийгэм Форум, Хуулийн Шүүмж, Монгол Улсын Нийгмийн Сүлжээний Хууль, Цуврал №41, 2023 оны 3 дугаар сар.

Дээрх хуулийг батлахдаа “олон нийтийн оролцоог хангаагүй, хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн саналыг аваагүй, үндсэн эрх, чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг батлахдаа хууль дээдлэх ёсны зарчмыг баримталж, ард олон, эрдэмтэн судлаачид, мэргэжлийн байгууллагын саналыг авч, хэлэлцүүлэг зохион байгуулж батлах ёстой”<sup>70</sup> гэх үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьж, УИХ-ын хаврын чуулганы 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хүлээн авч хэлэлцээд, хуулийг хүчингүй болгожээ.

Дээр дурдсанчлан хэдийгээр Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх баталгааг хангахтай холбогдох тухайлсан хууль тогтоомж байхгүй боловч шүүхийн практикт энэ эрхийн баталгааг хангах асуудлыг хэрхэн хэрэгжүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар нь дүгнэж, хамгаалж буй эсэхийг холбогдох шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар тодруулан дүгнэх нь зүйтэй байна.

### 1.3 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээний хууль зүйн үндэслэл

#### 1.3.1 Монгол Улсын эрх зүйн орчин

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний жам ёсны, салшгүй эрх бөгөөд уг шинж нь цахим орчинд нэгэн адил хамаарна. ХЭТТ-ын 29 дүгээр зүйлийн 2 дах хэсэгт “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй.” гэж заасан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нийгмийн хэв журмыг хангах зорилгоор гагцхүү **“хуулиар”** хязгаарлаж болох зарчмыг тодорхойлсон. ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг (1) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, (2) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагаар хуулиар хязгаарлана.


ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооны 34 дүгээр Ерөнхий тайлбарын 43 дах хэсэгт “Цахим хуудас, блог, интернэтэд суурилсан бусад хэвлэл, электрон буюу мэдээлэл түгээх бусад систем, интернэтийн үйлчилгээ түгээгч, хайлтын систем, эдгээрт туслах үүрэгтэй дэд

<sup>70</sup> Монцамэ, <https://montsame.mn/mn/read/312089> Сүүлд хандсан: 2024.07.29

системийн үйл ажиллагаанд тогтоосон аливаа хязгаарлалтыг гагцхүү пактын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн шаардлагад нийцсэн тохиолдолд зөвшөөрнө. Энэ тайлбарт дурдсанаар “Үндэсний аюулгүй байдал”-ын шаардлагад үндэсний аюулгүй байдал, төрийн болон албаны нууц, үндэсний эв нэгдлийг бусниулах хэмжээний мэдээлэл хамаарна. Харин худалдаа, банк, шинжлэх ухааны салбарт хамаарах мэдээлэл, хөдөлмөрийн маргаантай холбоотой улс орныг хамарсан ажил хаялт зохион байгуулахаар төлөвлөсөн талыг дэмжсэн мэдэгдэл хийхийг үндэсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хязгаарлах нь ИБУТЭОУП-ын 19.3 дах хэсэгт нийцэхгүй болохыг тайлбарлажээ. Харин нийгмийн хэв журмыг хангахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүн таслах ажиллагааны дэг журмыг хангах шаардлагад тулгуурласан, эрхийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгод нийцсэн тохиолдолд хязгаарлаж болно.

Тиймээс ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт хийх тохиолдолд “заавал хуулиар тогтоогдсон” байх, уг хуулийн зохицуулалт нь бусдын нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах гэсэн шаардлагуудад үндэслэж буй эсэхийг дараах зарчмуудыг шалгуур болгон баримталж хэрэгжүүлбэл зүйд нийцнэ.

Зураг 1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад баримтлах зарчмууд<sup>71</sup>



НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2022 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 50/15 тоот “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө”-ний тухай тогтоолд<sup>72</sup> гишүүн улс орон бүр ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд дурдагдаагүй шаардлагад үндэслэн

<sup>71</sup> (1) Columbia university., Global Freedom of Expression., “Internet shutdowns in international law”, 2023., [https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/07/GFoE\\_Internet-shutdowns-in-international-law.pdf](https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/07/GFoE_Internet-shutdowns-in-international-law.pdf).,

(2) UN., Human Rights Council., Report of the Office of the United Nations High Commissioner for Human Rights., “Internet shutdowns: trends, causes, legal implications and impacts on a range of human rights”, May 13, 2023., para 11., <https://documents.un.org/doc/undoc/gen/g22/341/55/pdf/g2234155.pdf?token=4Dag4l19xSuQgZwd96&fe=true>.,

(3) Council of Europe., Recommendation CM/Rec(2016) of the Committee of Ministers to member States on Internet freedom (Adopted by the Committee of Ministers on 13 April 2016 at the 1253rd meetings of the Ministers’ Deputies)., [https://search.coe.int/cm/#{%22CoEIdentifier%22:%2209000016806415fa%22},%22sort%22:\[%22CoEValidationDate%20Descending%22\]}](https://search.coe.int/cm/#{%22CoEIdentifier%22:%2209000016806415fa%22},%22sort%22:[%22CoEValidationDate%20Descending%22]})., Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>72</sup> Freedom of opinion and expression : resolution adopted by the Human Rights Council on 8 July 2022., <https://digitallibrary.un.org/record/3985686?ln=ru&v=pdf>., Сүүлд хандсан огноо: 2024.07.01.



шинэ төрлийн хязгаарлалт тогтоохоос татгалзаж, одоо байгаа хязгаарлалтуудыг цуцлах арга хэмжээ авахыг уриалсан. Ялангуяа цахим орчинд нэвтрэх, түгээх эрхийг санаатайгаар тасалдуулах зорилгоор интернэтийг хаах, онлайн цензур (online censorship) тогтоох, хэвлэлийн болон бусад мэдээллийн хэрэгслийг хориглох, хаах, захиргааны арга хэмжээ авах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх, радио, телевиз, интернэт гэх мэт мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглалтыг хязгаарлах арга хэмжээг дурджээ.

Интернэтийн эрх чөлөөг хамгаалах, бэхжүүлэх зорилго бүхий 39 улсын<sup>73</sup> Засгийн газар нэгдсэн Онлайн эрх чөлөөний эвсэл (Freedom Online Coalition)-ийн 2022 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт<sup>74</sup> зүй бусаар хязгаарласан цензур, интернэтийн хязгаарлалт зэрэг дарамт шахалтаас ангид онлайн экосистемд хүн бүрийн аюулгүй байдлыг дэмжих зорилтыг тодорхойлсон. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 47 дугаар хэлэлцүүлгээр Онлайн эрх чөлөөний эвсэл нь “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх хамтарсан тунхаглал”-ыг танилцуулахдаа<sup>75</sup> улс орнуудыг “Интернэт хязгаарлалтыг нэн даруй зогсоож, олон янзын дуу хоолой сонсогддог чөлөөт, нээлттэй, харилцан ажиллах боломжтой, найдвартай, аюулгүй интернэт орчноор хангаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг хүний эрхийг бүрэн хүндэтгэх арга хэмжээ авахыг бүх Засгийн газруудад тууштай уриалжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэл нь ИБҮТЭОУП-аар тодорхойлсон шаардлагатай шууд холбоотой. Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг (1) үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, (2) бусдын эрх чөлөө, эрх чөлөөг хүндэтгэх, (3) нийгмийн хэв журмыг сахиулах үндэслэлээр гагцхүү хуулиар хязгаарлана. Ингэхдээ өмнө дурдсан НҮБ-ын Хүний эрхийн хороо тогтоол, Засгийн газруудын нэгдсэн Онлайн эрх чөлөөний эвслийн тогтоол, тайлбаруудаас үзвэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуулиар хязгаарлах шаардлага, үндэслэлийг онлайн болон оффлайн орчинд нэгэн адил дагаж мөрдөнө.

<sup>73</sup> Аргентин, Австрали, Австри, Cabo verde, Канад, Чиль, Коста Рика, Чех, Денмарк, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Гана, Ирланд, Исланд, Итали, Япон, Кень, БНСУ, Латви, Литвань, Люксембург, Малдив, Мексик, Молдав, Монгол, Недерланд, Шинэ Зееланд, Норвеги, Польш, Словек, Испани, Швед, Швейцарь, Tunisia, Англи, АНУ.

<sup>74</sup> Freedom Online Coalition., Program of Action 2022., “Digital inclusion: A democratic and human rights-based vision for the digital age”, [https://freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2022/01/FOC\\_ProgramofAction\\_2022\\_ENG.pdf](https://freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2022/01/FOC_ProgramofAction_2022_ENG.pdf)., Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>75</sup> FOC Joint Statement on Freedom of Expression Online Presented at the 47th Session of the United Nations Human Rights Council., July 2021., <https://freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2021/07/FOC-Joint-Statement-on-Freedom-of-Expression-Online-Presented-at-the-47th-Session-of-the-United-Nations-Human-Rights-Council.pdf>., Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

Харин Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах харилцааг зохицуулсан эрх зүйн актыг захиргааны байгууллагаас баталж, хэрэгжүүлж байна. Цахим хуудас дах сэтгэгдлийг зохистой хэрэглэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2013 оны тогтоолоор<sup>76</sup> “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем” бий болгож, домэйн нэр олголтыг зохион байгуулах болон мэдээ, мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим хуудсанд тавигдах шаардлагыг тодорхойлох, зохицуулах журмыг зохих хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх арга хэмжээг ХХЗХ-д даалгажээ.

Харилцаа холбооны тухай хуульд 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр оруулсан нэмэлтээр ХХЗХ-д домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбогдсон журам батлах, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг олгосон. ХХЗХ-оос баталсан Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журмын дагуу<sup>77</sup> домэйн нэр эзэмшигч нь (1) Бүртгэлийн мэдээллийг үнэн зөв бүрэн мэдүүлэх; (2) Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг<sup>78</sup> дагаж мөрдөх; (3) Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргийг тус тус хүлээдэг. Тус журмын 6 дугаар зүйлийн 6.1.6 дах хэсэгт зааснаар ХХЗХ нь домэйн нэр эзэмшигч дээрх үүргээ зөрчсөн тохиолдолд домэйн нэрийн хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах талаар мэдэгдлийг домэйн нэр бүртгэгчид хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна.

<sup>76</sup> МУЗГ-ын 2013.01.05-ны өдрийн №1 дүгээр тогтоол., Цахим хуудас дах сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай., <https://legalinfo.mn/mn/detail/8939>.

<sup>77</sup> Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.05.21-ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211149&showType=1>.

<sup>78</sup> Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”, <https://www.mediacouncil.mn/p/7>

Зураг 2. Хууль бус контентын ангилал<sup>79</sup>

Дээрх байдлаар хууль бус контентын агуулгыг тодорхойлоход Эрүүгийн хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиас гадна Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг үндэслэжээ.<sup>80</sup>

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мөрдөгч нь харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулдаг. Хэрэгт ач холбогдол бүхий мэдээ,

<sup>79</sup> Харилцаа холбооны зохицуулах хороо., Цахим орчны зохицуулалт (зөвлөмж)., 2021., <https://crc.gov.mn/storage/1.2%20%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC%20%D0%BE%D1%80%D1%87%D0%BD%D1%8B%20%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BC%D0%B6.pdf> ., Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>80</sup> Мөн тэнд.

баримт байна гэж үзэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд<sup>81</sup> прокурорын зөвшөөрөлтэйгөөр уг ажиллагааг явуулна.

ХХЗХ нь цахим орчин, интернэт, цахим хуудаснууд дахь мэдээ мэдээлэл, контентын агуулгыг шууд хянадаггүй. Харин аливаа мэдээ мэдээлэл нь хууль зөрчсөн тухай холбогдох эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр, саналыг үндэслэн тухайн цахим хуудсыг Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах, хаах зэрэг технологийн арга хэмжээ авч байна.<sup>82</sup>

Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэнтэй холбогдон үүсэж болзошгүй эрүүгийн гэмт хэрэгт “Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийх дамжуулах, тараах”<sup>83</sup>, “Худал мэдээлэл тараах”<sup>84</sup>, “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах”<sup>85</sup>, “Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх”<sup>86</sup>, “Террорист үйлдлийн талаар зориуд мэдээлэх”<sup>87</sup>, “Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах”<sup>88</sup>, “Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах”<sup>89</sup> гэмт хэргүүд хамаарахаар байна.

Олон Улсын Сонгууль ажиглах хорооны 2024 оны Монгол Улсын парламентын сонгуульд хийсэн ажиглалтын тайланд<sup>90</sup> 2017 онд Эрүүгийн хуулиас “гүтгэлэг”-ийн гэмт хэргийг хассан боловч худал мэдээлэл тараах гэмт хэргийг 2020 онд дахин оруулсан нь олон улсын стандарттай зөрчилдөж байгааг онцолжээ. Мөн тайланд сонгуулийн жил эхэлснээс хойш 6 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд сонгуультай холбоотой нийт 786 гомдол, мэдээлэл цагдаагийн

<sup>81</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.2 дугаар зүйл. Харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох. 1. Мөрдөгч хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримт байна гэх хангалттай үндэслэл байвал прокурорын зөвшөөрлөөр дараах арга хэмжээг авч болно: 1.1. харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах; 1.2. харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах; 1.3. харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах. 2. Дараах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно: 2.1. харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох; 2.2. харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулж авах.

<sup>82</sup> Мөн тэнд. Сүүлд хандсан огноо: 2024.07.01.

<sup>83</sup> Эрүүгийн хуулийн 13.8 дугаар зүйл.

<sup>84</sup> Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл.

<sup>85</sup> Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйл.

<sup>86</sup> Эрүүгийн хуулийн 18.2 дугаар зүйл.

<sup>87</sup> Эрүүгийн хуулийн 20.1 дүгээр зүйл.

<sup>88</sup> Эрүүгийн хуулийн 20.2 дугаар зүйл.

<sup>89</sup> Эрүүгийн хуулийн 20.16 дугаар зүйл.

<sup>90</sup> Олон Улсын Сонгууль ажиглах хороо, Монгол Улс – Парламентын сонгууль, 2024.06.28 <https://www.osce.org/files/f/documents/4/e/571883.pdf>

байгууллагад ирснээс зөрчлийн шинжтэй 471, гэмт хэргийн шинжтэй 315 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна. Нийт гомдол мэдээллийн 65 хувийг сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасантай холбоотой гомдол мэдээлэл эзэлж байгаа талаар дурджээ.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан ([www.shuukh.mn](http://www.shuukh.mn)) -аас хайлт хийж үзэхэд 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 2024 оныг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлд заасан “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэргийн шүүхэд хянан шийдвэрлэсэн тохиолдол гараагүй байна. Үүнээс гадна, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйл (Сонгуулийн хуулийг зөрчих)-ийн 7 дахь хэсэгт “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд тараасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 50000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалт байсныг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7-д зааснаар (1) нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, (2) бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашигласан, эсхүл бусдын нэр болон хуурамч хаяг ашигласан бол Харилцаа холбооны зохицуулах хороо нь Тагнуулын байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн цахим хуудсыг хаах, түр хязгаарлах арга хэмжээг авах зохицуулалттай.

ХХЗХ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.11-т зааснаар Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн цахим орчин дахь олон нийтийн сүлжээний хандалтыг хязгаарлах, тархалтыг бууруулах технологийн арга хэмжээг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс санал авах өдрийн дараах өдөр хүртэл авч болно. Гэвч энэ арга хэмжээг ямар үндэслэлээр авах, сүлжээний хандалтыг хэрхэн хязгаарлах, ямар хүрээнд хязгаарлах талаар хуулийн агуулга тодорхойгүй байгаа нь захиргааны байгууллагаас дур мэдэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэлийг тогтоох эрсдэлийг бий болгожээ.

Монгол Улсад хэрэгжиж буй цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад чиглэсэн эрх зүйн актууд нь Монгол Улсын Үндсэн хууль, ИБҮТЭОУП болон хүний эрхийн олон улсын бусад баримт бичгүүдэд тусгагдсан “хуульд үндэслэх, зайлшгүй, зорилгодоо нийцсэн, хуульд нарийвчлан тусгасан, тохирсон буюу пропорциональ байх” зарчмуудад үндэслэгдээгүй байх ба дээрх зарчмуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Дотоодын хууль тогтоомжид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, шаардлагыг ойлгомжтой, тодорхой болгох, хүний эрхийг хязгаарлах зарчмуудад тулгуурлан эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгын хүрээнд Европын Холбоо, ХБНГУ, Эстони Улс, АНУ-ын зохицуулалтыг тухайлан дараах байдлаар судаллаа.

### *1.3.2 Европын Холбооны зохицуулалт*

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах харилцааг Хүний эрхийн тухай Европын Конвенц, Онлайн болон оффлайн орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Европын холбооны хүний эрхийн удирдамж, Дижитал зах зээлийн тухай хууль, Дижитал үйлчилгээний тухай хуулиар тус тус зохицуулдаг.

Хүснэгт 2. Европын Холбооны зохицуулалт

№	Эрх зүйн акт	Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, шаардлага
1	Хүний эрхийн тухай Европын Конвенц	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дараах зорилгоор хязгаарлаж болно. Үүнд:</p> <p>Зорилго 1. Үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, нийтийн аюулгүй байдлыг хангах;</p> <p>Зорилго 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;</p> <p>Зорилго 3. Эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын нэр хүнд, эрхийг хамгаалах;</p> <p>Зорилго 4. Бусдын эрхэд халдахаас сэргийлэх;</p> <p>Зорилго 5. Шүүх эрх мэдлийн хараат бус, ил тод байдлыг хадгалах;<sup>91</sup></p>
2	Онлайн болон оффлайн орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Европын холбооны хүний эрхийн удирдамж	<p>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахад дараах шаардлагыг хангана. Үүнд:<sup>92</sup></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүн бүхэнд нээлттэй, ил тод байдлаар хуулиар хязгаарлалтыг тогтооно.</li> <li>2. Тогтоож буй хязгаарлалт нь ИБУТЭОУП-ын 19.3-т заасан үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, бусдын эрх, нэр хүндийг хамгаалах аль нэг шаардлагад хамаарсан байна.</li> <li>3. Тус эрхийг зайлшгүй хязгаарлах шаардлагатай бөгөөд зорилгодоо хүрэхэд чиглэсэн хамгийн бага түвшний хязгаарлалтыг хэрэгжүүлнэ.</li> <li>4. Эрхийг хязгаарласан агуулга бүхий хуулийн хэрэгжилтийг улс төрөөс ангид байгууллага хангах ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд үндэслэлгүйгээр, дур зоргоороо халдахыг зөвшөөрөхгүй.</li> <li>5. Сэтгүүлч, нийтлэгч нар нь ямар нэг айдасгүйгээр олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл мэдээлэх боломжийг хангах зорилгоор эх сурвалжаа задруулахгүй байх эрхийг хангах үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн байгууллага нь ямар нэгэн цензурээс эмээхгүйгээр аюулгүй, таатай орчинд ажиллах боломжийг олгох ёстой.</li> </ol>
3	Дижитал үйлчилгээний тухай хууль	<p>Дижитал үйлчилгээ эрхлэгч нь санал болгож буй үйлчилгээний нөхцөлд үйлчилгээ авагчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуульд нийцүүлэн хязгаарлах зохицуулалтыг тусгаж байна.</p> <p>Хязгаарлалтын нөхцөл нь бодитой шаардлагад үндэслэгдсэн, пропорциональ зарчимд нийцсэн байна.<sup>93</sup></p>

<sup>91</sup> European convention on human rights, Article 10.2  
[https://www.echr.coe.int/documents/d/echr/convention\\_ENG](https://www.echr.coe.int/documents/d/echr/convention_ENG) Сүүлд хандсан огноо: 2024.07.02

<sup>92</sup> European Union human rights guidelines on freedom of expression: online and offline, 22, 31  
[https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu\\_human\\_rights\\_guidelines\\_on\\_freedom\\_of\\_expression\\_online\\_and\\_offline\\_en.pdf](https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu_human_rights_guidelines_on_freedom_of_expression_online_and_offline_en.pdf) Сүүлд хандсан огноо: 2024.07.02

<sup>93</sup> Digital service act, Article 14  
<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32022R2065> Сүүлд хандсан огноо: 2024.07.02

Европын Холбоо нь цахим орчны онцлогтой уялдуулан дижитал үйлчилгээ эрхлэгчид холбогдох харилцааг зохицуулсан. Дижитал үйлчилгээ эрхлэгч нь тухайн дижитал үйлчилгээг ашигладаг хэрэглэгч (хувь хүн, хуулийн этгээд)-ийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх, тодорхой хязгаарлалт тогтоох орчныг бүрдүүлнэ. Дижитал үйлчилгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хязгаарлалтыг тогтооход хэрэглэгчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон ургалч үзэл, бусад үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ. Мөн хуулийн 17 дугаар зүйлийн дагуу Дижитал үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийн нийтэлсэн мэдээлэл хууль бус агуулгатай эсхүл үйлчилгээний нөхцөл, журамтай нийцэхгүй гэж дүгнэсэн тохиолдолд хязгаарлаж буй үндэслэл, шаардлагыг тусгасан тодорхой, ойлгомжтой тайлбарыг Хэрэглэгчид өгч, дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Тухайн хэрэглэгчийн контентыг устгах, тодорхой мэдээлэлд хандах эрхийг хаах, контентын тоог бууруулах;
- Мөнгөн төлбөрийн үйлчилгээг түдгэлзүүлэх, зогсоох, бусад хязгаарлах арга хэмжээг авах;
- Үйлчилгээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн түр зогсоох, бүрэн зогсоох;
- Хэрэглэгчийн хаягийг хаах;

Дижитал үйлчилгээний тухай хуулийн 51-р зүйлд дижитал үйлчилгээ эрхлэгч нь эрх бүхий байгууллагын шийдвэр, тушаалаар хэрэглэгчийн нэвтрэх эрхийг долоо хоног хүртэл хугацаагаар хязгаарлаж болно.

Европын Холбооны хууль тогтоомжоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь цахим орчинд байхаас үл хамааран хүний үндсэн эрхэд хамаарах тул хуульд заасан үндэслэл шаардлагаас бусад тохиолдолд хязгаарлахыг хориглодог. Хуулиар цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалан баталгаажуулахын зэрэгцээ, тухайн эрхийн хязгаарлалтыг ИБУТЭОУП-д заасан шаардлагад нийцүүлэн тогтоож, холбогдох хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байна.

### 1.3.3 Эстони Улсын зохицуулалт

Эстони Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон цахим орчинд хандах эрхийг цөөн тохиолдолд хязгаарладаг.<sup>94</sup> Эстони Улсын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу хүн бүр үзэл бодол, итгэл үнэмшил болон бусад мэдээллийг үг, хэвлэмэл, зураг болон бусад хэлбэрээр чөлөөтэй түгээх

<sup>94</sup> Comparative study on blocking, filtering and take-down of illegal internet content, pp.193, <https://rm.coe.int/CoERMPublicCommonSearchServices/DisplayDCTMContent?documentId=090000168065497e> Сүүлд хандсан огноо: 2024.07.03



эрхтэй. Энэ эрхийг нийтийн хэв журам, нийтийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хамгаалах зорилгоор хуулиар хязгаарлаж болно.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах гол үндэслэл нь хуулиар хориглосон үйлдэлтэй салшгүй холбоотой. Тиймээс дараах тохиолдолд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хязгаарлагдана. Үүнд:

**Гүтгэлэг, доромжлол:** Эстони Улсын Эрүүгийн хуулийн<sup>95</sup> 247 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Олон Улсын халдашгүй дархан эрхтэй хүн, түүний гэр бүлийн гишүүнийг гүтгэсэн, доромжилсон бол хүнийг торгох ял эсвэл 2 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ”; мөн хуулийн 275 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Олон нийтийн хэв журмыг сахиулах төрийн албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан доромжилсон бол хүнийг гурван зуун нэгжээр торгох, эсхүл баривчлах ялаар шийтгэнэ”; мөн хуулийн 305 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүх болон шүүгчийг шударга ёсыг хэрэгжүүлэхэд оролцсонтой нь холбогдуулан доромжилсон бол хүнийг 300 хүртэл нэгжээр торгох, эсхүл баривчлах ялаар шийтгэнэ.

**Үзэн ядсан үг хэллэг:** Эрүүгийн хуулийн 151 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүнийг үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, хэл, нийгмийн гарал байдал, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, улс төрийн үзэл бодол, санхүүгийн болон нийгмийн байдлаас нь шалтгаалан үзэн ядалт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг олон нийтэд өдөөн турхирч эрүүл мэнд, эд хөрөнгө, амь насанд нь аюул учруулсан бол хүнийг гурван зуу хүртэл нэгжээр торгох, эсхүл баривчлах ялаар шийтгэнэ.

**Харгис хэрцгий байдлыг сурталчлах:** Эрүүгийн хуулийн 180 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар арван найман насанд хүрээгүй хүнд харгис хэрцгий байдлыг сурталчилсан бүтээл, эсвэл бүтээлийн хуулбарыг шилжүүлэх, үзүүлэх, эсвэл түүнийг зориуд мэдэгдэх, эсхүл түүний өмнө амьтан хөнөөх, тарчлаах зэргээр харгислал үзүүлсэн нь хууль ёсны үндэслэлгүйгээр үйлдэгдсэн бол хүнийг 300 хүртэл нэгжээр торгоно.

**Садар самууныг агуулсан, хүчирхийлэл, харгислалыг сурталчилсан бүтээлийг зохицуулах хуулийн**<sup>96</sup> 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар

<sup>95</sup> Penal Code of Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide> Сүүлд хандсан огноо: 2024.07.01

<sup>96</sup> Act to Regulate Dissemination of Works which Contain Pornography or Promote Violence or Cruelty in Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/520012015009/consolide> Сүүлд хандсан огноо: 2024.07.03

телевиз, радио нэвтрүүлэг дамжуулах эрхтэй хүмүүс садар самууныг агуулсан, хүчирхийлэл, харгислалыг сурталчилсан телевиз, радио нэвтрүүлгийг дамжуулахыг хориглоно.

**Хүүхдийн порнограф:** Эрүүгийн хуулийн 178 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар арван найман насанд хүрээгүй хүнийг порнографийн нөхцөлд, эсвэл арван дөрвөн нас хүрээгүй хүнийг порнографийн эсвэл эротик нөхцөлд дүрсэлсэн зураг, бичвэр, эсвэл аливаа бүтээл болон тэдгээрийн хуулбарыг үйлдвэрлэх, олж авах, хадгалах, бусдад дамжуулах, үзүүлэх эсвэл бусад байдлаар бусдад ашиглуулах боломж олгосон бол хүнийг торгох эсвэл гурван жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

**Зохиогчийн эрх зөрчих:** Эрүүгийн хуулийн 222 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зохиогчийн эрх болон түүнтэй холбоотой эрхийг санаатайгаар зөрчиж, мэргэжлийн болон эдийн засгийн үйл ажиллагаанд бараа үйлдвэрлэх, худалдах, түрээслэх, хадгалах, хүргэх буюу худалдаалах үйл ажиллагаа явуулж зөрчлөөс үүссэн ашиг эсвэл хохирлын хэмжээ нь хорин өдрийн хамгийн бага орлогын хэмжээнээс давсан бол хүнийг торгох эсвэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

**Терроризм болон экстремизм:** Тус үйл ажиллагааг дэмжих, уриалах мөн мансууруулах бодис сурталчлахыг хориглодог.

**Мөрийтэй тоглоомын цахим хуудас:** Тус улсын Татвар, гаалийн зөвлөлөөс зөвшөөрөлгүйгээр мөрийтэй тоглоомын сайтуудыг хаах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.<sup>97</sup>

Тус улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, хязгаарлах тухайлсан зохицуулалт байхгүй. Харин онлайн болон оффлайн орчинд аль алинд нь Үндсэн хуулийн үзэл санаа, Эрүүгийн хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрддөг. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад “хуулиар хориглосон” үйлдэл буюу зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл мөн эсэхэд үндэслэдэг онцлогтой.

<sup>97</sup> maksu- ja tolliamet: Blocked domain names of illegal remote gambling, <https://ncfailid.emta.ee/s/6BEtzQAghF4y349> Сүүлд хандсан огноо: 2024.07.08

### 1.3.4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зохицуулалт

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5-р зүйлийн 2-т зааснаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг залуучуудын эрхийг хамгаалах, хүний нэр төрийг хамгаалах зорилгоор урьдчилж тодорхойлсон хуульд зааснаар хязгаарлана.<sup>98</sup> Тус улс нь анх удаа цахим орчинд хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Нийгмийн сүлжээнд хуулийг хэрэгжүүлэх тухай хууль (NetzDG)-ийг баталсан. Тус хуулийг дижитал үйлчилгээ эрхлэгч нар үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг.<sup>99</sup> Дижитал үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээг тус улсын хоёр саяас доошгүй иргэд ашиглаж буй тохиолдолд тухайн нийгмийн сүлжээнд нийтлэгдсэн контент нь ХБНГУ-ын Эрүүгийн хуулийг зөрчсөн бол тус үйлчилгээг 24 цагийн турш хаах үүргийг дижитал үйлчилгээ эрхлэгч хүлээдэг.<sup>100</sup>

Нийгмийн сүлжээнд хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийн 4-р зүйлд зааснаар Дижитал үйлчилгээ эрхлэгч нь тус улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт<sup>101</sup>

<sup>98</sup> Basic Law for the Federal Republic of Germany  
[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_gg/englisch\\_gg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html) Сүүлд хандсан огноо: 2024.07.03

<sup>99</sup> Network enforcement act  
[https://www.gesetze-im-internet.de/netzdg/\\_\\_\\_1.html](https://www.gesetze-im-internet.de/netzdg/___1.html) Сүүлд хандсан огноо: 2024.07.03

<sup>100</sup> Ibis.

<sup>101</sup> Эрүүгийн хуульд заасан дараах гэмт хэргүүд хамаарна.

§86. Үндсэн хууль зөрчсөн, террорист байгууллагын суртал ухуулгын материалыг тараах;

§86a. Үндсэн хууль зөрчсөн, террорист байгууллагын тэмдэг ашиглах;

§89a. Улсад аюул учруулахуйц ноцтой хүчирхийлэлд бэлтгэх;

§91. Төрд аюул учруулахуйц ноцтой хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэх зааврыг нийтлэх;

§100a. Хуурамч баримт бичиг;

§111. Олон нийтийг гэмт хэрэг үйлдэхэд уриалах;

§126. Гэмт хэрэг үйлдэхээр заналхийлж олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах;

§129. Гэмт хэргийн бүлэглэл байгуулах;

§129a. Террорист бүлэг байгуулах;

§129b. Гадаадын гэмт хэрэг, террорист байгууллага салбар болох;

§130. Олон түмнийг турхирсан;

§131. Хүчирхийлэл;

§140. Гэмт хэргийг дэмжих, өдөөн хатгах;

§166. Шашны итгэл үнэмшил, шашны болон үзэл суртлын бүлгүүдийг доромжлох;

§184b. Хүүхдийн садар самууныг харуулсан контентыг түгээх, худалдан авах, эзэмших;

§185. Доромжлох;

§186. Гүтгэлэг;

§187. Нэр төр гутаах;

§189. Нас барсан хүний нэр төрд халдах;

§201a. Гэрэл зураг болон бусад зураг авах замаар хувийн нууцлал, хувь хүний эрхийг зөрчих;

§241. Хүнд төрлийн гэмт хэрэг үйлдэхээр завдсан;

§269. Хотлох ач холбогдолтой мэдээллийг хуурамчаар үйлдэх;

Criminal code of Germany

[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_stgb/englisch\\_stgb.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html) Сүүлд хандсан огноо: 2024.07.03

хамаарах агуулга бүхий контентыг 24 цагийн дотор платформуос устгаагүй тохиолдолд 50 сая евро хүртэлх торгууль ногдуулна.<sup>102</sup>

Үүнээс гадна, тус улс нь 2024 онд Дижитал үйлчилгээний тухай хуулийг баталжээ. Энэхүү хуулиар арилжааны зорилгоор үйл ажиллагаа явуулж буй дижитал үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулдаг. Тус хуулийн 3-р бүлгийн 8-р зүйлд заасны дагуу оюуны өмчийн эрхийг зөрчсөн контентыг хязгаарлах шаардлагыг тодорхойлсон.<sup>103</sup>

### 1.3.5 АНУ-ын холбооны болон мужийн эрх зүйн зохицуулалт

АНУ-ын Үндсэн хуулийн I нэмэлтээр үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулсан. Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой улсын онцлогийг харгалзан, шүүхийн жишиг буюу прецедентээр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эсэхийг дүгнэсэн дараах тохиолдлуудыг судаллаа.

**Заналхийлэл (True Threats) агуулсан контентыг хязгаарлана.** Энтони Элонис нь “Өөрийн хамтран ажиллагсад, салсан эхнэр, цэцэрлэгийн ангийнхан, цагдаа, болон Холбооны мөрдөх товчооны төлөөлөгчийг гэмтээнэ.” гэсэн сүрдүүлгийг Фэйсбүүк дээр нийтэлсэн. Уг үйлдэл нь Холбооны заналхийллийн эсрэг хуулийн §875(с)-ыг зөрчсөн гэж үзжээ. Дүүргийн шүүхийн тангарагтны шүүгчид “заналхийлэл” нь Үндсэн хуулийн I нэмэлт өөрчлөлтийн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрхийн хамгаалалтын хүрээнд хамаарахгүй гэж дүгнэсэн. Элонис давж заалдсан бөгөөд АНУ-ын Дээд шүүхээс Элонисыг буруутай болохыг баталж, өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. АНУ-ын Дээд шүүхийн шийдвэрээр цахим орчин дахь заналхийлсэн илэрхийлэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэлд хамаарч байна гэж үзжээ.<sup>104</sup>

**Садар самуун явдлын (Obscenity) илэрхийлэл хязгаарлагдана.**<sup>105</sup> Калифорнийн эсрэг Миллерийн хэрэг (1973). Калифорни мужийн Ковина хотын хэвлэн нийтлэгч Марвин Миллер насанд хүрэгчдийн материалыг худалдахыг сурталчлах зорилгоор 1968 онд дөрвөн ном болон “Гэр бүлийн харилцаа”

<sup>102</sup> Network Enforcement Act

<https://www.gesetze-im-internet.de/netzdg/NetzDG.pdf> Сүүлд хандсан огноо: 2024.07.03

<sup>103</sup> Digital Service Act

<https://www.gesetze-im-internet.de/ddg/BJNR0950B0024.html> Сүүлд хандсан огноо:2024.07.05

<sup>104</sup> *Elonis v. United States*, 575 U.S. 723 (2015)., <https://firstamendment.mtsu.edu/article/elonis-v-united-states/>, Facts and Case Summary, <https://www.uscourts.gov/educational-resources/educational-activities/facts-and-case-summary-elonis-v-us>

<sup>105</sup> *Miller v. California* (1973), <https://firstamendment.mtsu.edu/article/miller-v-california/>

нэртэй киноны зарыг цахим шуудангаар илгээсэн байна. Миллерийн илгээсэн товхимлыг хүлээн авахыг хүсээгүй зарим хүмүүс цагдаад гомдол гаргаснаар “Садар самуун материал тараахыг хориглосон Калифорнийн хуулийг зөрчсөн хэргээр буруутгагдсан. Тангарагтны шүүх Миллерийг садар самуун мэдээ тараахыг хориглосон Калифорнийн хуулийн дагуу буруутгасан байна. Миллер дээрх зар сурталчилгаа нь садар самуун биш гэж маргаж АНУ-ын Дээд шүүхэд хандсан. АНУ-ын Дээд шүүхээс түүнийг буруутай гэж үзсэн байна. Шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг садар самуун материалууд I нэмэлтийн хамгаалалтад хамаарахгүй гэж тайлбарлажээ. АНУ-ын Дээд шүүхийн Калифорнийн эсрэг Миллерийн хэргийг шийдсэн шийдвэрийн нэрээр Миллерийн тест<sup>106</sup> нь гурван шалгуурыг өөртөө багтаадаг. Үүнд:

- Тухайн цаг үеийн нийтийн жишиг стандартыг хэрэгжүүлдэг жирийн хүн уг бүтээлийг бүхэлд нь авч үзэхэд садар самууныг уриалсан эсэх;
- Уг бүтээл нь муж улсын холбогдох хуулиар тусгайлан тодорхойлсон бэлгийн зан үйлийг илт доромжилсон байдлаар дүрсэлсэн эсвэл тодорхойлсон эсэх;
- Бүтээлийг бүхэлд нь авч үзвэл утга зохиол, урлаг, улс төр, шинжлэх ухааны илэрхийлэл үндсэндээ агуулаагүй эсэх шалгуураар шүүн үзсэн байна.

**Гүтгэлэг (Defamation)** 1960-аад оны Иргэний эрхийн хөдөлгөөний үеэр Нью-Йорк Таймс худал мэдүүлэг өгсөн хэргээр Мартин Лютер Кингийг хамгаалахаар хандив цуглуулах тухай зарыг нийтэлжээ. Нийслэлийн олон нийтийн аюулгүй байдлын комиссар Л.Б. Салливан зар сурталчилгаанд дурдаагүй байсан ч түүний удирдлагад хамаарах доод шатны албан тушаалтнуудыг нь шүүмжилсэн, түүнийг бас гүтгэж байна гэж маргажээ. Салливан Нью-Йорк Таймс-ын эсрэг гүтгэлгийн хэрэг үүсгэсэн бөгөөд мужийн шүүхээс түүнд 500,000 доллар нөхөн төлүүлэх шийдвэр гаргасныг мужийн Дээд шүүх шийдвэрээр хэвээр үлдээсэн байна. Улмаар Нью-Йорк Таймс АНУ-ын Дээд шүүхэд давж заалдах гомдол гаргасан.

АНУ-ын Дээд шүүхээс I нэмэлтийн дагуу төрийн албан тушаалтнууд гүтгэсэн мэдэгдлийг *"зориуд санаатайгаар"* эсвэл *"худал байсан гэдгийг шалган мэдэх боломжтой буюу үнэн зөв эсэхийг шалгахгүй мэдээллийг нийтлэх шийдвэр гаргахдаа болгоомжгүй"* байсныг нотлох хүртэл гүтгэсний улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлж чадахгүй гэж үзсэн байна. Салливаны эсрэг Нью-Йорк Таймсын хэргийг шийдсэн АНУ-ын Дээд шүүхийн шийдвэр нь АНУ-д гүтгэлгийн

<sup>106</sup>Miller test, <https://firstamendment.mtsu.edu/article/miller-test/>

хуулийг боловсруулахад нөлөөлсөн жишиг тогтоосон. Хүмүүс болон хэвлэл мэдээллийн байгууллагууд хуулийн хариуцлагаас айхгүйгээр төрийн өндөр албан тушаалтнууд, олон нийтийн анхаарлыг татсан асуудлаар мэдээлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан юм.<sup>107</sup>

### **Өдсөн үг хэллэг (Fighting words): Нью Хэмпширийн эсрэг Чаплинскийн хэрэг (1942)**

Дээд шүүх үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хамгаалалт болсон Үндсэн хуулийн I нэмэлтийн хүрээнд хамгаалагдахгүй зарим төрлийн үг хэллэгийг тодорхойлсон бөгөөд үүнд "өдсөн үгс (Fighting words)"-ийг хамааруулсан. Энэ тайлбар нь Дээд шүүхийн Нью Хэмпширийн эсрэг Чаплинский (1942) хэргээс үүсэлтэй. Рочестер хотын төвд олон нийтийн явган хүний зам дээр Уолтер Чаплинский "Еховагийн Гэрч" буюу түүний итгэл үнэмшлийг дэмжсэн зохиол тарааж байв. Чаплинский тухайн зохиолд хотын даргыг "бурхны хараал идсэн рекетчин", "хараал идсэн фашист" гэж нэрлэжээ. Дээд шүүхээс Чаплинскийн доромжилсон үгс нь шууд хэн нэгэн рүү чиглэсэн, хор хохирол учруулах "өдсөн үгс (Fighting words)"-д хамаарах тул Үндсэн хуулийн хамгаалалтад хамаарахгүй гэж тайлбарлажээ.<sup>108</sup>

Сонгон авсан тохиолдлууд нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах асуудалд жишиг тогтоосон бөгөөд заналхийлэл, садар самуун, тэмцлийн хурц үгсийг ашигласан бусдын эрхийг зөрчсөн контентыг хязгаарлах нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчилд тооцохгүй байна. Харин үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагад аливаа цензур тавихгүй байх зарчмын дагуу мэдээллийг чөлөөтэй нийтлэх эрх зүйн хамгаалалтыг шүүхийн жишгээр тогтоожээ.

<sup>107</sup> New York Times v. Sullivan (1964), <https://www.oyez.org/cases/1963/39>

<sup>108</sup> Chaplinsky v. New Hampshire, 315 U.S. 568 (1942) <https://supreme.justia.com/cases/federal/us/315/568/>

### 1.3.6 Олон нийтийн сүлжээний платформын хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ (Community Standards)

Гадаад улс орнуудын хууль тогтоомжуудад цахим орчинд үйлчилгээ үзүүлж буй дижитал үйлчилгээ эрхлэгчээс хэрэглэгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой зохицуулалт нь нийтлэг байгаа нь ажиглагдаж байна.

GlobalStats дах 2024 оны 06 дугаар сарын тоон мэдээллээс үзвэл, Монгол Улсын нийт дижитал үйлчилгээ хэрэглэгчдийн 82.94 хувь нь Фейсбүүк, 7.21 хувь нь Pinterest, 3.47 хувь нь Youtube, 2.81 хувь нь Instagram, 2.32 хувь нь Twitter, 0.8 хувь нь Reddit платформыг тус тус ашиглаж байна.<sup>109</sup> Тиймээс Монгол Улсад нийтлэг ашиглагддаг Фейсбүүк платформд хэрэглэгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах үндэслэлийг хэрхэн тодорхойлсныг авч үзье.

Фейсбүүк платформ нь дижитал үйлчилгээ үзүүлэгч Мета компанид харьяалагддаг. Мета нь хууль бус болон өөрийн журамд нийцэхгүй агуулга бүхий контент, зураг, бичлэг зэргийг устгах, хэрэглэгчийн нэвтрэх эрхийг хаах зэрэг арга хэмжээ авч хүний эрхийг хамгаалдаг. Мета нь фэйсбүүк хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ болох Фейсбүүк Community Standards<sup>110</sup>-тай бөгөөд энэ журамд заасны дагуу Фейсбүүк-н нийтлэлд дараах хязгаарлалт тавигддаг байна. Үүнд:

<sup>109</sup><https://gs.statcounter.com/social-media-stats/all/mongolia>

<sup>110</sup> Фэйсбүүк community standards

<https://transparency.meta.com/ru-ru/policies/community-standards/?source=https%3A%2F%2Fwww.Фэйсбүүк.com%2Fcommunitystandards> Сүүлд хандсан огноо: 2024.07.02

### Хүснэгт 3. Фейсбүүкийн журмаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан байдал<sup>111</sup>

№	Хязгаарлах үндэслэл	Хамаарах тохиолдол, авах арга хэмжээ
1	Хүчирхийлэл, гэмт хэргийн шинжтэй үйлдэл	<ul style="list-style-type: none"> <li>- Гэмт хэргийг сурталчилсан мэдээллийг бүрэн устгана.</li> <li>- Олон нийтэд аюул бүхий хүн, хуулийн этгээдийг алдаршуулах, төлөөлөх, дэмжихтэй холбоотой хандах эрхийг хаана.</li> <li>- Залилан буюу платформын хэрэглэгч эсвэл бизнесийн үйл ажиллагаанд хор хохирол учруулж, төөрөгдүүлж болзошгүй гуравдагч этгээдийн контентыг устгана.</li> <li>- Хориотой бүтээгдэхүүн үйлчилгээ буюу хар тамхи, зэвсэг худалдаа, хүний бие болон эд эрхтэн наймаалах агуулга бүхий мэдээлэл нийтлэх хориотой.</li> <li>- Хүчирхийлсэн болон хүчирхийллийн шинжтэй контентыг платформоос устгах арга хэмжээ авна.</li> </ul>
2	Аюулгүй байдалд халдсан	<ul style="list-style-type: none"> <li>- Насанд хүрэгчийн бэлгийн мөлжлөг, бэлгийн дур хүсэл агуулсан бүхий зураг бичлэг, постыг нийтлэх нь хориотой.</li> <li>- Дээрэлхсэн, дарамталсан агуулга бүхий контентыг платформ дээр байрших хэрэглэгч нарын мэдээлэх хэсгээр дамжуулан устгадаг.</li> <li>- Хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, нүцгэн зураг, бичлэг зэргийг устгадаг.</li> <li>- Хүний наймаа буюу хүүхэд худалдах, хууль бусаар үрчлэх, албадан гэрлэлт, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтэн худалдах, шилжүүлэх, албадан гэмт хэрэг үйлдүүлэх зэрэг мэдээлэл нийтлэхийг хориглодог.</li> <li>- Өөрийн болон бусдын хувийн нууцтай холбоотой мэдээлэл нийтлэхийг хориглодог.</li> <li>- Амиа хорлох, өөрийгөө гэмтээх зэргийг харуулсан, ийм үйлдэл хийсэн, хийхийг дэмжсэн, зааварчилгаа өгсөн зэрэг нийтлэл оруулахыг хориглодог.</li> <li>- Эрүүл бус аргаар жин хасах аргыг олон нийтэд түгээх нь хориотой.</li> </ul>
3	Зөрчилтэй контент	<ul style="list-style-type: none"> <li>- Насанд хүрэгчдийн нүцгэн зураг, бэлгийн харьцааг харуулсан, дүрсэлсэн мэдээллийг устгадаг.</li> <li>- Биеэ үнэлэлтийг зуучлахтай холбоотой мэдээлэл, порнограф үйл ажиллагаа, тайчих клубийн шоу, амьд секс тоглолт эсвэл эротик бүжиг, массаж зэргээр илт бэлгийн дур хүслийг өдөөх агуулгатай мэдээллийг нийтлэх нь хориотой.</li> <li>- Хүнийг арьс өнгө, үндэс угсаа, бэлгийн чиг баримжаа, хүйс болон бусад байдлаар ялгаварлан гадуурхах, бусдыг айлган сүрдүүлэх, гадуурхаж тусгаарлах зорилгоор үзэн ядсан үг хэллэг ашиглахыг хориглодог.</li> <li>- Хүчирхийлэл, жихүүцэл төрүүлсэн буюу фейсбүүк хэрэглэгчдийн сэтгэл түгшээсэн контентыг нууж, устгадаг. Жишээ нь: хүн, амьтныг хэрцгийгээр зовоон тарчлаасан контент хамаарна.</li> </ul>

<sup>111</sup> Ibis.



№	Хязгаарлах үндэслэл	Хамаарах тохиолдол, авах арга хэмжээ
4	Бодит байдалд нийцэхгүй, ил тод байдлын шаардлагыг хангаагүй	<ul style="list-style-type: none"> <li>- Бусдыг төөрөгдүүлэх, хууран мэхлэх зорилгоор олон удаа нэр, нас, болон бусад хувийн мэдээллээ өөрчлөх, бусдын зургийг зөвшөөрөлгүй нийтлэх зэрэг үйлдэлд хаягийг хаах арга хэмжээ авдаг.</li> <li>- Кибер аюулгүй байдлын хүрээнд хууль бус контент нийтэлж, хуваалцах, төлөөлөх, татаж авах зэргийг хязгаарладаг.</li> <li>- Олон хаяг зэрэг ашиглах, бусдыг дарамтлах зэрэг үйлдлийг энэхүү журамд зөвшөөрөхгүй ба устгадаг.</li> <li>- Хүн нас барахад тухайн хүний хаягийг ойр дотнынхны хүсэлтийн дагуу “дурсах” тохиргоонд шилжүүлж, нэвтрэх оролдлогыг хаадаг.</li> <li>- Хүчирхийлэл агуулсан, сонгуулийн үеэр хөндлөнгийн нөлөөлөл бүхий, захиалгат мэдээ зэргийг устгах арга хэмжээ авна.</li> <li>- Спам буюу маш өндөр давтамжтай бэлэг бэлэглэх, бараа зарах контент нийтлэх зэрэг үйлдлээс үүдэн хязгаарлалт тогтоож болно.</li> </ul>
5	Оюуны өмчийг зөрчсөн	<ul style="list-style-type: none"> <li>- Оюуны өмч, зохиогчийн эрх болон барааны тэмдгийн эрх зөрчсөн үйлдлийг эрх эзэмшигч эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлтээр устгаж, хязгаарлана.</li> <li>- Мета нь оюуны өмч, лицензийн эрхэд халдсан агуулга бүхий контентыг устган, ахин бүртгэл үүсгэх эрхийг хязгаарлана.</li> </ul>
6	Тухайн мэдээлэлтэй холбогдох хэрэглэгчийн хүсэлт	<ul style="list-style-type: none"> <li>- Насанд хүрээгүй хэрэглэгчийн нэмэлт хамгаалалт - хэрэглэгч, Засгийн газар, хууль сахиулах байгууллага эсвэл хүүхдийн байгууллагын хүсэлтээр насанд хүрээгүй хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учирч болзошгүй контентыг устгана.</li> <li>- Улс орны хүрээнд хууль бус контент, бараа, үйлчилгээний талаар Засгийн газар, төрийн бус байгууллагын мэдээлснээр шалгаж, өөрсдийн хяналтын дүнд эсвэл шүүхийн шийдвэрээр хязгаарлана.</li> <li>- Хэрэглэгчийн хүсэлтээр бүртгэлийг устгах эсвэл татгалзах, нэмэлт тодруулга шаардах арга хэмжээ авна.</li> </ul>

Тухайн хэрэглэгчийн платформ дээр оруулсан мэдээлэл нь платформын хэм хэмжээг хэрхэн зөрчсөнөөс шалтгаалж үр дагавар янз бүр байна. Жишээ нь: Зөрчил гаргасан эхний тохиолдолд сануулга өгөх ба хэрэв зөрчлийн тоо нь олон давтагдвал платформ ашиглах эрхийг нь хязгаарлах, эсхүл профайл хаягийг нь хүчингүй болгох зэрэг арга хэмжээ авна. Мөн бие махбодын бодит эрсдэл учруулахуйц, олон нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулах агуулга бүхий хэмээн үзвэл хууль сахиулах байгууллагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авхуулна.<sup>112</sup>

Бусад улсын хууль тогтоох байгууллага болон олон нийтийн сүлжээний

<sup>112</sup> Харилцаа Холбооны Зохицуулах Хороо: Фэйсбүүк хэрэглэгчдийн дагаж мөрдөх хэм хэмжээ, <https://crc.gov.mn/list/internetijn-s-lzhee-jlchilgee/mn?show=145> Сүүлд хандсан огноо: 2024.07.04

платформын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй зохицуулалт нь Иргэний болон улс төрийн олон улсын пактад тодорхойлсон бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагуудад үндэслэгддэг. Мөн цахим орчин, интернэтийн хэрэглээг хязгаарлах, цензур тогтоох г.м нэмэлт шаардлагуудыг тодорхойлоогүй байна.

#### 1.4 Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээг авах эрх бүхий субъектүүд

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 22.1.3-т зааснаар мөрдөгч нь прокурорын зөвшөөрлөөр харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах ажиллагааг хийнэ.<sup>113</sup> Харилцаа холбооны зохицуулах хороо нь харилцаа холбооны сүлжээнд нэвтрэхийг хязгаарлах тухай прокурорын зөвшөөрөлтэй мөрдөгчийн тогтоолыг биелүүлэх үүрэг хүлээнэ. Мөн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага: Интернэтийн үйлчилгээнд” журмын 3.8-д интернэтийн үйлчилгээ эрхлэгчид Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д заасны дагуу насанд хүрэгчдэд зориулсан контент (+18)-д хандах хандалтыг хязгаарлах (системийн эсвэл программ хангамжийн) үйлчилгээтэй байх, мөн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг агуулгатай контентыг хадгалах, түгээхийг хориглож, энэ тохиолдолд Зохицуулах хорооноос шаардсаны дагуу тухайн контентын Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлахаар заасан.<sup>114</sup>

<sup>113</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) <https://legalinfo.mn/mn/detail/12694> Сүүлд хандсан: 2024.07.08

<sup>114</sup> Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.04.29-ний өдрийн №23 дугаар тогтоолын хавсралт, “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (интернэтийн үйлчилгээнд). [https://www.crc.gov.mn/storage/busad/nuhtsul%20shaardlag/2020\\_23\\_Togtool%20-%20%D0%98%D0%BD%D1%82%D0%B5%D1%80%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD%20%D2%AF%D0%B9%D0%BB%D0%B8%D0%B%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B4%20\(1\).pdf](https://www.crc.gov.mn/storage/busad/nuhtsul%20shaardlag/2020_23_Togtool%20-%20%D0%98%D0%BD%D1%82%D0%B5%D1%80%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD%20%D2%AF%D0%B9%D0%BB%D0%B8%D0%B%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B4%20(1).pdf) Сүүлд хандсан огноо: 2024.07.05

Харилцаа холбооны зохицуулах хороо нь иргэн, аж ахуй нэгж байгууллага цахим орчин дах хууль бус контентын талаар гомдол хүсэлт гаргаснаар хууль зөрчсөн эсэхийг тогтоохгүй ч, хууль, тогтоомж зөрчсөн тухай албан бичиг, дүгнэлт, шийдвэрийг үндэслэн дараах арга хэмжээг авах талаар дижитал үйлчилгээ эрхлэгчдэд мэдэгддэг.<sup>115</sup> Үүнд:

1. Мэдэгдэлд дурдсан хууль зөрчсөн контентыг устгах эсвэл хандалтыг хязгаарлах;
2. Мэдэгдэлд дурдсан хууль зөрчсөн цахим хаяг, цахим хуудсыг зөрчил арилгах хугацаанд хандалтыг хязгаарлах;
3. Хэрэв мэдэгдэлд дурдсан хугацаанд зөрчлийг арилгаагүй эсхүл цахим үйлчилгээ эрхлэгчтэй холбоо тогтоох боломжгүй бол үүрэн холбооны болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчдээр дамжуулан зөрчил арилах хүртэл DNS системийн бүртгэлээр Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээг авна.

Монгол Улсын хувьд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой харилцаанд Харилцаа холбооны зохицуулах хороо гол үүрэг гүйцэтгэдэг. Харин Эстони Улсад Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, техникийн зохицуулалтын газар (CPTRA<sup>116</sup>) нь цахим орчинд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, интернэтийн үйлчилгээнд хяналт тавих үүргийг хүлээж, цахим орчинд дээр дурдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хориглосон агуулгыг нийтэлсэн тохиолдолд хяналт тавьж ажилладаг. Тус байгууллагаас гадна, Хэрэглэгчийн эрх, технологийн зохицуулалтын газар (ТТЈА) нь тус улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүргийг хариуцдаг. Тус газар нь Европын холбооны 2022/350 тоот тогтоолын дагуу ОХУ болон Украйны дайнтай холбоотой ОХУ-н 50 гаруй цахим хуудас, 40 гаруй телевизийн сувагт БНЭУ-аас хандах эрхийг хаажээ.<sup>117</sup>

Цахим орчин дах сонгуулийн сурталчилгааг тухайлан зохицуулсан Канад Улс нь сонгуулийн үеэр хараат бус, бие даасан Олон нийтийн сүлжээний сонгуулийн

<sup>115</sup> Цахим орчны зохицуулалт зөвлөмж, Харилцаа Холбооны Зохицуулах хороо <https://crc.gov.mn/articles/slug12102/mn> Сүүлд хандсан огноо: 2024.07.04

<sup>116</sup> The Consumer Protection and Technical Regulatory Authority, Эстониар Tarbijakaitse ja Tehnilise Jdrevalve Amet (ТТЈА)

<sup>117</sup> ХЗҮХ: Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал судалгааны тайлан, 2022 он, 34 дэх тал. <https://sudalгаа.gov.mn/download/tsakhim-orchin-dakh-khniy-erkhiyn-erkhiyn-zrchil-xka> Сүүлд хандсан огноо: 2024.07.05

ажиглалтын хэлтсийг ажиллуулдаг.<sup>118</sup> Тус хэлтэс нь Фейсбүүк, Twitter, Youtube, LinkedIn, Tumblr, WeChat, Snapchat, TikTok зэрэг платформуудад хяналт тавьдаг аж.<sup>119</sup>

Хуулиар тодорхойлсон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд аливаа улсын дотоодын эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас гадна олон нийтийн сүлжээний платформуудтай хамтран ажиллах, тухайлсан тохиолдлуудад бие даасан хараат бус нэгжийг ажиллуулах шаардлага үүсжээ.

---

<sup>118</sup> CBC., Social media users voiced fears about election manipulation during 2019 campaign, says Elections Canada., <https://www.cbc.ca/news/politics/elections-canada-social-media-monitoring-findings-1.5444268>., Сүүлд хандсан огноо: 2024.07.05.

<sup>119</sup> Ibis.

## ХОЁР. ЦАХИМ ХУУДСЫГ ХААХ ЗАМААР ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХЯЗГААРЛАСАН ШИЙДВЭРҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 2.1. Монгол Улс

#### *2.1.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим хуудсыг хааж, хандалтыг хязгаарлаж буй тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл*

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn-д 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2024 оны 7 дугаар сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд Эрүүгийн хуулийн 13.14.1 дүгээр зүйлд заасан худал мэдээлэл тараах гэмт хэргээр зүйлчилсэн нийт 89 шүүхийн шийдвэрээс “цахим орчинд” гэх түлхүүр үгээр хайхад 76 шүүхийн шийдвэрийн илэрцтэй байна. Үүнээс уг төрлийн гэмт хэргийн дийлэнх нь цахим орчинд үйлдэгдсэн болохыг харж болно.

“Худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт 1) 450,000-1,300,000 төгрөгөөр торгох; 2) 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх; 3) 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Шүүх зөвхөн хуульд тодорхойлсон дээрх эрүүгийн хариуцлагын төрлөөс сонгож ял ногдуулах бөгөөд бусад төрлийн албадлагын арга хэмжээ тухайлбал, цахим орчинд тодорхой хязгаарлалт хийх зохицуулалт байхгүй.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурорын зөвшөөрлөөр харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох дараах хэлбэрүүдийг мөрдөгч хэрэгжүүлэх боломжтой:

- харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох
- харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах

- харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах
- харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах
- харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах

Дээрхээс “харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх эрхийг хязгаарлах” буюу аливаа хувь хүн Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг шүүхээс тогтоож шийдвэр гаргаагүй байхад түүний Үндсэн хуулиар баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хязгаарлах үр дагаврыг зохицуулалтын хувьд үүсгэжээ.

Уг зохицуулалтыг практикт хэрэгжүүлсэн нь нийтэд ил болсон дараах тохиолдол гарсан.

#### Кейс 1.

Цагдаагийн Ерөнхий Газраас 2023 оны 12 дугаар сард сэтгүүлч \*\*\*-г цахим сүлжээнд илт худал мэдээлэл тараасан гэх үндэслэлээр түүний мэдээллийн цахим хуудас, пэйж хуудас болон хувийн профайлыг Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарласан асуудлаар олон нийтийн сүлжээнд мэдэгдэл гаргасан. Тус мэдэгдэлдээ:

- Өнөөдрийн байдлаар иргэн \*\*\*-д холбогдуулан Шүүхийн Ерөнхий Зөвлөл болон бусад иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу олон нийтийн цахим сүлжээнд худал мэдээлэл тараасан, мөрдөн байцаалтын нууц задруулсан, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлсэн, хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээлэл тараасан зэрэг Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдлүүдийг шалгаж байна...
- \*\*\* нь \*\*\*\* сайтаар дамжуулан олон удаа иргэдийг төөрөгдөлд оруулах худал мэдээлэл тарааж, цахим сайтыг гэмт хэрэг үйлдэх хэрэгсэл болгон ашигласан, мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байхад удаа дараа ташаа мэдээлэл нийтэлж байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар прокурорын зөвшөөрлөөр харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах, мөрдөн шалгах ажиллагаа явуулж шалгах шаардлага үүссэн. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны нэг хэлбэр юм... гэжээ.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн прокурорын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 116 тоот “Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай” зөвшөөрлөөр “Сэтгүүлч \*\*\* нь ...олон нийтийг төөрөгдүүлсэн илт худал мэдээллүүдийг олон нийтийн цахим сүлжээ буюу фейсбүүк орчинд тараасан гэх эрүүгийн хэрэгт “\*\*\*\*\*” гэх фейсбүүк пэйж хуудас, “\*\*\*\*\*” цахим хуудасны Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авах буюу харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах газарт даалгаж явуулах нь хэрэгт ач холбогдолтой байх тул мөрдөгчийн саналыг хүлээн авах нь зүйтэй” гэж үзэн, прокурорын зөвшөөрлийн дагуу ЦЕГ-ын мөрдөн байцаах албанаас сэтгүүлч \*\*\*-ийн цахим хуудас, профайлыг хаалгах тухай албан бичгийг ирүүлснийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо холбогдох технологийн арга хэмжээг авчээ.

Цахим хуудас болон олон нийтийн сүлжээний платформд хаяг, хуудас нээж, тухайн цахим хуудас, хаяг, хуудсаар дамжуулан мэдээ, мэдээлэл түгээж, нийтэлж буй нь цахим орчинд үзэл бодлоо илэрхийлж буй хэлбэр тул хандалтыг хязгаарласан арга хэмжээ нь зөвхөн тухайн хувь хүний эрхээс гадна, мэдээллийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүлээн авах бусад этгээдийн эрхийг хязгаарлах үр дагавартай. Үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төрд халдаж, худал мэдээлэл тарааж, төөрөгдүүлсэн бол Эрүүгийн болон Иргэний хуульд заасны дагуу хариуцлага хүлээх, хохирол барагдуулах замаар уг эрх чөлөөг хязгаартай эдлэх нөхцөлийг хуульчилдаг нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 3-т *“Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй”* гэж заасанд нийцнэ. Харин үзэл бодлоо илэрхийлсэн нь хууль бус буюу гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгах ажиллагааны явцад эрх чөлөөг нь хязгаарлах эрхийг прокурорт олгосон хуулийн дээрх зохицуулалт нь цахим орчинд ч үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх хууль зүйн баталгааг хангах тухай Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т *“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”* гэж заасанд нийцэхгүй байна.

Цаашлаад прокурорын зөвшөөрөл олгосон энэ үйлдэлд дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй<sup>120</sup> боловч үндсэн эрхийг хязгаарласан гэх үндэслэлээр хууль тайлбарлах эрх бүхий “шүүх”-д гомдол гаргах боломжгүй. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйлд заасан шүүхэд гомдол гаргах үндэслэлд хамаарахгүй. Ийнхүү үндсэн эрхээ хязгаарлагдаж буйг шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлэх Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан *“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах...”* эрхийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн байна.

<sup>120</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаарх гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.

**Кейс 2.**

Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2023 оны 12 дугаар сарын 1-ний өдөр “Прокурорын саналыг хүлээн авахаас татгалзсан тухай” шүүгчийн захирамжийг гаргажээ.<sup>121</sup> Прокурорын таслан сэргийлэх арга хэмжээ авхуулах саналд: “...Яллагдагч \*\*\*-ийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авах \*\*\* гэх **фейсбүүк хаяг, \*\*\* гэсэн сайтуудаар дамжуулан хэргийн талаар мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулсан, мөн шууд утастай лайв бичлэг хийж**, иргэдээс шууд сонсох ажиллагааг \*\*\* олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мөрдөх байгууллагад нөлөөлөх зорилгоор иргэд олон нийт болон бусад сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг уриалан, турхирсан үйл ажиллагааг зохион байгуулж яллагдагчийн хуулиар хүлээсэн үүргээ зөрчиж, мөрдөх байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагаанд саад учруулах нөхцөл байдал бий болгож байх тул тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх...” гэж тусгасан. Шүүхээс: “прокурорын дээрх санал, оролцогч нарын шүүхийн хэлэлцүүлэгт гаргасан тайлбар, хавтаст хэрэгт цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтууд зэрэгтэй танилцахад яллагдагч мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлснээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан буюу мөрдөн шалгах ажиллагааг хуулийн хүрээнд явуулахад саад учруулах нөхцөл байдал тогтоогдоогүй байна. Харин хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх гэсэн таслан сэргийлэх арга хэмжээг шүүхээс авах боломжгүй юм. Энэ нь яллагдагчаар татагдсан этгээдийн хуулиар хүлээсэн үүрэг” гэж дүгнэсэн. Мөн “Яллагдагч \*\*\* нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 заалтад заасан “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад санаатай саад учруулахгүй байх”, мөн зүйлийн 1.5-д заасан “оролцогч, бусад оролцогчид нөлөөлөхгүй байх” яллагдагчийн хуулиар хүлээсэн үүргийг зөрчсөн байх бөгөөд үүргээ ахин зөрчих, мэргэжлийн үйл ажиллагаагаа ашиглан **олон нийтийг төөрөгдүүлэх, тодорхой үйлдэлд уриалах, жагсаал цуглаан зохион байгуулах, хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг гутаах, доромжлох зэргээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахуйц үйлдлийг хийх нь яллагдагчид хуульд заасны дагуу албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх, түүнд авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болохыг анхаарах нь зүйтэй” талаар дурдаж, яллагдагч \*\*\*-т тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хэргийн талаар цахим орчинд хандах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.**

Яллагдагчид хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг дараах хүрээнд хэрэгжүүлэхээр хуульд заасан<sup>122</sup>:

<sup>121</sup> Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх., Шүүхийн шийдвэрийн тойм: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Сувд-Эрдэнэ., 2023.12.01.

<sup>122</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.



1. Тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах;
2. Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах;
3. Тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох;
4. Тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгах;

Харин тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг “төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэх”<sup>123</sup> гэх хүрээгээр хязгаарлах боломжтой.

Хуулийн зохицуулалтаас үзвэл дээрх таслан сэргийлэх арга хэмжээнүүдэд цахим орчин, харилцаа холбооны сүлжээнд хандах эрхийг хязгаарлах агуулгагүй байна. Мөн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэлтэй байлаа ч энэ нь тухайн хүнийг цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хөндөх учиргүй юм. Тиймээс өмнөх кейсээс ялгаатай нь таслан сэргийлэх арга хэмжээг хуульд заасан үндэслэл, агуулгаар хэрэгжүүлж буй эсэхэд шүүхээс хяналт тавьж байгаа учир уг ажиллагааг хууль зөрчин хэрэгжүүлэх замаар яллагдагчийн үндсэн эрхийг хязгаарлах явдлыг таслан зогсоох боломжтой байна.

### *2.1.2 Сонгуулийн сурталчилгааны үеэр цахим хуудсыг хаасан тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл*

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэн 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш шүүхийн шийдвэрийн нээлттэй санд шүүлт хийж үзэхэд сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө “сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт холбогдуулан шүүхийн шийдвэрээр<sup>124</sup> эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн тохиолдол гараагүй байна.<sup>125</sup>

<sup>123</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналыг харгалзан шүүхийн зөвшөөрлөөр авч болно.

<sup>124</sup> Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)-аас Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.1 болон 14.8.2 дах хэсгүүдээр зүйлчилж, хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээр хайлт хийхэд 2015 оноос 2024 оныг хүртэлх хугацаанд нэг ч хэрэг хянан шийдвэрлэгдээгүй байна.

<sup>125</sup> Нээлттэй Нийгэм Форум, Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг, “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик”, УБ., 2021. [https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformation%20Crime\\_Web%20version.pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformation%20Crime_Web%20version.pdf) Сүүлд хандсан: 2024.07.22.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа хийсэн мэдээлэлд дурдсанаар Мета компанитай хамтран хууль зөрчсөн 403 контентыг хязгаарлажээ. Уг хязгаарлалтыг “Ногоон суваг (Government-Case-Work-Channel)”-ийн хүрээнд Фейсбүүк платформ дах аливаа контентыг хууль зөрчсөн гэж үзсэн цагдаа, тагнуул, эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн тухайн контентыг хязгаарлах, устгуулах хүсэлтийг Мета руу илгээх замаар хэрэгжүүлсэн.<sup>126</sup> Эрх бүхий байгууллагын санал дүгнэлт нь ихэвчлэн нэр дэвшигчийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэхийг хориглох, бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг хориглох гэснийг зөрчсөн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулахыг хориглох заалтуудыг зөрчсөнтэй холбоотой байсныг дээрх мэдээлэлд дурджээ.

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 7 дах хэсэгт заасны дагуу хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороо цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг хаах, цахим хуудсыг хаах, эсхүл түр хязгаарлах арга хэмжээ авах эрхтэй. Эдгээр арга хэмжээг авахдаа тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар<sup>127</sup> цахим орчинд сонгуулийн сурталчилгааг хууль зөрчиж явуулж буй талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн шийдвэр бүхий албан бичгийг үндэслэнэ.

Дээрх зохицуулалтын хүрээнд цахим орчинд үзэл бодлоо илэрхийлсэн нь нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээлэл байсан эсэх дүгнэлт, шийдвэрийг “шүүх” бус цагдаа, тагнуулын байгууллагын шийдвэрээр тогтоогдсон гэж үзэж үндсэн эрхийг хязгаарлах боломжтой нөхцөл үүсжээ. Эдгээр байгууллагын дүгнэлт, шийдвэрт гомдол гаргах эрхийг холбогдох хуульд заасны дагуу батлан мөрдүүлж буй журамд заагаагүй бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэгдлийн дагуу шууд хэрэгжүүлэх зохицуулалттай.

<sup>126</sup> <https://crc.gov.mn/articles/slug11777/en.>, Сүүлд хандсан: 2024.07.22.

<sup>127</sup> Сонгуулийн Ерөнхий Хорооны 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын 1 дүгээр зүйлийн 8 дах хэсэг, “Эрх бүхий байгууллага” гэж Сонгуулийн ерөнхий хороо, тагнуулын байгууллага, цагдаагийн төв байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар хамаарна. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089716019011>

## 2.2. Европын Холбоо: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим хуудсыг хязгаарлаж буй тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл

### Кейс 1. Иргэн Ахмет Уилдиримын нэхэмжлэлтэй Турк Улсын Засгийн газарт холбогдох хэрэг (AHMET YILDIRIM v. TURKEY)

Турк Улсын иргэн Ахмет эрдэм шинжилгээний ажил, судалгаагаа нийтлэх, янз бүрийн сэдвээр өөрийн үзэл бодлыг илэрхийлэх зорилгоор Google Sites-ийн цахим хуудас үүсгэх, байршуулах үйлчилгээг ашиглан сайт хөтөлдөг байв. 2009 оны 6 сарын 23-ны өдөр Турк Улсын “Интернэт орчиндох нийтлэлийг зохицуулах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх тухай” хуулийн 8.1 б хэсэгт заасны дагуу Денизлигийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс цахим хуудас эзэмшигч нь Ататүрк буюу Турк Улсын анхны ерөнхийлөгчийн нэр төрийг гутаан доромжилсон хэрэгт сэжиглэгдэж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаатай холбоотойгоор шүүхээс урьдчилан сэргийлэх байдлаар сайтыг хаах шийдвэр гарч тухайн өдрөө Харилцаа холбоо мэдээллийн технологийн газарт шийдвэрийн хувийг хүргүүлжээ. Уг газар шийдвэрийг хүлээн аваад зөрчил гаргасан цахим хуудас эзэмшигч нь өөр улсад амьдардаг, серверийн гэрчилгээгүй тул энэхүү сайтыг хаах арга нь Google Sites нэвтрэх бүх хандалтыг хаах хэмээн үзэж энэ талаар шүүхэд хүсэлт гарган, шүүхээс өмнөх шийдвэрээ өөрчлөн, “Интернэт орчиндох нийтлэлийг зохицуулах, цахим гэмт хэрэгтэй тэмцэх тухай” хуулийн 8-р зүйлийг үндэслэн бүх хандалтыг хаан шийдвэрлэсэн байна.<sup>128</sup> Үүний улмаас Ахмет өөрийн сайтад нэвтрэх боломжгүй болж шийдвэрийн өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулахаар хүсэлт гаргасан. Шүүхээс Харилцаа холбоо мэдээллийн технологийн газраас ирүүлсэн зөвлөмж болох зөрчилтэй цахим хуудас руу нэвтрэхийг хориглох ганц арга нь контент байршуулсан Google Sites үйлчилгээнд хандах хандалтыг хаах хэмээн тайлбарлаж, хүсэлтийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. 2011 оны 3-р сарын 25-ны өдөр зөрчил гаргасан цахим хуудасны эзэмшигчийн эсрэг үүссэн эрүүгийн хэрэг нь яллагдагчийн хувийн мэдээлэл, оршин суугаа хаягийг тогтоох боломжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болж шийдвэрлэгдсэн ч Ахмет өөрийн цахим хуудас руу нэвтэрч чадахгүй хэвээр байсан. Ахмет уг шийдвэрийг эсэргүүцэж Европын Хүний эрхийн шүүхэд гомдол нэхэмжлэл гаргасан.

Европын Хүний Эрхийн Шүүхээс: Ахмет Google Sites-н үйлчилгээг ашиглан өөрийн үзэл бодлыг цахим орчинд илэрхийлж байсан бөгөөд тэрээр цахим хуудсаа хууль ёсны дагуу ашиглаж байсан тул Google Sites-д хандах бүх эрхийг хязгаарлаж, тэрээр цахим хуудсандаа хандах боломжгүй болсон нь түүний эрхийг зөрчсөн. Хэдийгээр Конвенцын 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хуульд зааснаар хязгаарлаж болох ч энэ нь ардчилсан нийгмийн суурь зарчим болох хууль дээдлэх ёс (rule of law)-д нийцсэн байх ёстойг онцолсон. Тодруулбал, гомдол гаргагчийн гаргасан хууль бус үйлдлийг эсхүл түүний нийтэлсэн контент нь хууль бус болохыг шалгах

<sup>128</sup> Official website of European Court of Human Rights

<https://hudoc.echr.coe.int/eng?i=001-115705> Сүүлд хандсан огноо: 2024.07.17

ажиллагааны явцад, зөвхөн тухайн хүний цахим хуудсанд хандах эрхийг зөвхөн шүүгчийн захирамжаар хааж болохыг үндэсний хууль тогтоомжид тодорхой заасан хэдий ч Google Sites-н хандалтыг бүхэлд нь хааснаар бусад этгээдийн эрх хөндөгдөх үр дагаврыг шүүх харгалзаагүй байна. Үүний үр дагавраар их хэмжээний мэдээлэлд хандах боломжгүй олон тооны интернэт хэрэглэгчийн эрх хязгаарлагдсан байх тул Турк Улсын шүүхийн шийдвэр нь Европын Хүний Эрхийн Конвенцын 10 дугаар зүйлд баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчсөн гэх дүгнэлт хийжээ.

Дээрх шүүхийн шийдвэрт эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны явцад цахим хуудсанд хандах эрхийг зөвхөн тухайн хэрэгт шалгагдаж буй этгээдийн хувьд шүүгчийн захирамжийн дагуу хуульд заасан үндэслэлээр хааж боломжтой. Гэвч энэ тохиолдолд тухайн хандалтыг хааж ажиллагаа нь бусад этгээдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчих, хязгаарлах үр дагаврыг заавал харгалзан үзэх шаардлагатай. Гагцхүү хуульд заасан тул гэх үндэслэлээр энэ төрлийн хязгаарлалтын арга хэмжээг авах ёсгүйг онцлох нь зүйтэй байна.

## **Кейс 2. Иргэн Каблисын нэхэмжлэлтэй ОХУ-н Засгийн газарт холбогдох хэрэг (KABLIS v. RUSSIA)**

2015 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын алба болон Мөрдөн байцаах хорооноос Бүгд Найрамдах Коми Улсын захирагч Гайзер, Оросын парламентын дээд танхим дахь тус улсын төлөөлөгч болон хэд хэдэн өндөр албан тушаалтнуудыг залилангийн хэрэгт сэжиглэн, гэмт бүлэглэлд гишүүнээр элссэн байж болзошгүй гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэсэн хэмээн мэдэгдэн, баривчилсан. 2015 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Каблис гэх хүн Сыктыквар хотын захиргаанд 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Стефановскийн талбай дээр Лениний хөшөөний ард 5-6 цагийн хооронд Комигийн Засгийн газрын эсрэг үүсгэсэн эрүүгийн хэргийн талаар 50 орчим хүн оролцох цуглаан хийхээр төлөвлөж буйгаа мэдэгдсэн. Мөн тухайн өдрөө тэрээр өөрийн хөтөлдөг блогтоо дээрх үйл явдлыг хэрхэн үзэж байгаа талаар цуглаан хийх тухайгаа, хотын захиргаа хүсэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байсан ч цуглааныг хийх тухай, хотын захирагч нар ард түмнээс сонгогдох бус ерөнхийлөгч томилдог талаар шүүмжлэн, ард иргэд өөрсдөө сонгодог болох нь зүйтэй талаар, нотлох баримт хангалттай биш байхад баривчилж буй нь Ерөнхийлөгч Путин Гайзер болон Комигийн улс төрчдийг айлгах зорилготой явуулж буй зүйл, иймд Коми Улсын ирээдүйн талаар болон дараагийн захирагчдыг өөрсдийн саналаар сонгох саналыг хэлэлцэх талаар бичжээ. Тэрээр үүнээс хоёр өдрийн дараа нийгмийн сүлжээний VKontakte гэх платформын хаягаасаа цуглаанд идэвхтэй оролцохыг уриалан нийтлэл бичсэн. 2015 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр ОХУ-ын Харилцаа холбоо, мэдээллийн технологи, хэвлэл мэдээллийн хяналтын алба болон ОХУ-ын Ерөнхий Прокурорын орлогч Каблисын нийтлэл нь “Олон нийтийн арга хэмжээний тухай хууль”-ийн 10-р зүйлийн 1-р хэсгийг зөрчсөн хууль бус олон нийтийн арга хэмжээнд оролцохыг уриалсан гэх тушаал гаргасны дагуу VKontakte-иас Каблисын хаягийг хаасан.

Каблис энэ талаар 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр “Улс төрийн идэвхтэй, өөрийн үзэл бодлоо илэрхийлсний төлөө өөрийнх нь хаягийг хаасан, хууль хүчний байгууллага идэвхтэй оролцоо бүхий хүмүүсээс эмээж байна, цуглаанд оролцож өөрийн үзэл бодлоо илэрхийлээрэй” хэмээн уриалан блогтоо нийтэлсэн. Тухайн өдөр нь Каблисын блог байршсан сайтын админ нь Ерөнхий Прокурорын тогтоосон журам зөрчиж буй олон нийтийн арга хэмжээнд уриалсан гэх үндэслэлтэй тушаалаар Каблисын бичсэн гурван блогийн хандалтыг хаажээ.<sup>129</sup>

Каблис Конвенцын 11 дүгээр зүйлд заасан жагсаал, цуглаан хийж, эвлэлдэн нэгдэх эрхээ зөрчигдсөн<sup>130</sup>, 10 дугаар зүйлд заасан өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн, эдийн бус хохирол учирсан гэж Коми Улсын шүүхэд хандсан ч “олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах зөвшөөрөлгүй байтал тухайн арга хэмжээнд хүмүүсийг уриалсан, ийм мэдээлэл түгээх журам зөрчсөн тул хязгаарлалт нь үндэслэлтэй” гэж үзэж түүний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Европын Хүний Эрхийн Шүүхээс: Конвенцын 10-р зүйлд заасан Каблисын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь зөрчигдсөн гэж дүгнэсэн. Шүүхийн шийдвэрт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь ардчилсан нийгмийн нэг чухал үндэс бөгөөд хүн бүр энэхүү эрхийг эдлэх учиртайг дурдаад, эрхээ эдэлж буй хэлбэр нь мэдээлэл болон санааг заавал сөргөөр эсхүл аливаа дүрэм, журмын эсрэг илэрхийлсэн байсан ч хамгаалагдана. Учир нь олон ургалч, илүү өргөн хүрээнд сэтгэх, шүүмжлэлтэй хандах зэргийг илэрхийлэхгүйгээр ардчилал оршин тогтнохгүй юм. Мөн энэ эрхийг хэрэгжүүлж буй ойлголтод илэрхийлсэн агуулгаас нь гадна түгээж буй хэлбэрийг мөн хамааруулна. Тиймээс түгээлтэд аливаа хязгаарлалт хийж буй нь мэдээлэл хүлээн авах, хуваалцах эрхийг зөрчиж буй нэг хэлбэр гэж үзнэ. Интернет нь олон нийт мэдээлэлд хандах болон мэдээллийг түгээх боломжийг нэмэгдүүлж, маш их хэмжээний мэдээллийг авах хадгалах, харилцан санал бодлоо илэрхийлэх хүртээмжийг сайжруулсан чухал ач холбогдолтой. Хэрэглэгч өөрөө бүтээсэн контентоо интернет орчинд нийтэлснээрээ түүнийг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлж буй хүлээн зөвшөөрөгдсөн талбар болгосон.

Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуульд заасан үндэслэл, хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, нийтийн эрх ашгийн төлөө хязгаарлаж болно. Гэвч Каблисын олон нийтийн сүлжээний хаягийг хаах, гурван блогийг хотын захиргаанаас зөвшөөрөөгүй үйл ажиллагааны талаар мэдээлсэн гэх шалтгаанаар хаасан нь

<sup>129</sup> Official website of European Court of Human Rights

<https://hudoc.echr.coe.int/eng?i=001-192769> Сүүлд хандсан огноо: 2024.07.22

<sup>130</sup> Европын Хүний Эрхийн Шүүх Конвенцын 11 дүгээр зүйлд заасан Каблисын жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх зөрчигдсөн гэж дүгнэсэн бөгөөд судалгааны судлагдахуунд хамааралгүй тул тухайн хэсгийг дэлгэрэнгүй оруулаагүй болно.

хуульд заагаагүй төрийн хөндлөнгийн оролцоо гэж үзнэ. Учир нь Каблис болон түүний блогтой холбоотой эцэслэн гарсан шүүхийн шийдвэр гараагүй бөгөөд цуглаан нь олон нийтийн аюулгүй байдалд саад учруулах талаар ямар нэг үндэслэлийг тогтоогоогүй. Дотоодын шүүхийн шийдвэрт Мэдээллийн тухай хуулийн 15.3-т заасан буюу тогтоосон журмыг зөрчсөн олон нийтийн арга хэмжээнд уриалсан гэж дүгнэсэн ч “тогтоосон журмыг зөрчсөн олон нийтийн арга хэмжээ” гэх нэр томъёог Улсын Дээд шүүх болон Үндсэн хуулийн цэцээс тайлбарлаагүй, практикт хэрэглэгдэх жишээ дурдаагүй, эрх бүхий албан тушаалтнаар урвуулан ашиглагдахаас сэргийлэх ямар нэг хяналт, цар хүрээ тогтоогоогүй байна. Мөн үүсэж болох эмх замбараагүй байдал эсхүл олон нийтийн эрх ашиг зөрчигдөх нөхцөл үүсээгүй, Каблисын нийтэлсэн аль нэг блогт дурдсан агуулгыг шүүхийн шийдвэрээр хууль бус болохыг тогтоогоогүй байхад Ерөнхий прокурор болон түүний орлогч нь шүүхийн шийдвэргүйгээр дээрх заалтыг үндэслэн блог, хаягийг хаасан нь интернэт орчин дох хэрэглэгчийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж дүгнэжээ.

Шүүхийн шийдвэрт цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх ойлголтод түүнийг түгээж, хүргэж буй хэлбэрийг хамааруулах тул цахим хуудас, олон нийтийн сүлжээний хаягийг хаах, хандах эрхийг хязгаарлах зэрэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буй нэг хэлбэр болохыг тайлбарласан нь ач холбогдолтой. Нэг талд нь улс төрийн үзэл бодол, шүүмжлэл, саналаа илэрхийлэгч этгээдийн эрх, нөгөө талд түүнийг буюу мэдээлэл хүлээн авч буй бусад этгээдийн эрх хамт хангагдсанаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдэлж буй хэлбэр болно.

Мөн цахим орчинд нийтлэгдсэн нийтлэл, цахим сүлжээний хаягийг хаахдаа түүнд нийтэлж, илэрхийлсэн агуулга, үйл баримт нь ямар хуулийн зүйл заалтыг зөрчсөн болохыг нотолж, хууль бус болохыг шүүхийн шийдвэрээр тогтоолгүй зөвхөн прокурорын шийдвэрийг үндэслэсэн нь үндсэн эрхийг зөрчсөн гэж дүгнэх үр дагаварт хүргэжээ.

## 2.3 АНУ: Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүнийг хязгаарласан тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл

### Кейс 1. Иргэн Пэкингхамын нэхэмжлэлтэй Хойд Каролина мужийн засаг захиргаанд холбогдох хэрэг (Packingham v. North Carolina) (20)<sup>131</sup>

Лестер Пэкингхам нь 21 настай оюутан байхдаа насанд хүрээгүй хүүхэдтэй “садар самуун үйлдэл” хийснийхээ төлөө Хойд Каролина мужийн хуулийн дагуу 10-12 сарын хорих ялаар шийтгэгдсэн. Улмаар 2010 онд тэрээр өөрийн Фейсбүүк профайлдаа “*зогсоолын торгуулийг цуцалсан бурханд талархал илэрхийлж буй тухай*” бичсэнийг эрх баригчид олж мэдсэнээр баривчилсан байна. Түүнийг Хойд Каролинагийн бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтнүүд нийгмийн сүлжээнд нэвтрэхийг хориглосон хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр баривчилжээ. Тус хуулиар бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтнийг “*насанд хүрээгүй хүүхэд гишүүнээр элсэх эсхүл хувийн цахим хуудас үүсгэх, хөтлөх боломжтой арилжааны нийгмийн сүлжээ рүү нэвтрэх*”-ийг хориглодог. Тус хуулийн зохицуулалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчсөн маргааныг үүсгэсэн.

Хойд Каролина мужийн шүүхээс: Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийг зөрчсөн үндэслэлээр ялын дүгнэлтийг хүчингүй болгуулах өргөдөл гаргагчийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна. Шүүхээс ял оногдуулж, тус муж нь “хүүхдийг хамгаалах” зорилгоор бэлгийн гэмт хэрэгтнүүдийг олон нийтийн сүлжээнд нэвтрүүлэхгүй гэж дүгнэжээ.

Хойд Каролина мужийн давж заалдах шатны шүүхээс: Хойд Каролины Давж заалдах шатны шүүх шийдвэрийг өөрчилж, хуулийн олон нийтийн сүлжээний цахим хуудсанд холбогдох заалт Үндсэн хууль зөрчсөн гэж үзжээ.

Хойд Каролина мужийн дээд шүүхээс: Хойд Каролины Дээд Шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг өөрчилж, хуулийг “үйл ажиллагааны хязгаарлалт” гэж үзэн Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн. Энэ нь үг хэлэх эрх чөлөөг хязгаарлахгүй гэж дүгнэсэн. Тус хууль нь бэлгийн хүчирхийлэгчид болон ирээдүйд өртөж болох хохирогчдын “хууль бус нуугдмал үйлдэл болон харилцааг урьдчилан сэргийлэх” хангалттай зорилгыг агуулсан гэж дүгнэсэн.

Улсын Дээд шүүхээс: АНУ-ын Дээд шүүх Хойд Каролина мужийн “бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтнүүдийг насанд хүрээгүй хүүхдүүд идэвхтэй болон бүртгэлтэй байдаг янз бүрийн цахим хуудсанд хандахыг хориглох, бэлгийн хүчирхийлэгч нь насанд хүрээгүй хүүхэдтэй шууд харилцаа тогтоосон

<sup>131</sup> [https://www.supremecourt.gov/opinions/16pdf/15-1194\\_0811.pdf](https://www.supremecourt.gov/opinions/16pdf/15-1194_0811.pdf)

эсэхээс үл хамааран цахим хуудсанд хандсан тохиолдолд гэмт хэрэгт тооцогдох тухай” хууль нь Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийг дараах байдлаар зөрчиж байна гэж дүгнэсэн.

- i. АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийн үндсэн зарчим нь хүн бүр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хүлээн авах боломжтой байх орон зайд нэвтрэх эрхтэй байх явдал юм. Каролина мужийн хуулиар бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэгтнүүдийг цахим талбар ашиглахыг хориглох нь тэдний одоо өрнөж буй үйл явдлуудыг мэдэх, энэ талаар үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн өргөн хүрээг судлах үндсэн мэдээллийн эх сурвалжуудад нэвтрэхийг хориглож байна. Хууль нь Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтөд нийцэхийн тулд хууль ёсны хэрэгцээ шаардлагаас өргөн хүрээнд буюу үг хэлэх эрхийг явцуу байдлаар хязгаарлаагүй байх ёстой.
- ii. Хууль нь хүүхдүүдийг хүчирхийллээс хамгаалах хууль ёсны шаардлагад үндэслэсэн боловч насанд хүрээгүй хүүхэд гишүүнээр элсэх, эсхүл хувийн цахим хуудас үүсгэх, ашиглах боломжтой бүх төрлийн цахим хуудсанд нэвтрэхийг хориглосон нь хэт өргөн хүрээний хязгаарлалт байна. Учир нь насанд хүрээгүй хүүхдэд бэлгийн гэмт хэрэг үйлдэх магадлал багатай цахим хуудсуудыг ч хамруулсан байна. Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлт нь ийм өргөн хүрээний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зохицуулалтыг зөвшөөрөөгүй. Каролина мужийн хууль Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийг зөрчсөн байна.
- iii. Засгийн газар насанд хүрээгүй хүүхдүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах ашиг сонирхолтой бөгөөд интернэт нь гэмт хэрэгтнүүдэд хүүхдүүдтэй холбоо барих боломжийг олгодог тул хуулиар гэмт хэрэгтнүүдийн интернэт хэрэглэхийг тодорхой хэмжээгээр зохицуулах нь зөвшөөрөгдөнө. Үүний тулд муж улс илүү нарийн бичигдсэн хууль баталснаар ижил зорилгоо хэрэгжүүлж чадна гэж тайлбарласан.

Хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах нь хууль ёсны шаардлагад үндэслэгдсэн байхыг зөвшөөрөх хэдий ч хязгаарлалт нь пропорциональ зарчимд нийцсэн байх ёстой. Тухайн тохиолдолд тохирсон байх шалгуурыг эрхийн хязгаарлалтад зайлшгүй дагаж мөрдөхөөр байна.



**Кейс 2. Алабама мужийн эсрэг Миллсийн хэрэг (Mills v. Alabama), 384 U.S. 214<sup>132</sup> (1966)**

1962 оны 11 сард Алабама мужийн Бирмингем хотод тухайн үеийн хотын комиссыг хотын захирагчийн зөвлөлийн засаглалаар солих эсэхээ шийдвэрлэх бүх нийтийн сонгууль болж байсан. Сонгууль болох өдөр Бирмингем хотын Пост Хералд сонины эрхлэгч Жэймс И.Миллс хүмүүст хотын захирагчийн зөвлөлийн засаглалыг сонгохыг уриалсан нийтлэл бичжээ.

Авлигын тухай хуулийн 285-р зүйлд “Сонгуулийн өдөр аливаа хэлбэрээр санал хураалтыг дэмжсэн, эсхүл эсэргүүцсэн байдлаар сонгуулийн сурталчилгаа хийх”-ийг гэмт хэрэгт тооцохоор заасан тул Миллсийг Авлигын тухай хуулийн §285 дугаар зүйлийг зөрчсөн гэх үндэслэлээр баривчилсан.

Миллс үүний эсрэг анхан шатны шүүхэд гомдол гаргасан бөгөөд түүнийг баривчилсан явдал нь АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтөд заасан “Конгресс шашныг бий болгох, түүнийг чөлөөтэй хэрэгжүүлэхийг хориглосон эсвэл **үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө**, иргэдийн тайван замаар цуглах эрх, санал хүсэлтээ шийдвэрлүүлэхээр Засгийн газарт өргөдөл гаргахыг хязгаарласан ямар ч хууль батлахгүй.” гэснийг зөрчсөн гэж маргажээ.

Анхан шатны шүүхээс Алабама мужийн Авлигын тухай хууль нь Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтийг зөрчсөн гэж үзэж, хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

Харин Алабама мужийн дээд шүүх сонгуулийн өдөр хуульд заасан энэ хязгаарлалт байх нь үндэслэлтэй бөгөөд сонгуулийн өдөр ийм нийтлэл бичсэн нь Алабама мужийн хуулийг илт зөрчсөн үйлдэл мөн гэж үзэн, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон.

АНУ-ын Дээд шүүхээс хянан хэлэлцээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Алабама мужийн хуульд заасан хязгаарлалт нь Үндсэн хуульд заасан үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг зөрчөөгүй гэж үзжээ. Алабама мужийн дээд шүүх Авлигын тухай хууль нь үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан болохыг хүлээн зөвшөөрсөн боловч энэ нь зүй ёсны бөгөөд “үндэслэл бүхий хязгаарлалт” гэж дүгнэсэн байна.

АНУ-ын Дээд шүүхийн шийдвэрийн дүгнэлт хэсэгт: “Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлт, өөрчлөлтийн зорилго нь иргэд Засгийн газрын асуудлуудын талаар чөлөөтэй хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хамгаалах явдал юм. Үүнд нэр дэвшигчид, сонгуулийн талаарх хэлэлцүүлэг, засаглалын бүтэц хэлбэр, Засгийн газрын үйл ажиллагаа явуулах арга хэлбэр гэх мэт улс төрийн үйл явцтай холбоотой бүх асуудал багтана. Мөн Үндсэн хуульд заасан хэвлэн нийтлэл гэдэгт зөвхөн ном, сонин, сэтгүүл төдийгүй сонгуулийн ухуулга хуудас,

<sup>132</sup> <https://supreme.justia.com/cases/federal/us/384/214/>

тойруулга зэргийг ч багтаана. Гэхдээ сонгуулийн өдөр сонины редакторын хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан нь эрх чөлөөг “хамгийн бага хэмжээний хязгаарлалт” байсан тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зөрчөөгүй байна. Тус хязгаарлалт нь сонгуулийн сүүлийн өдөр сонгогчдод нөлөөлөх зорилгоор олон нийтийг төөрөгдүүлсэн, сөргөлдөөн үүсгэсэн суртал ухуулга тараахаас олон нийтийг хамгаалах зорилгыг агуулсан гэж шийдвэрлэсэн.

Сонгуулийн өдөр хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарлах нь сонгогчдыг зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, айлган сүрдүүлэх явдлыг бууруулах, эмх замбараагүй байдал, төөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, нэр дэвшигчдийн тэгш эрхийг хангах гэх мэт чухал ач холбогдолтой тул ийм хязгаарлалт нь дээрх ИБУТЭТОУП-ын 19(3)-т заасан “нийгмийн дэг журам”-ыг хамгаалах шаардлагад нийцжээ. Гэхдээ Алабама мужийн Авлигын тухай хуулийг зөрчиж, хэвлэн нийтэлсэн иргэнд хүлээлгэж буй хариуцлага нь хамгийн бага түвшинд байх ёстой. Европын холбооноос хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг онлайн болон оффлайн хэлбэрээр баталгаажуулсан удирдамжид “...хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд зорилгодоо нийцсэн, хамгийн бага түвшинд хязгаарлана. (шаардлагатай бөгөөд пропорциональ байх зарчмын хүрээнд)<sup>133</sup>...” гэсэн байдаг. Нийтлэл бичсэнийх нь төлөө хүнийг шууд баривчлах нь дээрх зарчимд нийцэхгүй байна.

### Кейс 3. Америкийн иргэний эрх чөлөөний холбоо болон АНУ-ын Ерөнхий прокурор Рено нарын оролцогчидтой хэрэг (Reno v. Am.Civil Liberties Union, 1997)<sup>134</sup>

Насанд хүрээгүй хүүхдүүдийг цахим орчин дахь зохисгүй мэдээллээс хамгаалах зорилгоор батлагдсан Харилцаа холбооны ёс зүйн тухай хуулийн 223(a), 223(d) заалтууд нь 18 насанд хүрээгүй хүүхдүүдэд “садар самууныг сурталчилсан, зохисгүй мессежийг санаатайгаар дамжуулсан”, түүнчлэн “бэлгийн харилцаа, түүнд хамааралтай зүйлсийг илтэд доромжилсон байдлаар дүрслэн харуулсан” зүйлсийг нийтлэх, түгээхийг гэмт хэрэгт тооцох тухай заажээ. Тус хууль 1996 оны 2 дугаар сарын 8-ны өдөр хүчин төгөлдөр болсон даруйд Америкийн иргэний эрх чөлөөний холбоо (The American Civil Liberties Union) нь дээрх заалтуудыг Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлтэд заасан “Конгресс нь ямар нэгэн шашныг албан ёсны болгон тунхаглах буюу түүнийг чөлөөтэй шүтэх, **үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарласан** болон тайван замаар жагсаал цуглаан хийх, Засгийн газарт өргөдөл санал гомдол өгөх эрхийг хязгаарласан **нэг ч хуулийг батлах ёсгүй**” гэсэнтэй зөрчилдөж байна хэмээн тойргийн шүүхэд гомдол гаргажээ. Өөрөөр хэлбэл хуулийн дээрх заалтууд нь насанд хүрэгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хэмээн гомдол гаргасан байна.

<sup>133</sup> European Union human rights guideline on freedom of expression: online and offline, 20 [https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu\\_human\\_rights\\_guidelines\\_on\\_freedom\\_of\\_expression\\_online\\_and\\_offline\\_en.pdf](https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu_human_rights_guidelines_on_freedom_of_expression_online_and_offline_en.pdf) Сүүлд хандсан огноо: 2024.07.02

<sup>134</sup> <https://supreme.justia.com/cases/federal/us/521/844/>

Тойргийн шүүхээс: Харилцаа холбооны ёс зүйн тухай хуулийн 223(а) болон 223(d) заалтууд нь Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр нэмэлтэд заасан үг хэлэх эрх чөлөөг дараах байдлаар хязгаарласан гэж дүгнэсэн:

- i. Харилцаа холбооны ёс зүйн тухай хууль нь *"Шаардлагатайгаас илүү өргөн хүрээг хамарч, ингэснээр насанд хүрэгчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж байна"* гэж үзсэн бөгөөд "илт доромжилсон" болон "зохисгүй" гэх нэр томъёонууд нь мөн чанартаа тодорхой бус хэмээн дүгнэсэн. Тодруулбал, хуулийн §223(а)-д заасан "зохисгүй", § 223(d)-д заасан "илтэд доромжилсон", "контекст" гэх зэрэг нэр томъёонууд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болгоход тодорхой бус, хэтэрхий өргөн хүрээг хамарч байх тул үүнийг гэмт хэрэг гэж үзэн хэрэгжүүлэх нь Үндсэн хуулийн Нэгдүгээр болон Тавдугаар нэмэлтийн 861-д заасан "шударга ёсны зарчим"-ыг зөрчих болно гэж үзсэн.
- ii. *"Энэ хуулийг зөвхөн арилжааны порно контент үйлдвэрлэгч нарт хамааруулан тайлбарласнаар хууль тогтоомжийн хамрах хүрээг хязгаарлаж болно"* хэмээн тайлбарласан Засгийн газрын тайлбарыг үндэслэлгүй гэж үзсэн.
- iii. Тодорхой мэдээлэл, материалд хандахын тулд хэд хэдэн баталгаажуулах алхмыг хийх шаардлагатай байдаг тул санамсаргүй байдлаар зохисгүй материалтай тулгарах эрсдэл маш ховор гэж дүгнэсэн.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг Улсын ерөнхий прокурор Жанет Рено эсэргүүцэж, Нэгдсэн Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс дээд шүүхэд давж заалдсан боловч дээд шүүхийн нийт шүүгчдийн олонхын саналаар тойргийн шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Улсын Дээд шүүхээс дараах дүгнэлтийг гаргасан.

- i. Интернет хэрэглэгчийг хянахад төвөгтэй, тэр тусмаа насыг нь хянахад хүндрэлтэй. Гэхдээ үүнийг ёс суртахуунаар болон эцэг эхийн хараа хяналтын доор хэрэгжүүлэх боломжтой юм.
- ii. Зохисгүй боловч садар самуун биш бэлгийн харилцааны илэрхийлэл нь Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтөөр хамгаалагдсан байдаг. Мөн насанд хүрээгүй хүмүүсийг зохисгүй мэдээллээс хамгаалахын тулд Харилцаа холбооны ёс зүйн тухай хуулиар насанд хүрэгчдийн Үндсэн хуулиар баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах эрхийг хязгаарласан нь зөвшөөрөгдөнө гэж үзсэн. Өөрөөр хэлбэл тус хуулийн дагуу зохисгүй мэдээллийг хязгаарласан нь насанд хүрэгчдийн харилцаанд саад болохгүй гэж тэмдэглэжээ.

- iii. Насанд хүрээгүй хүүхдүүдийг хамгаалах нь дан ганц эцэг эхийн үүрэг бус төрийн ашиг сонирхол тул Засгийн газрын “Эцэг эх нь хүүхдүүддээ хяналт тавих нь хангалттай” гэсэн нь үндэслэлгүй, хуулиар хүүхдүүдийн эрхийг хамгаалах ёстой гэж үзсэн.
- iv. Нөгөө талаас нэг хүн өөр газар эрх чөлөөгөө илэрхийлэх боломжтой гэсэн шалтгаанаар зохих газарт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө хязгаарлуулах ёсгүй болохыг дурдсан байна.
- v. “Садар самуун” мэдээллийг хязгаарлах нь “зохисгүй” мэдээллийн хязгаарлалтаас тусдаа бичвэрийн шинж чанартай байдаг бөгөөд үүнийг үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн. Тиймээс “эсвэл зохисгүй” гэсэн нэр томъёог хуулиас хасахаар зохих байгууллагад үүрэг ногдуулж шийдвэрлэжээ.

Хуулиар цахим орчинд хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа тодорхой бус нэр томъёо ашиглаж, хэт өргөн хүрээнд эрхийн хязгаарлалтын тогтоосныг зөвтгөх үндэслэлгүй. Тус заалтыг зөрчсөн нь гэмт хэргийн адилаар шийтгэл ногдуулах боломжийг олгох тул тодорхой бус, хоёрдмол утгатай заалтын дагуу хүнийг шийтгэж, эрх чөлөөг нь хязгаарлах үр дагаварт хүргэж болохыг үгүйсгэхгүй юм.

## 2.4 Эстони Улс: Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, түүнийг хязгаарласан тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл

### Кэйс 1. Тармо Вахтер, Сулев Ведлер нарын хэрэг<sup>135</sup>

Эстони Улсын Eesti Ekspress сонины сэтгүүлч Тармо Вахтер (**Tarmo Vahter**), Сулев Ведлер (Sulev Vedler) нар 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Ээстий Экспресс (Eesti Ekspress)-ийн цахим сэтгүүл болох [www.ekspress.ee](http://www.ekspress.ee) сайтад “Эстони улс дахь Swedbank-ны Төлөөлөн Удирдах Зөвлөл ОХУ-ын олигархитай холбогдон мөнгө угаах гэмт хэрэгт сэжиглэгдэж байна.” гэх гарчигтай мэдээллийг нийтэлсэн бөгөөд уг нийтлэлд мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон гэх бүх сэжигтэн, ОХУ-ын Засгийн газрын гишүүн асан хүмүүсийг нэрлэсэн байжээ.

<sup>135</sup> Эстони Улсын Дээд шүүхийн тогтоол (2023.01.31), <https://www.riigiteataja.ee/kohtulahendid/fail.html?fid=331402045> Сүүлд хандсан огноо: 2024.07.16

2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Улсын Прокурорын газраас сэтгүүлч Тармо Вахтер, Сулев Ведлер болон Эсти Экспрессийн эзэмшигч Экспресс Медиа А.С (одоогоор Делфи Медиа А.С.) нарыг Эстони Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 1381 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг<sup>136</sup> болон 214 дүгээр зүйлд<sup>137</sup> заасныг үндэслэн 3200 еврогоор торгох хүсэлтийг Харжу дүүргийн шүүхэд хүргүүлсэн. Прокуророос сэтгүүлч болон цахим сэтгүүлийн газрыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээллийг прокурорын зөвшөөрөлгүйгээр олон нийтэд нийтэлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрсдэл учруулсан гэж үзсэн.

Сэтгүүлч Тармо Вахтер, Сулев Ведлер болон Экспресс Медиа АС нар *“Нийтлэлд дурдсан мэдээлэл нь хуульд заасан аргаар олж авсан (тус хэрэгт сэжиглэгдэж буй нэгэн сэжигтэн байцаалтад дуудагдсанаа илчилж, яагаад тэнд дуудагдсанаа тайлбарласан), нийтийн эрх ашигт хамааралтай, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд ноцтой хохирол учруулахгүй мэдээлэл юм. Прокурорын байгууллагаас зөвшөөрөл аваагүй гэсэн шалтгаанаар бидэнд торгууль ногдуулсан нь хэвлэлийн эрх чөлөөнд харшилж байна.”*, Хүний эрхийн тухай Европын конвенцын<sup>138</sup> 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан *“Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрх нь төрийн эрх мэдлийн хөндлөнгийн оролцоогүйгээр, улс орны хил хязгаарыг үл харгалзан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах, түгээх эрхээс бүрдэнэ.”*-г зөрчиж байна гэж маргасан.

Анхан шатны шүүхээс: 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр сэтгүүлч нар болон сайтын эзэмшигч компанийг тус бүр нь 1000 еврогоор торгох шийдвэр гаргажээ. Дараах үндэслэлийг шийдвэртээ тусгасан:

<sup>136</sup> Эстони Улсын Эрүүгийн процессын хуулийн §138 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан тохиолдолд шүүх, урьдчилсан мөрдөн байцаалтын шүүгч торгууль ногдуулах эрхтэй бөгөөд энэ хуульд өөрөөр заагаагүй бол торгуулийн хэмжээ 3200 евро хүртэл байж болно. Шүүх, анхан шатны шүүхийн шүүгч торгуулийн хэмжээг тогтоохдоо тухайн хүний санхүүгийн байдал болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Урьдчилан анхааруулах боломжгүй, эсвэл үндэслэл бүхий шалтгаан байгаагаас бусад тохиолдолд анхааруулга өгсний дараа торгууль ногдуулна” гэж тус тус заасан.

<sup>137</sup> Эстони Улсын Эрүүгийн процессын хуулийн §214 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой мэдээллийг зөвхөн прокурорын зөвшөөрөлтэйгөөр задруулж болно” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны мэдээллийг шүүн таслах ажиллагаа, олон нийтийн ашиг сонирхлын үүднээс, мөн мэдээллийн субъект зөвшөөрөл олгосон бол дор дурдсан нөхцөлийг хэт их хэмжээгээр задруулаагүй тохиолдолд зөвшөөрөгдөнө. Үүнд:

- Гэмт хэргийг өдөөх, гэмт хэргийг илрүүлэхэд хүндрэл учруулах;
- Эстони Улсын ашиг сонирхол, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хохирол учруулах;
- Бизнесийн нууцад халдах, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хохирол учруулах;
- Мэдээллийн субъект, эсвэл гуравдагч этгээдийн хувийн мэдээллийг задруулах” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны мэдээллийг задруулахыг хориглосон заалтыг зөрчсөн тохиолдолд урьдчилсан мөрдөн байцаалтын шүүгч Прокурорын байгууллагын хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, байцаан шийтгэх ажиллагаанд оролцож буй бусад этгээдэд торгууль ногдуулах захирамж гаргаж болно. Сэжигтэн, яллагдагчийг торгох арга хэмжээ авахгүй” гэж тус тус заасан.

<sup>138</sup> European Convention on Human Rights, ECHR, <https://www.legal-tools.org/doc/8267cb/pdf/> Сүүлд хандсан огноо: 2024.07.17

- Эстони Улсын Эрүүгийн процессын хуулийн 138<sup>1</sup> дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 214 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу **прокурорын зөвшөөрөлгүйгээр** шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны мэдээллийг задруулсан тул сэтгүүлчдэд торгууль ногдуулах үндэслэлтэй гэж үзсэн байна.
- Мөн нийтлэлийг бичсэн сэтгүүлчдээс гадна сайтын эзэмшигч Экспресс Медиа АС компанийг нийтлэгч гэж үзэн торгууль ногдуулсан.
- Прокурорын газраас өмнө нь хоёр удаа Ээстий Экспресс (Eesti Ekspress) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээллийг нийтлэхэд прокурорын газраас редакц, сэтгүүлчдэд санамж бичиг хүргүүлж байсан тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 138<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан анхааруулга өгөх шаардлагагүй гэж үзсэн.
- Сэтгүүлчид өмнө нь хэрэгт холбогдож байгаагүй болохыг харгалзан прокурорын байгууллагаас шаардсанаас бага хэмжээний торгууль ногдуулсан.

Давж заалдах шатны шүүхийн 2022 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн шийдвэрээр анхан шатны шүүхийн шийдвэрийг дараах үндэслэлээр хүчингүй болгож шийдвэрлэсэн:

- Нийтлэлд тусгагдсан шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааны талаарх мэдээлэл нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 214.2-т заасны дагуу олон нийтийн ашиг сонирхлын үүднээс зөвшөөрөгдөнө гэж үзсэн.
- Шүүхийн өмнөх шатны мэдээллийг нийтлэхийн тулд прокуророос зөвшөөрөл авах ёстой хэдий ч уг нийтлэл нь мөрдөн байцаалтын ажиллагаанд хохирол учруулаагүй байх тул торгууль ногдуулах үндэслэлгүй. Прокурорын хүсэлт, анхан шатны шүүхийн шийдвэрийн аль алинд нь нийтлэл нийтлэгдсэнээс болж ямар нотлох баримт цуглуулах нь аюулд орсон, эсвэл мөрдөн байцаалтын төлөвлөгөөний аль нэг хэсгийг өөрчлөх шаардлагатай болсон талаар дурдаагүй, сэжигтнүүдийн эрх хэрхэн зөрчигдөж байгаа нь тодорхойгүй байна гэж үзсэн.
- Мөн тухайн нийтлэлийг нийтлэх эсэхийг мэдээллийн цахим хуудсыг эзэмшигч хариуцах тул энэ тохиолдолд сэтгүүлчдэд торгууль ногдуулах ёсгүй гэж үзсэн байна.

Улсын дээд шүүхийн 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн шийдвэрээр давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.<sup>139</sup> Шүүхээс хэвлэн нийтлэх эрх чөлөө болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шударга ёсны зарчмын тэнцвэрт байдлыг хангах хүрээнд дараах дүгнэлтийг гаргажээ:

- Сэтгүүлч, мэдээллийн цахим хуудас эзэмшигч нар нь прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг задруулсан бөгөөд нийтлэлд мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон сэжигтнүүдийн нэрсийг нэрлэсэн гэж үзжээ. Европын Хүний эрхийн шүүхийн тогтсон практикийн дагуу мөрдөн байцаалтын нууцад хамаарах эрүүгийн хэрэг хянан шийтгэх ажиллагааны мэдээллийг нийтэлснийх нь төлөө тухайн ажиллагаанд хамааралгүй этгээдийг, тэр дундаа мэргэжлийн сэтгүүлчийг шийтгэх нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцын 10 дугаар зүйлд заасан үг хэлэх эрх чөлөөтэй зөрчилдөхгүй юм. Хууль зөрчсөн нийтлэлээс үүдэх үг хэлэх эрх чөлөөний хязгаарлалт нь 10 дугаар зүйлийн дагуу хамгаалагдахгүй тул прокуророос зөвшөөрөл авах шаардлагатай.
- Гэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон түүний оролцогчид, ялангуяа сэжигтэн, хохирогчид их хэмжээний хохирол учирсан тохиолдолд мэдээлэл нийтэлсэн этгээдэд торгууль ногдуулах нь үндэслэлтэй. Шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтэлсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлөх талаар баттай нотлох баримт байхгүй байна. (прокурор, мөрдөн байцаах байгууллагын байр суурийг унагаах, сэжигтнүүдийг буруушаасан гэх зэрэг мэдээллийг нийтлээгүй байна.) Тиймээс энэ тохиолдолд торгууль ногдуулсан нь үндэслэлгүй гэж үзсэн байна.
- Прокуророос мэдээлэл нийтлэх зөвшөөрлийг олгохоос татгалзсан үндэслэлээ тайлбарлах шаардлагатай бөгөөд дур зоргоороо шийдвэр гаргах эрхгүй болохыг онцолжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмын тэнцвэрт байдлыг хангахад Улсын дээд шүүхээс төвлөрч, хууль зүйн дүгнэлт гаргасан нь “хүний эрхийг

<sup>139</sup> Jakob Juksaar, “Ajakirjandusvabaduse piiramine kriminaalmenetluse huvide kaitsmiseks eesti vabariigi ja saksamaa liitvabariigi vxrdluses”, Магистрын ажил, <https://dspace.ut.ee/server/api/core/bitstreams/1d7c329d-6ac5-4569-a8d1-cf2c56de0410/content> Сүүлд хандсан огноо: 2024.07.16

хязгаарлах” үндэслэл нь тодорхой, ойлгомжтой, зорилгод нийцсэн байх шинжийг хангасан байх шаардлагад нийцсэн. Шүүхээс сэтгүүлч, цахим хуудас эзэмшигчийн үйлдэл, эрх зүйн үр дагаврын шалтгаан холбоо, сөрөг нөлөөллийг судалж, шийдвэрлэж байгаа нь дур зоргоор хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах, цензур тогтоохгүй байх зарчмыг дагаж мөрджээ.

### Кэйс 2. Ромео КАЛДА –н хэрэг<sup>140</sup>

Хаалттай хорих ангид бүх насаараа хорих ял шийтгэгдэж 1996 оноос ял эдэлж буй Эстони Улсын иргэн Ромео Калда 2005 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн цахим хувилбар (Riigi Teataja)<sup>141</sup>, Дээд шүүх, захиргааны шүүхийн шийдвэрүүд болон Европын хүний эрхийн шүүхийн цахим мэдээллийн сантай<sup>142</sup> танилцахыг хүссэн бөгөөд шоронгийн захирагчид энэ тухай хүсэлт хүргүүлсэн ч хорих байгууллага түүний хүсэлтийг “Хорих тухай хуульд интернэт ашиглах талаар заагаагүй”<sup>143</sup> гэх үндэслэлээр зөвшөөрөөгүй байна. Калда дээрх мэдээлэлд цахим хэлбэрээр хандаж чадахгүй байгаа нь түүний Үндсэн хуулиар баталгаажуулсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах эрхийг нь зөрчсөн гэж үзэж Перну мужийн захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Таллин мужийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан боловч шоронгийн зүгээс гомдол гаргагчид дээрх мэдээллийн онлайн хувилбарт хандах эрх олгохоос татгалзсан нь хууль ёсны хэмээн үзэж түүний гомдлыг хэрэгсэхгүй болгосон. Эстони Улсын Дээд шүүх эдгээр мэдээллийг цаасан хэлбэрээр үзэх боломжтой, цаасан хувилбарыг нь ашиглах боломжийг хангалттай хэмээн үзэж өмнөх шүүхийн шийдвэрүүдийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

2007 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Калда шилжин ирсэн Тарту шоронгийн захирагчид [www.coe.ee](http://www.coe.ee) (Европын Зөвлөлийн Таллин дахь мэдээллийн алба), [www.oiguskantsler.ee](http://www.oiguskantsler.ee) (Хууль зүйн яам), [www.riigikogu.ee](http://www.riigikogu.ee) (Эстониин парламент) сайтад нэвтрэх эрх хүсэхэд түүний хүсэлтийг мөн зөвшөөрөөгүй байна. Эстони Улсын дээд шүүх хорих ялын зорилго нь хууль эрх зүйн дэг журмыг хамгаалах, хоригдлуудыг хууль сахиулах зан үйлд чиглүүлэх явдал гэдгийг онцлон, хоригдлууд интернэт ашиглах эрхээ урвуулан ашиглаж болзошгүй тул Калдаг интернэтэд холбогдохыг хориглосон байна.

Иймд тэрээр Европын хүний эрхийн шүүхэд “Хүний эрхийн тухай Европын конвенцын 10 дугаар зүйлд заасан төрийн эрх бүхий байгууллагын хөндлөнгийн оролцоогүйгээр интернэтээр мэдээлэл авах эрх нь зөрчигдсөн” хэмээн гомдол гаргажээ.

<sup>140</sup> European Court of Human Rights: CASE OF KALDA v. ESTONIA <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-160270> Сүүлд хандсан огноо: 2024.07.17

<sup>141</sup> Эстони Улсын төрийн сонин Riigi Teataja, <https://www.riigiteataja.ee/en/>

<sup>142</sup> Европын хүний эрхийн шүүхийн цахим мэдээллийн сан., <https://www.echr.coe.int/>

<sup>143</sup> Эстони Улсын Хорих тухай хуулийн 311 дүгээр зүйлд “Хоригдлууд зөвхөн албан ёсны эрх зүйн мэдээллийн сан болон шүүхийн шийдвэрийн санд нэвтрэхээр хорих ангийн удирдлаган доор интернэт ашиглах ба хорих ангийн тусгайлан тохируулснаас бусад компьютерээр интернэтэд холбогдохыг хориглоно” гэж заасан. (Энэ заалтыг 2023.02.15-ны өдөр хүчингүй болгосон.)



А. Эстони Улсын шүүхээс дараах дүгнэлтийг гаргасан<sup>144</sup>:

- Анхан шатны шүүхээс *“Перну хорих ангид хоригдлуудад зориулсан нийтийн интернэт ашиглах цэг болон бусад техникийн шаардлага байхгүй. Тиймээс хорих ангийн гомдол гаргагчид интернэт ашиглах эрх олгохоос татгалзаж байгаа нь хууль ёсных болно.”* гэж дүгнэж гомдол гаргагчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.<sup>145</sup>
- Давж заалдах шатны шүүхээс *“Хорих ангийн гадна байгаа хүмүүстэй чөлөөтэй харилцах нь аюулгүй байдлын үүднээс зөвшөөрөгдөхгүй. Хорих анги нь хоригдолд эрхээ хамгаалахад нь боломжийг олгох ёстой боловч үүнийг ямар хэлбэрээр хийх нь тухайн байгууллагын шийдвэрт хамаарах асуудал болно.”* гэж дүгнэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.
- Улсын дээд шүүхээс *“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл нь хэвлэмэл болон цахим хэлбэртэй байдаг. Цахим мэдээлэл нь хэдийгээр хууль тогтоомжтой танилцахад хялбар, хурдан байх боловч хоригдлууд нь дээрх мэдээллийг цаасан хэлбэрээр авах бүрэн боломжтой бөгөөд хангалттай байна. Иймд гомдол гаргагчийг цахим мэдээллийн санд нэвтрэх эрх олгохоос татгалзсан нь хууль ёсны гэж үзсэн.”* тул өмнөх шатны шүүхийн шийдвэрүүдийг хэвээр үлдээжээ.

В. Европын хүний эрхийн шүүхээс: Европын Хүний эрхийн конвенцын 10 дугаар зүйлд зааснаар үндэслэн Эстони Улсын Дээд шүүхийн шийдвэрт дараах өөрчлөлтийг оруулж шийдвэрлэсэн:

- Хорих ял нь хоригдлуудын гадаад ертөнцтэй харилцах, түүний дотор мэдээлэл хүлээн авах боломжийг хязгаарладаг хэдий ч энэхүү хэргийн нөхцөлд олон нийтэд нээлттэй эрх зүйн мэдээлэл агуулсан сайтад нэвтрэх эрхийг Эстонийн хуулиар<sup>146</sup> олгосон байдгийг анхаарч үзэх нь зүйтэй. Иймд эрх зүйн мэдээлэл агуулсан сайтад нэвтрэх эрхийг хязгаарласан нь

<sup>144</sup>Эстони Улсын Дээд шүүхийн 2007 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 3-3-1-20-07 дугаартай шийдвэр. <https://www.riigiteataja.ee/kohtulahendid/detailid.html?id=206128058> Сүүлд хандсан огноо: 2024.07.22

Эстони Улсын Дээд шүүхийн 2009 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 3-3-1-5-09 дугаартай шийдвэр. <https://www.riigiteataja.ee/kohtulahendid/fail.html?fid=206098432> Сүүлд хандсан огноо: 2024.07.22

<sup>145</sup>Перну мужийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2005 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 3-156/2005 дугаар шийдвэр

<sup>146</sup>Эстони Улсын Хорих тухай хууль (2000), Imprisonment Act in Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/504112013005/consolide> Сүүлд хандсан огноо: 2024.07.17

Эстони Улсын иргэн Калдагийн мэдээлэл хүлээн авах эрхэд хөндлөнгөөс нөлөөлж байна.

- Хоригдлуудын интернэт ашиглахыг тодорхой тохиолдолд хязгаарлаж байгаа нь бусдын эрхийг хамгаалах, эмх замбараагүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгод нийцсэн бөгөөд Хүний эрхийн тухай Европын конвенцын 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хуульд заасан нөхцөл” гэдэгт хамаарч байна.
- Гомдол гаргагчийн хандахыг хүссэн веб-сайтууд нь хүний үндсэн эрх болон хоригдлуудын эрхтэй холбоотой хууль эрх зүйн мэдээ, мэдээллийг голчлон агуулж байсан бөгөөд нэмэлт гурван цахим хуудас нь жишээлбэл, дотоодын шүүхэд гомдол гаргах үед шүүхийн шийдвэрийн Эстони хэл дээрх орчуулга, хураангуйг зөвхөн тэрхүү сайтаас харах боломжтой байсан. Нэмэлт гурван цахим хуудасны аюулгүй байдлын эрсдэлийн талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийлгүйгээр Эстони Улсын Дээд шүүх дүгнэлт хийсэн байна гэж дүгнэсэн.

Энэ шүүхийн шийдвэр нь “хууль хэн бүхэнд нээлттэй” буюу эртний Ромын эрх зүйн *“Lex publica est”* зарчмыг баримталж, хууль тогтоомжийн хүртээмжтэй байдлыг хангах хүрээнд орон зайнаас үл хамаарч, иргэний эрх зүйн мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх суурь шаардлагыг тодорхойлжээ.

Гэхдээ тус хэргийг шийдвэрлэсэн шүүгчийн бүрэлдэхүүний шүүгч Кжолброгоос дараах үндэслэлийг тайлбарласан тусгай санал гарсан:

- *Гомдол гаргагч нь хаалттай хорих ангид бүх насаараа хорих ял шийтгэгдсэн хоригдол гэдгийг олонх шүүгч хангалттай анхаарч үзэхгүй байна. Олон нийтийн аюулгүй байдал, эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд Хүний эрхийн тухай Европын конвенцод заасан эрхийг зарим тохиолдолд хязгаарладаг.*
- *Хоригдлуудад интернэтэд нэвтрэх эрхийг бүхэлд нь эсвэл хязгаарлагдмал хэлбэрээр олгох нь түүнийг зүй бусаар ашиглах эрсдэлийг бий болгож, аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлдэг. Миний бие мэдээлэл, технологийн эрин үед амьдарч байгаагийн хувьд интернэтийн ач холбогдлыг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч гомдол гаргагчийн хандахыг хүссэн нэмэлт гурван цахим хуудсанд хандахаас татгалзсан явдал нь Конвенцын 10 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй юм гэжээ.*

Хэдийгээр гомдол гаргагч нь хаалттай хорих ангид ял эдэлж байгаа боловч эрх зүйн мэдээллийн санд хандах эрхээ Эстони Улсын Хорих тухай хуулийн 311 дүгээр зүйлд заасан хяналтын дор хэрэгжүүлэх боломжтой. Мөн тухайн мэдээллийг цахим хувилбараар үзэх нь сонин дээрээс олж үзэхээс илүү өргөн цар хүрээтэй мэдээлэл олж авах боломжийг олгоно. Иймд гомдол гаргагч нь эрх зүйн мэдээллийн цахим сан болон нээлттэй бусад сайтад хандах эрхийг хангаж, цахим орчны бусад мэдээлэлд хандах эрхийг хязгаарлах технологийн шийдлийг нэвтрүүлэх шаардлага үүсэж байна.

## 2.5 Канад Улс: Цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахтай холбоотой үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах тохиолдол, түүний хууль зүйн үндэслэл

### Кейс. Канадын Үндсэн Хуулийн сангийн нэхэмжлэлтэй Канад Улсын Ерөнхий прокурорт холбогдох хэрэг (Canadian Constitution Foundation v. Attorney General of Canada)<sup>147</sup>

Канад Улсын Сонгуулийн тухай хуулийн 91.1-т зааснаар “Аливаа хүн, хуулийн этгээд нь сонгуулийн дүнд нөлөөлөх зорилгоор сонгуулийн хугацаанд нэр дэвшигчийн талаарх худал мэдээллийг тараахыг хориглосон”.<sup>148</sup>

Канад Улсын Сонгуулийн тухай хуульд 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ заалтад байсан “мэдсээр байж” гэх үгийг хасжээ.<sup>149</sup>

Тус нэмэлт өөрчлөлтийн үр дүнд болгоомжгүй байдлаар нэр дэвшигчийн талаарх худал мэдээллийг тараасан, эсхүл мэдээллийн худал болохыг мэдэлгүйгээр тараасан тохиолдолд хуулийн зөрчилд тооцож байгаа нь хэт өргөн хүрээг хамарсан гэж үзэж, Канадын Үндсэн хуулийн сангаас<sup>150</sup> Канадын Эрх чөлөөний дүрмээр хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрхийг<sup>151</sup> зөрчиж байна гэж маргажээ.

Улсын дээд шүүхээс: Сонгуулийн тухай хуулийн 91.1 дэх хэсгийг дараах үндэслэлээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзэн хүчингүй болгож шийдвэрлэсэн:

- Сонгуулийн тухай хуулийн дээрх зүйл нь хэт өргөн хүрээг хамарч байгаа тул зарим талаар хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах шинжийг агуулсан.

<sup>147</sup> Canadian Constitution Foundation v. Attorney General of Canada., <https://globalfreedomofexpression.columbia.edu/cases/canadian-constitution-foundation-v-attorney-general-of-canada/> Сүүлд хандсан огноо: 2024.07.24

<sup>148</sup> Канад Улсын Сонгуулийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Аливаа хүн, хуулийн этгээд нь сонгуулийн дүнд нөлөөлөх зорилгоор сонгуулийн хугацаанд дараах зүйлсийг хийхийг хориглоно. Үүнд:

(a) Нэр дэвшигч, нэр дэвшигч болохоор төлөвлөж буй хүн, улс төрийн намын удирдагч эсвэл улс төрийн намтай холбоотой олон нийтийн зүтгэлтэн нь Парламентын хуулийн дагуу буюу ийм хуульд нийцүүлэн гаргасан журмын дагуу гэмт хэрэг үйлдсэн, эсвэл гэмт хэрэгт яллагдсан, мөрдөн байцаалтын шатанд байгаа гэх худал мэдээлэл тараах;

(b) Нэр дэвшигч, нэр дэвшигч болохоор төлөвлөж буй хүн, улс төрийн намын удирдагч эсвэл улс төрийн намтай холбоотой олон нийтийн зүтгэлтний иргэншил, төрсөн газар, боловсрол, мэргэжлийн ур чадвар, бүлэг, холбооны гишүүнчлэлийн талаар худал мэдээлэл тараах” гэж заасан.

<sup>149</sup> Canada Elections Act, SC 2000, c 9., <https://qweri.lexum.com/w/calegis/sc-2000-c-9-en#!fragment/sec91/BQcwhgziBcwMYgK4DsDWszlQewE4BUBTADwBdoJC4BOARgEoAaZbUwiARUUNwE9oA5AMaUwuBFx78hlwmlQBIPKQBC-AEoBRADKaAagEEAcgGFNjUmABG0Utj16QA> Сүүлд хандсан огноо: 2024.07.24

<sup>150</sup> <https://theccf.ca/about-us/>

<sup>151</sup> Канад Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд “Хүн бүр дараах үндсэн эрх, эрх чөлөөг эдэлнэ. (a) Ухамсарлах болон шашин шүтэх эрх чөлөө; (b) Үзэл бодол, итгэл үнэмшлээ харилцаа холбооны хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө” гэж заасан.

- Болгоомжгүйгээр худал мэдээлэл нийтэлсэн нь “худал гэдгийг мэдсээр байж” худал мэдээлэл нийтэлсэнтэй адилгүй учраас ялгааг нь тодруулж хуульчлах шаардлагатай.
- Энэ зохицуулалт нь Канадын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөөг хамгийн багаар хязгаарлана.” гэж заасныг, мөн 2 дугаар зүйлийн (b) дэх хэсэгт “үзэл бодол, итгэл үнэмшлээ харилцаа холбооны хэрэгслээр чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхтэй” гэж заасныг зөрчиж байна.

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх нь хүмүүст илүү чөлөөтэй, хараа хяналт, зохион байгуулалтгүйгээр, хэн ч хаанаас ч, ямар ч хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгодог. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь төрийн үр нөлөөг баталгаажуулдаг учраас үнэ цэнтэй юм.<sup>152</sup> Сонгуулийн үеэр цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэхэд нэр дэвшигчийн нэр төрийг доромжлох, худал мэдээлэл тараах зэрэг үйлдлүүд ихсэх хандлагатай байдаг.

Гэвч Канад Улсын Дээд шүүхийн шийдвэрт тайлбарласанчлан, Үндсэн хуулиар баталгаажуулсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгийн бага түвшинд, тухайлсан тохиолдолд л хязгаарлах бөгөөд хязгаарлалтын хамрах хүрээ “тодорхой” байх нь дур зоргоор хүний эрхийг хязгаарлахаас сэргийлнэ. Тухайлбал, цахим орчинд тархсан нэр дэвшигчид хамаарах мэдээллийн худал болохыг “мэдсээр байж” санаатайгаар нийтлэх, түгээх, эсхүл “үнэн” гэж итгэн нийтэлсэн, түгээсэн нь ялгаатай эрх зүйн үр дагаврыг үүсгэж, зохицуулах шаардлага байгааг шүүхээс тодорхойлсон нь үндэслэлтэй байна.

<sup>152</sup> Unesco: Manuel de formation mondial pour les agents des forces de l'ordre., pp 15, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000385099/PDF/385099fre.pdf.multi> Сүүлд хандсан огноо: 2024.07.25

## ДҮГНЭЛТ, САНАЛ

### Дүгнэлт 1.

Онлайн эсхүл оффлайн орчинд, эсхүл түгээж буй арга хэлбэрээс үл хамаарч Үндсэн хуулиар баталгаажсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх үүргийг улс орнууд хүлээдэг. Тиймээс энэ эрхийг цахим орчинд тэгш, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэхэд интернэтэд хүртээмжтэй байдлыг сайжруулах, нийтэд нээлттэй мэдээлэлд хандах эрхийг хүн бүрд олгож, интернэтийг хязгаарлахаас зайлсхийх, онлайн орчинд цензур тогтоохгүй байх бодлогыг улс орнууд хэрэгжүүлж байна. Учир нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор цахим орчин, виртуал орчинд хүмүүсийн аж амьдрал өрнөж, хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд аливаа хязгаарлалтгүйгээр цахимаар нийгмийн харилцаанд оролцох боломжийг хүн бүрд нээлттэй байлгахад анхаарч байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан боловч түүний хэрэгжилтийг хангахад чиглэсэн хууль тогтоомж байхгүй байна. Улсын Их Хурлаас 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль”-ийг баталсан. Гэвч уг хуулийг батлах Хууль тогтоомжийн тухай хуулиар тодорхойлсон хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх процесс ажиллагааг зөрчиж, хууль дээдлэх ёсны зарчмыг баримтлаагүй үндэслэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хориг тавьж, Улсын Их Хурлын хаврын чуулганаар хүлээн авч, хүчингүй болгосон. Тус хуулийн зорилго нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулахаас илүүтэй хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зохисгүй, доромжилсон, ялгаварлан гадуурхсан агуулга бүхий контентыг хязгаарлах буюу үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хязгаарлах шинжийг агуулжээ.

**Санал 1.**

Монгол Улсад цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх баталгааг хангахтай холбогдох тухайлсан хууль тогтоомж байхгүй боловч Монгол Улсын нэгдэн орсон ИБУЭОУП-д үндэслэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг онлайн болон оффлайн орчин гэж ялгалгүйгээр, тухайн эрхийг хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хамаарах харилцааг зохицуулсан тусдаа хууль баталж, мөрдөхөөс илүүтэй одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа оффлайн орчинд дагаж мөрддөг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Сонгуулийн хууль тогтоомж зэрэг бусад хуулиудыг онлайн орчинд дагаж мөрдөх зорилгоор боловсронгуй болгох, цаашлаад хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

**Дүгнэлт 2.**

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хуулиар хязгаарлахад хууль ёсны байх, зүй ёсны байх, тохирсон буюу пропорциональ байх зарчмыг дагаж мөрдөнө. ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дах хэсэгт зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг (1) бусдын эрх, нэр, төрийг хүндэтгэх, (2) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах шаардлагад нийцсэн байх шаардлагатай. Тус зарчмыг Европын Холбоо, Эстони Улс, ХБНГУ, АНУ-д нэгэн адил дагаж мөрддөг. Эдгээр бүс нутаг, улс орнуудад зөвхөн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зохицуулсан бие даасан хууль тогтоомж байхгүй, харин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ямар зорилгоор хязгаарлах талаар, хязгаарлалтад ямар шаардлага тавигдах эсэхийг тодорхой, ойлгомжтой байдлаар тухайн харилцаанд хамаарах хуулиар эсхүл шүүхийн практикаар тогтоож байна.

**Санал 2.**

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зохицуулалтууд нь Монгол Улсын Үндсэн хууль, ИБУТЭОУП болон хүний эрхийн олон улсын бусад баримт бичгүүдэд тусгагдсан “хуульд үндэслэх, зайлшгүй, зорилгодоо нийцсэн, хуульд нарийвчлан тусгасан, пропорциональ байх” зарчмуудыг баримталж, тэдгээрт нийцсэн байх шаардлагатай. Монгол Улсад хууль бус контентын агуулгыг тодорхойлоход хуулиас гадна Домэйн нэр бүртгэх, ашиглах журам, хууль бус зохисгүй контентын агуулгыг дүрэм, журмаар тогтоож байгаа нь “хүний эрхийн хязгаарлалт”-ыг зохицуулах шаардлага, зарчмуудад нийцэхгүй. Тиймээс үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлаж буй хүчин төгөлдөр хууль тогтоомжийг түүвэрлэн судалсны үндсэн дээр онлайн болон оффлайн орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах зорилго, шаардлагыг тодорхойлж, түүнийг цахим орчинд түлхүү хэрэгжүүлэх нь зүйтэй.

### Дүгнэлт 3.

Цахим орчинд үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ авах үүргийг хүлээлгэж, үүргээ хэрэгжүүлсний төлөө хариуцлага хүлээхгүй байх, үүргээ хэрэгжүүлээгүй бол хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг улс орнууд хэрэгжүүлж байна. Тухайлбал, Европын Холбооны Дижитал үйлчилгээний хуулиар хэрэглэгчийн хүсэлтээр, алсаас, цахим хэлбэрээр, төлбөртэй үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээ үзүүлэгчид хариуцлагатай байж, найдвартай, аюулгүй орчныг бүрдүүлэх үүргийг хүлээлгэж, уг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хэрэглэгчийн хандалтыг хаах арга хэмжээ авах нөхцөл, шаардлагыг тогтоосон. Мөн ХБНГУ үзэл бодлоо илэрхийлэхдээ илт хууль бус агуулгатайгаар хэрэгжүүлэх тохиолдолд хэрэглэгчийн контентыг устгах үүргийг тухайн нийгмийн сүлжээний платформыг ажиллуулагч дижитал үйлчилгээ үзүүлэгчид Нийгмийн сүлжээний хэрэгжилтийн тухай хуулиар ногдуулж, уг үүргээ биелүүлээгүй тохиолдолд торгох хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ. АНУ-д цахим орчинд үйлчилгээ үзүүлэгч хууль бус хэрэглэгчийн контентод хязгаарлалт тавих, үйлчилгээнд нэвтрэх эрхийг хязгаарлах үүргийг Харилцаа холбооны зохистой байдлын тухай хуулиар хүлээж, уг үүргийг хэрэгжүүлсний төлөө хариуцлага хүлээхгүй байх хамгаалалт олгосон.

Монгол Улсын одоогийн нөхцөл байдалд үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчийн контентыг устгах, хандалтыг хязгаарлах эрх олгосон хуулийн зохицуулалт шаардлагагүй юм. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг уламжлалт хэлбэрээр эдлүүлэх, цахим орчинд хэрхэн баталгаатай эдлүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж байхгүй тул дээрх төрлийн үүрэг, хариуцлагыг хуульчилсан ч хангалттай түвшинд хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй тул үндсэн эрхийг хязгаарлах эрсдэл үүсэх боломжтой.

Түүнчлэн олон нийтийн сүлжээний хэрэглэгчийн дагаж мөрдөх хэм хэмжээ (Community Standard) нь үндэсний хууль тогтоомжтой зөрчилдсөн тохиолдолд дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтын ажиллагаа байхгүй байна.



**Санал 3.**

Хуулиар тодорхойлсон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд аливаа улсын дотоодын эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанаас гадна олон улсад үйл ажиллагаа явуулж буй олон нийтийн сүлжээ (сошиал медиа) платформуудтай хамтран ажиллах, тухайлсан тохиолдлуудад бие даасан хараат бус нэгжийг байгуулах, эсхүл байгуулагдсан нэгжтэй хамтран ажиллах замаар хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх орон зайг хадгалах нь зүйтэй.

**Дүгнэлт 4.**

Монгол Улсад харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх эрхийг хязгаарлаж буй зохицуулалтыг хэрэгжүүлж буй практикаас үзвэл, прокурорын зөвшөөрлөөр цахим хуудас, олон нийтийн сүлжээний платформын цахим хуудас, хаяг, контент, нийтэлсэн мэдээлэлд хандах эрхийг хязгаарлах арга хэмжээг авч байна. Гэвч прокурорын зөвшөөрөл олгосон үйлдэлд дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй ба үндсэн эрхийг хязгаарласан гэх үндэслэлээр шүүхэд гомдол гаргах хууль зүйн боломж байхгүй. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7-д зааснаар шүүхэд гомдол гаргах үндэслэлд хамаарахгүй. Тиймээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарлаж буйг шүүхэд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх боломжгүй нөхцөл үүсжээ.

Европын Хүний эрхийн шүүхээс Туркийн засгийн газар болон Ахмет Илдрим (AHMET YILDIRIM v. TURKEY) нарын оролцогчтой хэргийг шийдвэрлэхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цахим хуудсанд хандах эрхийг зөвхөн тухайн хэрэгт шалгагдаж буй этгээдийн хувьд шүүгчийн захирамжийн дагуу хуульд заасан үндэслэлээр хязгаарлах боломжтой. Хандалтыг хаах арга хэмжээ авахдаа бусад этгээдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчих, хязгаарлах үр дагаврыг заавал харгалзан үзэх шаардлагыг тодорхойлсон. Мөн Европын Хүний эрхийн шүүхээс Орос Улсын засгийн газар болон Каблис (KABLIS v. RUSSIA) нарын оролцогчтой хэргийг шийдвэрлэхдээ цахим орчинд нийтлэл, цахим хуудасны хаягийг хаахдаа түүнд нийтэлж, илэрхийлсэн агуулга, үйл баримт нь ямар хуулийн заалтыг зөрчсөн болохыг нотолж, хууль бус болохыг шүүхийн шийдвэрээр тогтоолгүй зөвхөн прокурорын шийдвэрийг үндэслэсэн нь үндсэн эрхийг зөрчих үр дагаврыг үүсгэж байна гэж дүгнэсэн.

**Санал 4.**

Монгол Улсад прокурорын зөвшөөрлөөр аливаа цахим хуудас, хаяг, контентод хандах эрхийг хязгаарлаж, хааж буй тохиолдолд тухайн шийдвэрт шүүхийн журмаар гомдол гаргаж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг шүүхээр хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад хамрах хүрээг тодорхойлсон, хязгаарлалтад хамрах субъектэд хандаж, аль хуулийн заалтыг хэрхэн зөрчсөн талаар ойлгомжтой тодорхой тайлбарласан байх шаардлагыг баримтлах нь зүйтэй.

**Дүгнэлт 5.**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 7 дэх хэсэгт зааснаар (1) нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг цахим орчин дах олон нийтийн сүлжээгээр тараасан, (2) бүртгүүлээгүй цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, эсхүл бусдын нэр болон хуурамч хаяг ашигласан тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн цахим хуудасны Монгол Улс дах хандалтыг хаах, хязгаарлах арга хэмжээг авах эрхтэй байна.

Канад Улсын Сонгуулийн тухай хуулийн 91.1 дэх хэсэгт “Аливаа хүн, хуулийн этгээд нь сонгуулийн дүнд нөлөөлөх зорилгоор сонгуулийн хугацаанд нэр дэвшигчийн талаарх худал мэдээллийг тараахыг хориглоно.” гэх зохицуулалтаас “мэдсээр байж” гэх нөхцөлийг хассан байна. Тиймээс Үндсэн хуулийн нийтийн сангаас тухайн зохицуулалтыг үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж маргасан хэргийг Канад Улсын Дээд шүүхээс эцэслэн шийдвэрлэхдээ тухайн заалт нь хэт өргөн хүрээг хамаарсан, хүний эрхийг хамгийн багаар хязгаарлах зарчмыг зөрчсөн, мөн “худал гэдгийг мэдсээр байж” нийтлэх, “болгоомжгүй байдлаар” түгээх хоёр ялгаатай тул тодруулан хуульчлах шаардлагыг тодорхойлсон.

**Санал 5.**

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлд цахим хуудсыг хязгаарлах, хаах үндэслэлийг өргөн хүрээнд тодорхойлноос гадна, тухайн тохиолдлыг харгалзан үзэж нарийвчлан зохицуулаагүй байгааг өөрчлөх нь зүйтэй. Тухайлбал, тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасан “гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх” нөхцөлийг зөвхөн гутаан доромжилсон, эсхүл худал мэдээллийг агуулсан, эсхүл хоёр шаардлагыг нэгэн зэрэг хангасан тохиолдолд хэрэглэх зэргээр олон утгаар ойлгож, хэрэглэгдэхээр байна. Хуулийг хоёрдмол утгаар тайлбарлах боломж нэмэгдэх тусам үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах агуулга өргөн хүрээг хамаарч, улс төрийн зорилгоор хүний эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах эрхийн зөрчлийг үүсгэнэ. Тиймээс хязгаарлалтын агуулгыг нарийвчлан, тухайн тохиолдолд нийцүүлэн хүн бүрд ойлгомжтой байдлаар тодорхойлох шаардлагатай.

**Дүгнэлт 6.**

Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах шаардлагын хүрээнд хуулийн зорилгыг тодорхойлохын зэрэгцээ, хориглож буй мэдээлэл, контентын агуулга нь энгийн ойлгомжтой тодорхой байх, хоёрдмол агуулгагүй байх, эрх бүхий байгууллагаас хязгаарлалтын агуулгыг өргөн утгаар эсхүл өөрийн дур зоргоор тайлбарлахаас зайлсхийсэн байх урьдчилсан нөхцөлийг хангахаар байна.

АНУ-ын Дээд шүүхээс Умард Каролина мужийн захиргаа болон Пакингхам (Packingham v. North Carolina), Рено болон АНУ-ын Иргэний эрх чөлөөний холбоо (Reno v. Am.Civil Liberties Union) нарын оролцогчтой хэргүүдийг шийдвэрлэхдээ хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хэдий ч тухайн хязгаарлалт нь тохирсон буюу пропорциональ зарчимд нийцээгүй, тухайн тохиолдолд тохирсон байх шаардлагыг хангаагүй, тодорхой бус нэр томьёо ашиглаж, хэт өргөн хүрээнд хүний эрхийн хязгаарлалтыг тогтоосныг үндэслэлгүй гэж дүгнэсэн. Мөн Эстони Улсын Дээд шүүхээс сэтгүүлч Тармо Вахтер, Сулев Ведлер (Tarmo Vahter, Sulev Vedler) нарын хэргийг шийдвэрлэхдээ үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмын тэнцвэрт байдлыг хангаж, үндсэн эрхийг хязгаарласан прокурорын шийдвэр нь хууль ёсны зарчимд үндэслэгдсэн, тухайн зарчмын тайлбарлагдаж байх шалгуурыг тодорхойлсон.

**Санал 6.**

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан зохицуулалтыг боловсронгуй болгоход үндсэн эрхийг хязгаарлах нөхцөлийг тухайн тохиолдолтой уялдуулан хамгийн бага түвшинд тодорхойлох зарчмыг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Монгол хэл дээрх эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)
3. Иргэний болон улс төрийн тухай олон улсын пакт (1966)
4. Эрүүгийн хууль (2015 он)
5. Зөрчлийн тухай хууль (2017 он)
6. Зохиогчийн эрхийн тухай хууль (2021 он)
7. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2020)
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017 он)
9. Засгийн газрын 2013.01.05-ны өдрийн №1 дүгээр тогтоол., Цахим хуудас дах сэтгэгдлийн нэгдсэн системийн тухай., <https://legalinfo.mn/mn/detail/8939>.
10. Харилцаа холбооны зохицуулах хорооны Контентын үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам (2022 он)
11. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам (2020 он)
12. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.05.21-ний өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт., <https://legalinfo.mn/mn/detail?lawId=211149&showType=1>.
13. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020.04.29-ний өдрийн №23 дугаар тогтоолын хавсралт, "Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (интернэтийн үйлчилгээнд).  
[https://www.crc.gov.mn/storage/busad/nuhtsul%20shaardlag/2020\\_23\\_Togtool%20-%20%D0%98%D0%BD%D1%82%D0%B5%D1%80%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD%20%D2%AF%D0%B9%D0%BB%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B4%20\(1\).pdf](https://www.crc.gov.mn/storage/busad/nuhtsul%20shaardlag/2020_23_Togtool%20-%20%D0%98%D0%BD%D1%82%D0%B5%D1%80%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD%20%D2%AF%D0%B9%D0%BB%D0%B8%D0%BB%D0%B3%D1%8D%D1%8D%D0%BD%D0%B4%20(1).pdf)

14. “Эмнести интернэшнл”, “Аюулд өртөөд буй мэдэх эрх, үзэл бодлоо илэрхийлэн эрх чөлөө, олон улсын хандлага сургамж”  
Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө аюулд өртөөд ...Нээлттэй нийгэм форум <https://forum.mn> › uploads › users › files › 1\_ Ү...
15. Хууль зүйн Үндэсний хүрээлэн, Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал судалгааны тайлан, 2022 он, <https://sudalгаа.gov.mn/download/tsakhim-orchin-dakh-khniy-erkhiyn-erkhiyn-zrchil-xka>
16. “Глоб Интернэшнл төв” ТББ “Үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө” <https://legaldata.mn/buteel/pdf?id=717>
17. Харилцаа холбооны зохицуулах хорооноос [zarig.mn](http://zarig.mn) цахим хуудсыг хаасантай холбогдуулан хийсэн мэдэгдэл, 2023.12.02. <https://news.mn/r/2689489/>
18. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн., Үндсэн хууль манай сургуульд: НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр., Улаанбаатар., хуудас 137. 2022. <https://cli.num.edu.mn/content/Undsen%20manai%20surguulid%202022.pdf>
19. ХЭҮК-ын Монгол улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дах илтгэл., 2018., хуудас 208., <https://lib4u.net/ebook/?id=80&lib=nhrс>
20. Монцамэ, <https://montsame.mn/mn/read/312089ь>
21. Хэвлэл мэдээллийн зөвлөл, “Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим”, <https://www.mediacouncil.mn/p/7>
22. Харилцаа холбооны зохицуулах хороо., Цахим орчны зохицуулалт (зөвлөмж)., 2021., <https://crc.gov.mn/storage/1.2%20%D0%A6%D0%B0%D1%85%D0%B8%D0%BC%20%D0%BE%D1%80%D1%87%D0%BD%D1%8B%20%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BC%D0%B6.pdf>
23. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх., Шүүхийн шийдвэрийн тойм: Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Сувд-Эрдэнэ., 2023.12.01.
24. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан ([shuukh.mn](http://shuukh.mn))
25. Нээлттэй Нийгэм Форум, Хууль зүйн мэдээлэл, судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг., “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик”, УБ., 2021. [https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformatiоn%20Crime\\_Web%20version.pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformatiоn%20Crime_Web%20version.pdf)

26. Нээлттэй Нийгэм Форум, Хуулийн Шүүмж, Монгол Улсын Нийгмийн Сүлжээний Хууль, Цуврал №41, 2023 оны 3 дугаар сар.

**Гадаад хэл дээрх эх сурвалжийн жагсаалт:**

1. United Nations, Human Rights Committee, General comment No.34, Article 19: Freedoms of opinion and expression, International Covenant on Civil and Political Rights, 2011. <https://www2.ohchr.org/english/bodies/hrc/docs/gc34.pdf>
2. United Nations, General Assembly, Resolution adopted on December 16, 2020, No.75/176, "The right to privacy in the digital age" <https://digitallibrary.un.org/record/3896430?ln=en&v=pdf#files>.
3. НҮБ-ын Хүний эрхийн хорооны Benhanj v. Algeria, 1173/2003 дугаартай гомдолд холбогдох 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дүгнэлт., "...With regard to the alleged violation of article 19, the Committee recalls that the freedoms of information and expression are cornerstones in any free and democratic society...", [https://www.worldcourts.com/hrc/eng/decisions/2007.07.20\\_Benhadj\\_v\\_Algeria.htm.](https://www.worldcourts.com/hrc/eng/decisions/2007.07.20_Benhadj_v_Algeria.htm.),
4. European Union human rights guideline on freedom of expression: online and offline, 20
5. [https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu\\_human\\_rights\\_guidelines\\_on\\_freedom\\_of\\_expression\\_online\\_and\\_offline\\_en.pdf](https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu_human_rights_guidelines_on_freedom_of_expression_online_and_offline_en.pdf)
6. UN, Human Rights Council., Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression, Frank La Rue., 2013.04.17., [https://www.ohchr.org/sites/default/files/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session23/A.HRC.23.40\\_EN.pdf](https://www.ohchr.org/sites/default/files/Documents/HRBodies/HRCouncil/RegularSession/Session23/A.HRC.23.40_EN.pdf)
7. Bills of Rights, 1689. <https://www.parliament.uk/about/living-heritage/evolutionofparliament/parliamentaryauthority/revolution/collections1/collections-glorious-revolution/billofrights/#:~:text=It%20is%20an%20original%20Act,known%20today%20as%20Parliamentary%20Privilege.>
8. Declaration of Rights of Man and Citizen., 1791., 11. The free communication of ideas and opinions is one of the most precious rights of man. Every citizen can therefore speak, write and print freely, subject to responsibility for the abuse of this freedom in cases as determined by law. <https://www.justice.gc.ca/eng/rp-pr/csj-sjc/ilp-pji/rev5/index.html#:~:text=Men%20are%20born%20free%20and,security%20and%20resistance%20to%20oppression.>

9. Joint declaration on freedom of expression and the internet, 2011.06.01  
<https://www.osce.org/files/f/documents/e/9/78309.pdf>,
10. Council of Europe., Legal instruments., Recommendation CM/REC 13 (2022),  
The Impacts of Digital Technologies on Freedom of Expression., <https://edoc.coe.int/en/international-law/11101-the-impacts-of-digital-technologies-on-freedom-of-expression-recommendation-cmrec202213.html>.
11. Aaron minc “22 Free Tools & Tips to Identify an Anonymous Online Defamer”  
2024 <https://www.minclaw.com/free-tools-tips-find-anonymous-online-defamer/>
12. Joint declaration on Freedom of expression and the Internet., Jun 11, 2011.,  
<https://www.osce.org/files/f/documents/e/9/78309.pdf>,
13. Joint declaration on Challenges to Freedom of expression in the next decade.,  
Jul 10, 2019., <https://www.osce.org/files/f/documents/9/c/425282.pdf>,
14. Council of European Union “EU human rights guidelines on freedom of  
expression online and offline”
15. [https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu\\_human\\_rights\\_guidelines\\_on\\_freedom\\_of\\_expression\\_online\\_and\\_offline\\_en.pdf](https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu_human_rights_guidelines_on_freedom_of_expression_online_and_offline_en.pdf)
16. Information Society services codification, 2015 <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32015L1535>
17. EUR-lex “Digital services act” <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32022R2065&qid=1719385637751>
18. The Constitution of the Republic of Estonia, (1992),  
<https://www.riigiteataja.ee/en/eli/521052015001/consolide>
19. Republic of Estonia, Ministry of Economic Affairs And Communication,  
“Estonia’s Digital Agenda 2030”, 2021., <https://digital-skills-jobs.europa.eu/en/actions/national-initiatives/national-strategies/estonia-estonian-digital-agenda-2030>,
20. Federal Ministry of Justice website “Basic Law for the Federal Republic of  
Germany” [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_gg/englisch\\_gg.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/englisch_gg.html)
21. Federal Ministry of Justice website “Network Enforcement Act” [https://www.gesetze-im-internet.de/netzdg/\\_1.html](https://www.gesetze-im-internet.de/netzdg/_1.html)
22. Germany “Digital service act” (DDG) <https://www.gesetze-im-internet.de/ddg/BJNR0950B0024.html>

23. Reno v. ACLU, 521 The U.S. Supreme Court, 844 (1997), <https://supreme.justia.com/cases/federal/us/521/844/#tab-opinion-1960201>, brief analysis: <https://www.oyez.org/cases/1996/96-511>
24. Danielle K. Citron, Neil Richards, “Four Principles for Digital Expression” 2018, p.1358, [https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty\\_scholarship](https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty_scholarship)
25. (1) Columbia university., Global Freedom of Expression., “Internet shutdowns in international law”, 2023., [https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/07/GFoE\\_Internet-shutdowns-in-international-law.pdf](https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/07/GFoE_Internet-shutdowns-in-international-law.pdf).,
26. (2) UN., Human Rights Council., Report of the Office of the United Nations High Commissioner for Human Rights., “Internet shutdowns: trends, causes, legal implications and impacts on a range of human rights”., May 13, 2023., para 11.,  
<https://documents.un.org/doc/undoc/gen/g22/341/55/pdf/g2234155.pdf?token=4Dag4l19xSuQgZwd96&fe=true>.,
27. (3) Council of Europe., Recommendation CM/Rec(2016) of the Committee of Ministers to member States on Internet freedom (Adopted by the Committee of Ministers on 13 April 2016 at the 1253rd meetings of the Ministers’ Deputies).,  
[https://search.coe.int/cm#{%22CoEIdentifier%22:\[%2209000016806415fa%22\],%22sort%22:\[%22CoEValidationDate%20Descending%22\]}](https://search.coe.int/cm#{%22CoEIdentifier%22:[%2209000016806415fa%22],%22sort%22:[%22CoEValidationDate%20Descending%22]}).,
28. Freedom of opinion and expression : resolution adopted by the Human Rights Council on 8 July 2022., <https://digitallibrary.un.org/record/3985686?ln=ru&v=pdf>.,
29. Freedom Online Coalition., Program of Action 2022., “Digital inclusion: A democratic and human rights-based vision for the digital age”., [https://freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2022/01/FOC\\_ProgramofAction\\_2022\\_ENG.pdf](https://freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2022/01/FOC_ProgramofAction_2022_ENG.pdf).,
30. FOC Joint Statement on Freedom of Expression Online Presented at the 47th Session of the United Nations Human Rights Council., July 2021., <https://freedomonlinecoalition.com/wp-content/uploads/2021/07/FOC-Joint-Statement-on-Freedom-of-Expression-Online-Presented-at-the-47th-Session-of-the-United-Nations-Human-Rights-Council.pdf>.,
31. European convention on human rights, Article 10.2  
[https://www.echr.coe.int/documents/d/echr/convention\\_ENG](https://www.echr.coe.int/documents/d/echr/convention_ENG)



32. European Union human rights guidelines on freedom of expression: online and offline, 22, 31  
[https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu\\_human\\_rights\\_guidelines\\_on\\_freedom\\_of\\_expression\\_online\\_and\\_offline\\_en.pdf](https://www.eeas.europa.eu/sites/default/files/eu_human_rights_guidelines_on_freedom_of_expression_online_and_offline_en.pdf) Penal Code of Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide>
33. Act to Regulate Dissemination of Works which Contain Pornography or Promote Violence or Cruelty in Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/520012015009/consolide>
34. *Elonis v. United States*, 575 U.S. 723 (2015)., <https://firstamendment.mtsu.edu/article/elonis-v-united-states/> , Facts and Case Summary,<https://www.uscourts.gov/educational-resources/educational-activities/facts-and-case-summary-elonis-v-us>
35. *Miller v. California* (1973), <https://firstamendment.mtsu.edu/article/miller-v-california/>
36. Miller test, <https://firstamendment.mtsu.edu/article/miller-test/>
37. *New York Times v. Sullivan* (1964), <https://www.oyez.org/cases/1963/39>
38. *Chaplinsky v. New Hampshire*, 315 U.S. 568 (1942) <https://supreme.justia.com/cases/federal/us/315/568/>
39. Фэйсбүүк community standards  
<https://transparency.Мета.com/ru-ru/policies/community-standards/?source=https%3A%2F%2Fwww.Фэйсбүүк.com%2Fcommunitystandards>
40. The Consumer Protection and Technical Regulatory Authority, Эстониор Tarbijakaitse ja Tehnilise Jdrelevalve Amet (TTJA)
41. CBC., Social media users voiced fears about election manipulation during 2019 campaign, says Elections Canada., <https://www.cbc.ca/news/politics/elections-canada-social-media-monitoring-findings-1.5444268.>,
42. Official website of European Court of Human Rights  
<https://hudoc.echr.coe.int/eng?i=001-115705>
43. Official website of European Court of Human Rights  
<https://hudoc.echr.coe.int/eng?i=001-192769>
44. European Convention on Human Rights, ECHR, <https://www.legal-tools.org/doc/8267cb/pdf/>
45. European Court of Human Rights: CASE OF KALDA v. ESTONIA <https://hudoc.echr.coe.int/eng?i=001-160270>

46. Эстони Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан Riigi Teataja, <https://www.riigiteataja.ee/en/>
47. Европын хүний эрхийн шүүхийн цахим мэдээллийн сан., <https://www.echr.coe.int/>
48. Эстони Улсын Дээд шүүхийн 2007 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 3-3-1-20-07 дугаартай шийдвэр. <https://www.riigiteataja.ee/kohtulahendid/detailid.html?id=206128058>
49. Эстони Улсын Дээд шүүхийн 2009 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 3-3-1-5-09 дугаартай шийдвэр. <https://www.riigiteataja.ee/kohtulahendid/fail.html?fid=206098432>
50. Перну мужийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2005 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 3-156/2005 дугаар шийдвэр
51. Эстони Улсын Хорих тухай хууль (2000), Imprisonment Act in Estonia, <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/504112013005/consolide>
52. Canadian Constitution Foundation v. Attorney General of Canada., <https://globalfreedomofexpression.columbia.edu/cases/canadian-constitution-foundation-v-attorney-general-of-canada/>
53. Canada Elections Act, SC 2000, с 9., <https://qweri.lexum.com/w/calegis/sc-2000-c-9-en#!fragment/sec91/BQCwhgzIBcwMYgK4DsDWszlQewE4BUBTADwBdoJC4BOARgEoAaZbUwiARUUNwE9oA5AMaUwuBFx78hlwmlQBIPKQBC-AEoBRADKaAagEEAcgGFNjUmABG0Utjj16QA>
54. <https://theccf.ca/about-us/>
55. Unesco: Manuel de formation mondial pour les agents des forces de l'ordre., pp 15, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000385099/PDF/385099fre.pdf.multi>
56. Statista, Number of internet and social media users worldwide as of April 2024 <https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide/>.
57. David Konstan., The Two Faces of Parrhesia: Free Speech and Self-Expression in Ancient Greece., 2015. [https://www.researchgate.net/publication/289879205\\_The\\_Two\\_Faces\\_of\\_Parrhesia\\_Free\\_Speech\\_and\\_Self-Expression\\_in\\_Ancient\\_Greece](https://www.researchgate.net/publication/289879205_The_Two_Faces_of_Parrhesia_Free_Speech_and_Self-Expression_in_Ancient_Greece).
58. Wolfgang Benedek, Matthias C. Kettemann., "Freedom of expression and the internet", 2013. p.24 <https://rm.coe.int/prems-167417-gbr-1201-freedom-of-expression-on-internet-web-16x24/1680984eae>.

59. Jack M Balkin (2004). How Rights Change: Freedom of Speech in the Digital Era, [https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/1734/How\\_Rights\\_Change\\_Freedom\\_of\\_Speech\\_in\\_the\\_Digital\\_Era.pdf?sequence=2](https://openyls.law.yale.edu/bitstream/handle/20.500.13051/1734/How_Rights_Change_Freedom_of_Speech_in_the_Digital_Era.pdf?sequence=2)
60. Cass Sunstein “Does AI have the right to freedom of speech?” , 2024 <https://law.queensu.ca/news/Does-AI-have-the-right-to-freedom-of-speech>
61. Gene Policinski, “Does ChatGPT Have the Right to Free Speech?” <https://www.freedomforum.org/does-chatgpt-have-the-right-to-free-speech/>
62. Simon McCarthy-Jones, “Does AI have a right to free speech? Only if it supports our right to free thought”, 2023., <https://theconversation.com/does-ai-have-a-right-to-free-speech-only-if-it-supports-our-right-to-free-thought-212555>
63. Dirk Voorhoof “Freedom of Expression in the Digital Environment: How the European Court of Human Rights has Contributed to the Protection of the Right to Freedom of Expression and Information on the Internet” 2023 <https://globalfreedomofexpression.columbia.edu/wp-content/uploads/2023/10/VOORHOOF.FOEDigitalEnvironment.BookElgar.SEPT22.pdf>
64. Freedom House “Freedom on the net report: Germany 2023” <https://freedomhouse.org/country/germany/freedom-net/2023>
65. Danielle K. Citron, Neil Richards, “Four Principles for Digital Expression” 2018, pp.1357, [https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty\\_scholarship](https://scholarship.law.bu.edu/cgi/viewcontent.cgi?article=1624&context=faculty_scholarship)
66. “Freedom of Expression: A Comparative Summary of United States and European Law”, 2019, p.4 [https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN\\_ID4563882\\_code1452677.pdf?abstractid=4563882&mirid=1&type=2](https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN_ID4563882_code1452677.pdf?abstractid=4563882&mirid=1&type=2)
67. Comparative study on blocking, filtering and take-down of illegal internet content, pp.193, <https://rm.coe.int/CoERMPublicCommonSearchServices/DisplayDCTMContent?documentId=090000168065497e>
68. Jakob Juksaar, “Ajakirjandusvabaduse piiramine kriminaalmenetluse huvide kaitsmiseks eesti vabariigi ja saksamaa liitvabariigi vxrdluses”, Магистрын ажил, <https://dspace.ut.ee/server/api/core/bitstreams/1d7c329d-6ac5-4569-a8d1-cf2c56de0410/content>